

## **СҮМБЭР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **Нэгдүгээр бүлэг. СУМЫН БАЙГАЛЬ, ЦАГ УУР, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ**

#### **1.1. Сумын тухай ерөнхий ойлголт**

Улсын Бага Хурлын 1931 оны 5 дугаар тогтоолоор хошуудыг татан буулгаж, 13 аймгийг шинээр байгуулахад Оцол сансар уулын хошууны нутаг Хэнтий, Төв, Дорноговь аймагт хуваагдахад Төв аймгийн Говьсүмбэр (одоогийн Сүмбэр) сум байгуулагджээ. Тус сум 1931-1956 онд буюу 25 жил Төв аймгийн 1956-1991 онд буюу 35 жил Дорноговь аймгийн харьяалалд байжээ. Улсын Бага хурлын 1991 оны 6-р сарын 21-ний өдрийн 46 дугаар тогтоолын дагуу Дорноговь аймгийн Сүмбэр сум, Шивээговь хороо, Улаанбаатар хотын харьяанд байсан Баянтал хороог нэгтгэж, Сүмбэр сумын хилийн цэс дотор Чойр хотыг 1991 оны 8 дугаар сард шинээр байгуулжээ.

Сүмбэр сум нь Улаанбаатар хот, БНХАУ болон ОХУ-тай засмал зам болон төмөр зам, шилэн кабелиар холбогдсон нь орчин үеийн холбоо мэдээллийн салбарын дэвшилтэт технологийг ашиглах бололцоотой бөгөөд мөн байнгын эрчим хүчний системд холбогдсон дэд бүтэц сайн хөгжсөн сум юм.

#### **1.2. Байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөл**

##### **1.2.1. Газрын гадарга**

Тус сумын нутаг дэвсгэр нь физик газарзүйн мужлалаар төв азийн заримдаг цөл, цөлийн их муж, Дорнод говийн мужид хамаарагдах ба нутгийн зарим хэсэг нь говь, хээрийн завсрын бүсэд ордог. Газрын гадаргын ихэнх хэсэг нь харьцангуй өндөрлөг, толгодорхог тэгш тал бөгөөд бусад хэсэгтээ дундаж өндөрлөгтэй бэсрэг уулс тохиолдоно.

##### **1.2.2. Ус зүй**

Сүмбэр сум нь усан хангамжын хувьд хангалттай биш, цөөн тооны булаг шанд горхи нь ундрага багатай.

Сумын хэмжээнд тал хээрийн бүсэд хамаарагдах ба жилийн турш байнга устай байдаг тоотой хэдэн нуураас өөр гадаргын усны сүлжээ байхгүй юм. Хаврын шар ус, зуны борооны үеэр түр зуурын урсгал ус үүсч улмаар ширгэж алга болдог байна. Иймд сумын ихэнх нутгийн хэмжээнд түр зуурын урсгал усны гольдролууд ялгагдана. Байнгын урсгалтай гол горхи, нуур талбайн болон орчны хэмжээнд гадаргуугийн усан сүлжээгүй, зөвхөн ухаа гүвээт талын хонхор, хотгоруудад ширгэдэг. жижиг нуур, тогтоол ус /тойром/ тохиолддог.

### **1.2.3. Уур амьсгалын нөхцөл**

Сүмбэр сум нь ерөнхийдөө халуувтар зунтай хуурайвтар мужуудад багтана. Энэ мужид зуны улирлын идэвхитэй температурын нийлбэр 2000-2500°, чийг дулааны коэффициент 0.5-1.0 байна. Энэ мужид ургамлын өсөж хөгжих үе нь 110-120 хоног, жилд 120-270 мм тунадас унадаг байна.

Өвлийн улирал нь харьцангуй богино боловч дулаавтар, хавар, намар нь бусад улирлаас урт, хаврын улиралд хүчтэй шороон шуурга нилээд ажиглагдаж, зун халуун хуурай, хур тунадас бага унадаг онцлогтой байна. Уур амьсгал нь халуун хуурайгаас болж усалгаагүй тариалан эрхлэхэд тохиромжгүй юм. Ус багатай булаг шандаас өөр гол мөрөн цэнгэг уст нуур байхгүй боловч зуншлага сайн үед булаг шанд, тойром нилээд элбэгшинэ.

1-р сарын агаарын дундаж температур нь -20-22 хэм хүйтэн, 7-р сард агаарын дундаж температур +29 хэм орчим байдаг. Жилийн 1-6 хоногт 30 хэмээс дээш дулаарах идэвхитэй агаарын хэмийн нийлбэр нь 2200 хэмээс бага байдаг. Анхны цочир хүйтрэлт 9 дүгээр сарын эхний арван хоногийн сүүлчээр, эцсийн цочир хүйтрэл 5 дугаар сарын эцсээр дуусна.

Чийг хангамжийн коэффициентийн олон жилийн дундаж 0,8 байна. Цасан бүрхүүлтэй хонгийн тоо 24-69, цасан бүрхүүлийн зузаан 2-4см хүрнэ. Зарим жилд цасан бүрхүүл тогтохгүй хараар өвөлжих нь бий. Энэ мужид салхины дундаж хурд 3-4.4м/с, голчлон баруун, баруун хойт зүгээс салхилна. Жилдээ 17-33 өдөр шороон шуургатай 3.5-7.5 өдөр цасан шуургатай.

Сүүлийн жилүүдэд цаг уурын огцом өөрчлөлт хуурайшлын нөлөөгөөр ган гачгийн давтамж нэмэгдэж 7, 8 дугаар сард үргэлжилсэн халуун болж зарим үед 36-40 хэм хүрч халдаг.

### **1.2.4. Хөрс, хөрсөн бүрхэвч**

Хөрсний үржил шим, шинж төлөв, төрөл, тархалт нь газар тариалан хадлан бэлчээр мал аж ахуй эрхлэх байршуулах үндсэн хүчин зүйл болдог.

Говьсүмбэр аймагт 1989 онд хийгдсэн хөрсний судалгаанаас үзэхэд хүрэн хөрсний төрөл нилээд тархацтай байна. Хүрэн хөрс нь ялзмагийн агууламж, үржил шимийн байдлаараа харилцан адилгүй шинж чанартай байна.

## **I. Уулын хөрс**

### **1. Уулын хүрэн хөрс**

Энэ хөрсний бүлэгт уулын сулавтар хөгжилтэй хүрэн хөрс, толгодын хүрэн хөрсний дүрсүүдийг хамруулан үзсэн байна. Хүрэн хөрсний төрлүүд нь тус аймгийн бэсрэг уулс, толгодорхог газраар тархсан.

1-а Уулын сулавтар хөгжилтэй хөнгөн шавранцар хүрэн хөрс: Энэ хөрс нь бэсрэг уулархаг газраар бүрдэл байдлаар тархах бөгөөд морфологи шинж нь ялзмагт үе нимгэн /4-6см орчим/, хэврэг бүтэцтэй, ихэнх тохиолдолд хөнгөн шавранцар, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна. Шим тэжээлийн элементийн хангамж дунд зэрэг, ялзмагийн агуулалт 0.8-1.2%, ус нэвчүүлэлт сайн, барих чадвар сул. Хөрс нь хэврэг бүтэцтэй, үндэсний тархалт бага тул ус салхины эвдрэл, элэгдлийн нөлөөнд эмзэг. Уулын сулавтар хөгжилтэй хөнгөн шавранцар хүрэн хөрсөнд хялгана, ерхөг, боролзой, агь зонхилон тачир сийрэг ургадаг.

### **2. Толгодын хүрэн хөрс**

Говьсүмбэр аймгийн нутгаар дангаараа болон бүрдэл байдлаар тархсан. Толгодын сулавтар хөгжилтэй элсэнцэр хүрэн хөрсийг энд хамруулдаг. Морфологи шинжийн хувьд ялзмагт үеийн зузаан 8-23 см-ийн хооронд хэлбэлзэж дунджаар 16 см байна. Шим тэжээлийн элементийн хангамж дунд зэрэг, ялзмагийн агуулалт 1.3-1.9%, ус нэвчүүлэлт сайн, барих чадвар сул. Толгодын сулавтар хөгжилтэй хөнгөн шавранцар, элсэнцэр хөрстэй газарт хялгана, ерхөг, хазаар өвс, агь зонхилон ургана.

## **II. Тал хөндийн хөрс**

Энэ бүлгийн хөрсний үүсэх нөхцөл нь зун нь халуун, өвөл нь хүйтэн, хур тунадас харьцангуй бага, салхины нөлөө ихтэй, эх газрын эрс тэс, хуурайвтар уур амьсгалын нөхцөлд хялгана, хазаар өвс, хиаг, дааган сүүл, ерхөг, агь, шарилж, таана, хөмүүл, дэрс зэрэг үетэн, алаг өвс, бутлаг ургамлын доор гол төлөв делювийн сийрэгдүү хөвсгөр хурдас дээр үүсэж тогтож, 1150-1300 м өндөрт гүвээрхэг хуурай хээрт нилээд өргөн дэлгэр тархжээ.

### **1. Дунд зэргийн зузаан хүрэн хөрс**

Энэ төрлийн хөрс нь бэсрэг уулс, ухаа-гүвээт толгодын хоорондох өргөн, нарийн хөндий, ам хоолой, тал газар зэрэг тэгшивтэр гадаргад нилээд хэмжээгээр тархаж, нийтдээ

237.4 мян.га талбайг эзэлнэ. Энэ хөрсний гол ялгаа нь гэвэл ялзмагт үеийн зузаан 13-22 см хооронд хэлбэлзэж байдагт оршино.

1-а. Дунд зэргийн зузаан дунд шавранцар хүрэн хөрс: Энэ төрлийн хөрс нь тус аймгийн нутагт тэгшивтэр хотгордуухан нам газруудаар багахан хэмжээгээр тархаж нийтдээ 67.02 мян.га талбайг эзэлнэ.

Ялзмагт үеийн давхаргын зузаан нь дунджаар 31 см, хэлбэлзэл нь 28-33 см байна. Ялзмагийн хэмжээ 2-3.5%, ерөнхий азот 0.14-0.20%, 100 гр хөрсөнд шингээгдсэн сууриудын нийлбэр 20.4-24.5 мг/экв, хөдөлгөөнт фосфор 1.2-2.6 мг, солилцох кали 9.8-12.1 мг орчим байна. Дунд шавранцар хүрэн хөрс нь тал хөндийн хүрэн хөрсний дотроос үржил шимт чанарын хувьд хамгийн сайн чанарын хөрсөнд тооцогдож хадлан бэлчээрээс гадна газар тариаланд ашиглах боломжтой.

1-б. Дунд зэргийн зузаан хөнгөн шавранцар хүрэн хөрс: Энэ төрлийн хөрс нь бэсрэг уул, толгодын хоорондох өргөн, нарийн хөндий, ам хоолойнууд зэрэг тэгшивтэр гадаргад нилээд өргөн тархаж тархаж нийтдээ 144.2 мян.га талбайг эзэлнэ. Агуулагдах ялзмагийн хэмжээ 0.8-3.1%-н хооронд хэлбэлзэж, дунджаар 2%, ерөнхий азот 0.05-0.23% буюу 0.14%, 100 гр хөрсөнд шингээгдсэн сууриудын нийлбэр 20.7мг/экв, хөдөлгөөнт фосфор дунджаар 1.7 мг, кали 3.5-18.1 мг орчим байна. Хөнгөн шавранцар хүрэн хөрс нь үржил шимт чанарын хувьд нилээд сайн чанарын хөрсөнд тооцогдоно.

1-в. Дунд зэргийн зузаан элсэнцэр хүрэн хөрс: Энэ төрлийн хөрс нь аймгийн нутгийн тэгшивтэр гадаргад тархаж нийтдээ 26.2 мян.га талбайг эзэлнэ. Сумын төвөөс зүүн тийш 3 км-ийн зайтай хялгана, хазаар, хиаг, агь, шарилж, харгана зэрэг ургамлын нөмрөгтэй ухаархаг тал газрыг төмөр /Оросын цэргийн анги байхад булсан/ авах зорилгоор ухсан байна.

Ялзмагийн агууламж 1.4-2.5%-н хооронд хэлбэлзэж, дунджаар 2.1%, ерөнхий азот 0.03-0.15% буюу дунджаар 0.09%, 100 гр хөрсөнд шингээгдсэн сууриудын нийлбэр дунджаар 18.2мг/экв, хөдөлгөөнт фосфор 0.8-1.8 мг-ийн хооронд хэлбэлзэж, дундаж нь 1.2 мг, кали 4.3-13.9 мг буюу дунджаар 9.8 мг орчим байна.

## **2. Нимгэн хүрэн хөрс**

Энэ төрлийн хөрс нь дунд зэргийн зузаан хүрэн хөрсний нэг адил намхан бэсрэг, уулс ухаа гүвээт толгодын хоорондох хөндий, ам хоолойнууд болон өргөвтөр тал газар зэрэг тэгшивтэр гадаргад нилээд хэмжээгээр тархаж нийтдээ 181.54 мян.га талбайг эзэлнэ. Нимгэн хүрэн хөрсний гол онцлог нь ялзмагт үеийн зузаан 10-20 см хүртэл байдагт оршино.

2-а. Нимгэн хөнгөн шавранцар хүрэн хөрс: Энэ төрлийн хөрс нь бэсрэг уулс, ухаа гүвээт толгодын хоорондох хөндийнүүд ба зарим газраа бага зэрэг ухаархаг, долгиорхог гадаргатай, тал газруудаар тархаж, нийтдээ 74.2 мян.га талбайг эзэлнэ.

Энэ зүсэлтийг сумын төвөөс урагш 7 км-ийн зайтай хялгана, хазаар, хиаг, ерхөг, агь, цахилдаг өвс, хаяа харгана зэрэг үет алаг өвс зонхилсон ургамлын нөмрөгтэй тэвшивтэр тал газар хийсэн байна. Дээд давхаргад агуулагдах ялзмагийн хэмжээ 1.3-2.8%-н хооронд хэлбэлзэж, дунджаар 1.9%, ерөнхий азот 0.08-0.30% буюу дунджаар 0.16%, 100 гр хөрсөнд шингээгдсэн сууриудын нийлбэр дунджаар 22.5 мг/экв, хөдөлгөөнт фосфор 1.7 мг, кали 10 мг орчим байна.

2-б. Нимгэн элсэнцэр хүрэн хөрс: тус сумын нутагт нилээд хэмжээгээр тархаж, нийт 120 мян.га талбайг эзэлдэг байна. Ялзмагийн давхаргад агуулагдах ялзмагийн хэмжээ 0.5-2%-н хооронд хэлбэлзэж, дунджаар 1.1%, ерөнхий азот 0.06-0.08% буюу дунджаар 0.07%, хөдөлгөөнт фосфор 0.8-1.2 мг-н хооронд хэлбэлзэж дундаж нь 1 мг, кали 6-23.2 мг-ийн хооронд хэлбэлзэж дунджаар 14.5 мг орчим, механик бүрэлдэхүүнд шаврын эзлэх хувь 11.2-19.2%-ийн хооронд хэлбэлзэж, дунджаар 16.2% байгаа нь хөрс элсэнцэр болохыг харуулж байна.

### **3. Нугын хүрэн хөрс**

Нугын хүрэн хөрс тус сумын уулсын хоорондох хөндийн чийглэг хотгорууд, нам газраар нийт бүрдлийн хамт 25.2 мян.га талбайг эзэлнэ.

3-а Нугын мараалаг дунд шавранцар хүрэн хөрс: Уг хөрс нь Говьсүмбэр сумын нутагт нийт 16.8 мян.га талбайд тархсан байна. 100 гр хөрсөнд агуулагдах шингээгдсэн сууриудын нийлбэр 37.4 мг/экв, хөдөлгөөнт фосфор 1.6-1.8 мг, солилцох кали 8-17.4 мг болно.

### **4. Аллювийн нугын, дунд шавранцар карбонатлаг хөрс**

Аллювийн нугын хөрс, Хэрлэн голын дагуу 2.6 мян/га-д тархана. Аллювийн хөрсийг үүсч, хөгжихөд усны нөлөөгөөр үе давхрагууд нь бие биенээсээ ялгаран үелсэн байдалтай тогтоно.

Ялзмагт үедээ 3.1% ялзмагтай, ерөнхий азот 0.16% хөрсний орчим РН 7.7 буюу сул шүлтлэг орчинтой, харин 100 гр хөрсөнд агуулагдах хөдөлгөөнт фосфор кг шороонд 1 мг, солилцох кали 5.3 мг байгаа нь тухайн хөрс байгалийн үржил шимээр төдийлөн сайнгүй. Судалгааны ажлаас дүгнэж үзэхэд аллювийн нугын карбонатлаг хөрс нь зөвхөн бэлчээрийн эдэлбэрт ашиглагдах боломжтой гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

### 1.2.5. Ургамалжилт

Сүмбэр сумын нутаг дэвсгэр нь ургамал газарзүйн мужлалаар Евразийн хээрийн мужийн Дундад-Халхын хээр, Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарна. /Н.Өлзийхутаг, А.А.Юнатов /

Нутгийн баруун, баруун урд хэсэгт ихэнхдээ хялгана, хазаар, харгана зэрэг ургамал зонхилсон, нам хотос тааралдах бөгөөд хуурай хээрийн тал хөндийнүүд хосолсон ухаа, гүвээ толгодууд дайралдана.

Нутгийн зүүн, зүүн хойд талаараа 1500-1700 м өндөрлөгтэй Их, Бага уул, Сансар уул, Сүмбэр уул, Өндөр улаан, Алаг өндөр уул зэрэг бэсрэг уулсууд тааралдана. Энд хялгана, хазаар, хиаг, ерхөг зэрэг үет ургамал, агь, гол гэсэр, навтуул, шарилж, таана зэрэг алаг өвс зонхилно.

Цөлөрхөг хээр тархсан нутгаар нь шар, бор бударган, гашуун банздоо, манан хамхаг, бор шаваг, таана, үмхий өвс, дэрс зэрэг ургамал зонхилон ургана. Ус чийг дутагдалтай талхлагдсан газраар шарилж, хамхуул, лууль, агь зэрэг хуурай нөхцөлд тэсвэртэй ургамлууд нилээд тохиолдоно.

Уулын эх чулуулагтай нам уулсаар хээрийн ургамалжил нилээд түрэн ургадаг бөгөөд энд шивээт хялгана, саман ерхөг, дэрвээн хазаар өвс, агь, үхэр ба нарийн навчит харгана ургана.

Бэсрэг ба нам уулархаг газруудаараа хялган-хазаар өвст, хазаар-хялганат, үетэн-агь-шавагт төрөл тархана. Мөн сумын төв орчим, Гашуун тойром, Зараагийн хоолой, Улаан нуурын хөндийгөөр хялгана-хазаар-шарилжит, шарилж-хялганат, хялгана-үетэн-агьт, талхлагдсан бэлчээрийн төрөл тохиолдоно.

Нугын нам хотсын давсархаг нугаар Өндөр толгой, Хулгар, Өгөөмрийн гол, Шар бүрд, Өвдөгийн худаг орчмын газраар гялгар дэрс, мөлхөө хиаг, монгол улаан толгой, ширэг улалж, зэрлэг арвай, галуун гичгэнэ, цахилдаг, таван салаа зэрэг ургамлууд ургана.

Нийт 367.3 мян.га бэлчээрээс 95.4 мян.га буюу 26% чулуутай, 159.9 мян.га буюу 43.5 % сөөгтэй, 63.2 мян.га буюу 17.2% довонтой, 48.7 мян.га буюу 13.2% цэвэр бэлчээр, хад асга 147 га байна.

Сүүлийн жилүүдэд ган гачиг, малын бэлчээрийн давтагдлын нөлөөгөөр бэлчээрийн ургамалын зүйлийн бүрэлдэхүүн ядуурч ургац улам бүр тачир сийрэг болж байгаа нь ажиглагдаж байна. Ялангуяа булаг шанд худгийн орчин тойрны бэлчээр ихээхэн давтагдаж элэгдэлд нэрвэгдэн цэгэн цөлшлийн голомт үүсвэр болж байна.

### 1.2.6. Ан амьтан

Мөлхөгчдөөс зөвхөн цоохор хонин гүрвэл, бамбай хоншоорт могой бүртгэгдсэн байна. Цоохор хонин гүрвэл өндөрлөг ухаа толгод, Чойрын Богд уулс зэрэг газруудад ховор таарах бол харин харгана, дэрс зэрэг бутлаг ургамалтай нам дор, хотос газраар олон тааралдана. Бамбай хоншоорт могой Чойрын Богд уулсаар тархалттай.

Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт нийт 86 зүйлийн шувууг бүртгэв. Бүртгэгдсэн шувуудаас 20 зүйл нь суурин амьдралтай, 25 зүйл нь нүүдлийн үрждэг, 41 зүйл нь нүүдлийн үедээ түр саатан, дайран өнгөрдөг, мөн 46 зүйл нь ус намгийн шувууд байна.

Суурин шувууд болон нүүдлийн үрждэг шувууд нийлээд 45 зүйлийн шувуу аймгийн нутаг дэвсгэрт үрждэг. Суурин шувуудаас хамгийн өргөн тархалттай, ердийн тохиолдох зүйлүүд нь шоорон эвэрт болжмор, монгол болжмор, хадны бор шувуу, хээрийн бор шувуу, хээрийн бор шувуу юм. Нүүдлийн үрждэг шувуудаас бүжимч чогчиго өргөн тархалттай. Харин бусад шувуудын хувьд тодорхой газруудад төвлөрсөн тархалттай байна. Нүүдлийн үрждэг шувуудаас алаг этэн, эгэл хараалай, анхидал ангир, хондон ангир, шугуйн хөгчүү, үхэр цахлай жил бүр Шивээгийн нуурт үржиж байна

Алтан хараацай, бөвөөлжин өвөөлж, хөх цэгцгий, цагаан хэвэлт хөмрөг, сохор элээ, бүжимч чогчиго, эргийн хараацай, хондлой цагаан ураацай, хурын ураацай, хээрийн шийхнүүхэй, дорнын хиазат зэрэг шувууд нь ус намгархаг газраас тусдаа орчинд буюу дэрстэй нам хотос, хад асга бүхий уулс, хаягдсан барилга байгууламж, айлын өвөлжөө гэх мэт байрлалд үүрлэнэ.

Нийт 18 зүйлийн хөхтөн амьтад бүртгэсэн байна. Хөхтөний олонх зүйл аргаль хонь, өмхий хүрэн, шар үнэг, хадны барагчин, бор туулай, монгол тарвага зэрэг Чойрын Богд улсын тусгай хамгаалттай газар нутгийн хүрээнд тэмдэглэгдсэн байна.

Зуны улиралд цагаан зээрийн тоо толгой цөөрөх Баянхошууны талд янзагатай 35 зээр, Сүмбэр уулын баруун талд 23 зээр ба харин өвлийн улиралд элбэгшдэг

Чойрын Богд уул нь Говьсүмбэр аймгийн аргалийн үндсэн байршил нутаг юм. Судалгааны хугацаанд Чойрын Богд уул, Уулзварын гол, Сансар уул хүртэлх орон зайд бид аргаль тархсан байгааг тэмдэглэсэн. 2009 оны ШУА-ын тооллого судалгаагаар 140 аргаль бүртгэгдсэн байдаг.

Чойрын Богд болон түүний орчны бүсийн хадархаг уул толгод нь саарал чоно идээшиж нутаглахад тохиромжтой.

Чойрын Богд уулын төв хэсэгт 1 бодгаль, Сүмбэр уулын орчимд 2 бодгаль ажиглагдсан байна. Чойрын Богд уулын арын хөндий, Уулзварын голын зүүн талын тал хээрт 20-оос цөөн тоо толгойтой 6 бүл тарвагатай. Чойрын Богд ууланд байрлах нөмрөг тасууд Шивээгийн нуур болон Уулзварын голоос ихэвчлэн ундаалдаг ба Говьсүмбэр аймгийн хэмжээнд 17 бодгаль бүртгэгдсэн.

Говьсүмбэр аймгийн нутагт тархан амьдрах агнуурын 13 зүйл хөхтнөөс, 7 зүйл нь ан агнуурын ач холбогдолтой байна.

### **1.2.7. Орчны бохирдол**

Сүүлийн жилүүдэд аймгийн төв болон Сүмбэр суманд суурьшил эрчимжиж хог хаягдал нэмэгдэж байгаа нь тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Сумын төвүүд төвлөрсөн хогийн цэгтэй, хогийн цэгүүдийг тохижуулах ажлууд хийгдэж байна. Сүмбэр сумын төвлөрсөн хогийн цэгт Ландфилл аргаар хог хаягдлыг булшлах технологийг нэвтрүүлсэн боловч санхүүжилтийн эх үүсвэргүйн улмаас хэрэгжээгүй байна. Аймгийн хэмжээгээр нийт 33.8 га талбай бүхий гурван төвлөрсөн хогийн цэгт ахуйн хатуу 19290.9 тн, үйлдвэрийн хатуу 2430 тн хог хаягдал байна. Мөн Сүмбэр суманд жишиг гудамж байгуулж, айл өрхийн хашаанд боловсон хогийн сав байрлуулж, хогийг ангилан ачиж хаях арга хэмжээг нэвтрүүлсэн байна.

Тус аймгийн хэмжээнд хуучнаар ЗХУ-ын зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүдийн ашиглаж байгаад орхигдсон барилга, байгуулажийг нурааснаар барилгын туурь, хатуу хог хаягдал ихээр хуримтлагдан орчныг бохирдуулж, газрын гадаргын элэгдэл, эвдрэлийг бий болгож, газар ашиглалтад сөргөөр нөлөөлсөөр байна. Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 5 хэсэг газарт 218.5 га талбай барилгын туурь, хатуу хог хаягдлаар бохирдсоноос 2013-2015 оны хооронд 69.5 га талбайг цэвэрлэж, техникийн нөхөн сэргээлтийг хийснээр 31.8 хувиар багассан байна.

Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэр дэх улсын чанартай авто зам дагуу малын сэг, зэм нилээд тааралдана. Малчид сэг, зэмийг төвлөрсөн хогийн цэгт хаяхгүй ил задгай газарт зам дагуу хаяж гээж байгаа нь байгаль орчныг бохирдуулаад зогсохгүй хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөр байна.



### 1.3. Нийгэм-эдийн засгийн суурь нөхцөл


#### 1.3.1. Хүн ам зүй

2010 оны тоогоор тус сумын нийт хүн амын тоо 10697 үүний эрэгтэй 5281, эмэгтэй 5416 байсан бөгөөд 2016 онд хүн амын тоо 12532 үүнээс эрэгтэй 6125, эмэгтэй 6227 тоологдсон байна.


Хүснэгт : Хүн амын тоон өөрчлөлт

Он	Эрэгтэй	Эмэгтэй	Сүмбэр сум
2010	5281	5416	10697
2011	5454	5648	11102
2012	5557	5722	11279
2013	5667	5903	11570
2014	5848	5761	11709
2015	5974	5927	11901
2016	6125	6227	12532

Бүдүүвч: Сүмбэр сумын хүн ам, өрхийн тооны өөрчлөлт, 2010-2016 он




Суурин байгаа хүн амын тоо: 2016 он



Насны бүтэц: 2016 оны байдлаар Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 12532 хүн амын 48.8 хувь нь эрэгтэй, 49.6 хувь нь эмэгтэй хүн ам байна.

Нийт хүн амын 31.6 хувийг 0-15 насны хүүхэд, 57.7 хувийг 16-59 насны хүмүүс, 9.1 хувийг 60 ба түүнээс дээш насны хүмүүс эзэлж байна. Насны бүлгээс харахад 70 ба түүнээс дээш настан 257, 80 ба түүнээс дээш настан 87, 90 ба түүнээс дээш настан 15 тоологдсон байна.



*Ажил эрхлэлт:* 2016 онд хөдөлмөрийн насны хүн ам 7472, үүнээс 4156 нь ажиллагчид байгаа нь хөдөлмөрийн насны хүн амын 55.6 хувийг эзэлж байна

Хүснэгт: Ажиллагчидын тоо, 2010-2016 он


	Сүмбэр	Говьсүмбэр
2010	3307	4566
2011	3400	4641
2012	3464	4799
2013	3696	5047
2014	3869	5238
2015	4050	5827
2016	4156	5988

Эх сурвалж: Сүмбэр сумын хүн ам, нийгмийн үзүүлэлт, 2003-2016 он

*Шилжих хөдөлгөөн:* 2010-2016 оны хугацаанд шилжин ирэгчдийн тоо Говьсүмбэр аймгийн хэмжээнд 5491 Сүмбэр сумын хэмжээнд 3949 хүн амын тоо бүртгэгдсэн байна.

2010-2016 оны хугацаанд шилжин явсан хүний тоо Говьсүмбэр аймгийн хэмжээнд 4734 Сүмбэр сумын хэмжээнд 3483 хүн амын тоо бүртгэгдсэн байна.

Бүдүүвч : Сүмбэр сумын шилжих хөдөлгөөн, 2010-2016 он



## Хүснэгт: Шилжих хөдөлгөөн

Он	Шилжин ирсэн	Шилжин явсан
	Сүмбэр сум	Сүмбэр сум
2010	684	510
2011	687	477
2012	372	366
2013	598	521
2014	511	595
2015	557	484
2016	540	530

## 1.3.2. Газар тариалан

2016 онд 39.4 га талбайд тариалалт хийснээс төмс 18.1 га-д, хүнсний ногоо 11.0 га-д, тэжээлийн ургамал 10.6 га-д, жимс, жимсгэнэ 0.06 га-д тариалсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт тариалсан талбай 23.9 га буюу 2.5 дахин нэмэгдсэн байна.


## Сүмбэр сумын тариалсан талбайн хэмжээ /2010-2016 оноор/

2010	2011	2012	2013	2014	2015	2016
21.8	32.8	5.6	7.9	15.1	15.5	39.4

Ургац хураалтын эцсийн мэдээгээр сумын хэмжээнд 78.7 тн төмс, 38.5 тн хүнсний ногоо, 5.16 тн тэжээлийн ургамал, 1.98 тн жимс, жимсгэнэ хурааж авсан байна.

## 2016 оны тариалалт, ургац хураалтын дүн


№	Сумын нэр	Тариалалт				Ургац хураалт			
		Төмс	Хүнсний ногоо	Тэжээлийн ургамал	Жимс жимсгэнэ	Төмс	Хүнсний ногоо	Тэжээлийн ургамал	Жимс жимсгэнэ
1	Сүмбэр	18.4	11.07	10.16	0.06	78.7	38.5	5.16	1.98
	Нийт дүн	<b>18.4</b>	<b>11.07</b>	<b>10.16</b>	<b>0.06</b>	<b>78.7</b>	<b>38.5</b>	<b>5.16</b>	<b>1.98</b>



Сүмбэр сумын хураасан ургацын дүн мэдээ /2010-2016 оноор/

2010	2011	2012	2013	2014	2015	2016
216.3	261.2	38.4	40.9	79.4	68.3	122.2

Сумын хэмжээгээр хураасан ургацын мэдээг сүүлийн 7 жилээр авч үзвэл 2011 онд хамгийн их буюу 261.2 тн ургац, 2012 онд хамгийн бага буюу 38.4 тн ургац, 2016 онд 122.2 тн ургац хурааж авсан байна.



### 1.3.3. Мал аж ахуй

2010 онд Сүмбэр сумын хэмжээнд 359 өрхийн 716 малчин байсан бол 2016 онд 548 малчин өрхийн 950 малчин бүртгэгдсэн байна. Малчидын тоо 2016 онд 2010 оноос 23.4 хувиар буюу 168-аар өссөн байна. 2016 оны жилийн эцсээр Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум 295.3 мянган толгой малтай болсон нь 2015 оны мөн үеэс 18.4

мянган толгой буюу 4.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс: адуу 12990 толгой, үхэр 8879 толгой, тэмээ 639 толгой, хонь 123602 толгой, ямаа 132283 толгой тус тус тоологджээ.

## Хүснэгт: Малын тоо, 2010-2015

	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Сүмбэр сум	114785	141522	165819	198730	245303	278393	295361

Эх сурвалж: Говьсүмбэр аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт, 2009-2015 он

## Хүснэгт : Малчин өрхийн тоо, 2010-2015

	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Сүмбэр сум	359	367	382	421	479	495	548

Эх сурвалж: Говьсүмбэр аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт, 2009-2015 он

## Хүснэгт : Малчидын тоо, 2010-2016

	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Сүмбэр сум	716	682	690	755	859	878	950

Эх сурвалж: Говьсүмбэр аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт, 2009-2015 он

## Хүснэгт 8: Том малын зүй бус хорогдол, 2010-2016

	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Сүмбэр сум	7675	271	753	1184	1466	1677	8650

Энэ онд тус аймагт нэг мянгаас дээш толгой мал тоолуулсан 90 малтай иргэн бүртгэгдсэнээс 63 малчин нь Сүмбэр сумын харъяат иргэн байна.

Тус аймагт Монгол улсын хэмжээнд ганц байгаа Говьсүмбэр аймгийн брэнд болсон каракулийн Сүмбэр хонь үүлдрийг өсгөдөг. Каракуль хурганы арьсны чиглэлийн “Сүмбэр” хонийг 1990 онд үүлдэр болгон баталсан байдаг. Эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн мал 13737, үүнээс “Сүмбэр” хонь 1591 толгой тоологдлоо. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал эрлийз, цэвэр үүлдрийн мал 39.8 хувиар, “Сүмбэр” хонь 19.3 хувиар тус тус өссөн байна.

## “СҮМБЭР” үүлдрийн хонь

Он	СҮМБЭР каракуль хонь, толгой				Нийт мал	Нийт малд каракуль хонин эзлэх хувь
	Бүгд	Хээлтэгч	Хээлтүүлэгч	Бэлтгэсэн арьс		
2010	1029	777	50	449	153223	0.7
2011	826	760	47	237	189651	0.4
2012	793	547	57	224	226102	0.4
2013	767	506	57	239	272764	0.3
2014	1166	610	44	81	339438	0.3
2015	1334	708	41	232	379477	0.4
2016	1595	1009	31	316	397910	0.4

## Тэжээвэр амьтад

	Гахай:				Тахиа:			
	Бүгд	Хээлтэгч	Хээлтүүлэгч	Бусад	Бүгд	Хээлтэгч	Хээлтүүлэгч	Бусад
Сүмбэр сум	254	102	27	125	3732	102	15	3615

Нийт гахайны 91.7 хувь, нийт тахианы 98.4 хувь Сүмбэр сумын нутагт байршиж, өмнөх оны үеэс гахай 9.0 пунктээр, тахиа 0.2 пунктээр нэмэгдсэн.

**1.3.4. Аж үйлдвэр**

Тээвэр: Дэд бүтэц, зам харилцаа сайн хөгжсөн. Тус сумын нутгаар Москва-Улаанбаатар-Бээжинг холбосон Транс Сибирийн олон улсын транзит төмөр зам, агаарын коридор дайран өнгөрдөг.

Эрчим хүч: Цахилгаан эрчим хүчний дамжуулах станц нь Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Хэнтий аймгуудын 19 төв суурин газар, сумд, эдгээр сумын нутагт орших үйлдвэрийн газрууд, айл өрхийг цахилгаан эрчим хүчээр ханган ажилладаг. Монгол улсын хойд хилээс өмнөд хил хүртэл тавигдсан шилэн кабелийн шугамд холбогдсон, тоон АТС-ын системд шилжсэн, хөдөлгөөнт холбоо суурилагдсан, дэлхийн аль ч улс оронтой телефоноор болон интернетээр харилцах боломж бүрдсэн. Мөн цахилгаан түгээх сүлжээ нь айл өрх, албан байгууллагад цахилгаан түгээх үйлчилгээ үзүүлж байна.

*Аж үйлдвэржилт:* Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд сүүлийн жилүүдэд эдийн засгийн хувьд эрчимтэй өсөж байгаа бөгөөд томоохон үйлдвэрүүдээс дурьдвал нүүрсний уурхай, жонш угаах үйлдвэрүүд тус тус үйл ажиллагаагаа явуулж байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн мэдээг “Ус-Ду” ОНӨААТҮГ, “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ, ОНӨААТҮГ, “ОНӨААТҮГ, “Илчит сансар” ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллагуудаас авдаг бөгөөд эдгээр аж ахуйн нэгж байгууллагууд 2016 онд 47.1 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 44.7 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна. 2015 оны мөн үетэй харьцуулбал бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 25.3 хувиар өссөн ба үүнд уул, уурхайн салбарын үйлдвэрлэлт голлон нөлөөлсөн байна.

*Багуудын хөгжлийн зарим үзүүлэлтүүд*

Багийн нэр	Өрхийн тоо	Хүн амын тоо	Малын тоо	Сумын төвөөс зай, км
1-р баг	735	2774	3685	-
2-р баг	792	2898	7689	-
3-р баг	734	2443	4454	-
4-р баг /Тэвш/	165	525	31768	13
5-р баг /Уулзвар/	192	637	43365	37
6-р баг /Малх/	120	442	33010	75
Аж ахуйн нэгжүүд	-	-	2383	-
Нийт	2738	9719	126354	-

### 1.3.5. Боловсрол

2016 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 4 сургуульд 3800 сурагч суралцаж, 170 багш ажиллаж байгаа бөгөөд нэг багшид 35 сурагч ногдож байна. Суурь боловсролын хамран сургалтын бохир жин 98, бага боловсролынх 102.1, дунд боловсролынх 95.6 хувь байна. Аймгийн төвийн 8 цэцэрлэгт 39 багш ажиллаж, нийт нэг 1520 хүүхэд сурч хүмүүжиж байна. Говьсүмбэр аймагт 20 суудал бүхий нийтийн номын сан нэг ажиллаж байгаа бөгөөд уншигчдын тоо 670 хүн байна. Мөн 300 суудал бүхий 2 соёлын төвтэй, ажиллаж байгаа сүм хийд 2, үүнээс буддын сүм 1, христийн сүм 1 байна.

### 1.3.6. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн салбарт 41 их эмч, 2 эм зүйч ажиллаж байгаа бөгөөд нэг их эмчид 320, нэг сувилагчид 247 хүн ногдож байна. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн өвчтөний тоо 4.3 мянган хүн байна. Эрүүл мэндийн салбарын боловсон хүчний хангалт дутагдалтай, мэргэжлийн ур чадварын түвшин харилцан адилгүй,



эмнэлэгүүдийн төсөв, материаллаг баазын хангамж, хүрэлцээ хангалтгүйгээс эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний чанар, хүртээмж шаардлагын түвшинд хүрээгүй байна.

### 1.3.7. Байгалийн баялаг

Чойр уулын зүүн тарл, Сүмбэр уулын эргэн тойронд тоосгоны шавар, хүрэн нүүрс, газрын тос, холимог металл болон эрдэс будгийн нөөцийг тогтоосон байна. Аймгийн төвөөс 100 м радиус дотор 30 гаруй төрлийн ашигт малтмалын орд, илэрц байдаг. Үүнд:

Хайлуур жонш /38 сая тн/

Холимог металл /1.1 сая тн/

Төмрийн хүдэр /13 сая тн/

Бал чулуу /200 мянган тн/

Хүрэн нүүрс /13 биллион тн/

Байгалийн үзэсгэлэнт газрын хувьд Хүрийн ногоон, Цоорхойн рашаан, Зүүн Чойрын хийдийн туурь, Уулзварын гол, Зараа булаг, Баян булаг, Хүн хөшөө зэрэг газруудтай.

### Хөгжлийн давуу болон сул талын шинжилгээ

Хүчтэй ба давуу тал /S/	<ol style="list-style-type: none"> <li>1. Дэд бүтэц сайн хөгжсөн</li> <li>2. Мянганы замын босоо тэнхлэгийн зам дайран өнгөрдөг</li> <li>3. Сумын төв нэгдсэн эрчим хүчинд бүрэн холбогдсон</li> <li>4. Улаанбаатар, Замын-үүдийг холбосон холбооны шилэн кабелийн сүлжээнд холбогдсон</li> <li>5. Үүрэн холбооны Мобиком, Скайтель, Жи мобайл, Юнител болон Мэдээлэл Цахилгаан Холбоо ХХК үйл ажиллагаа явуулдаг</li> <li>6. Дэд бүтцээ дагаад иргэдийн шилжин ирж суурьших хөдөлгөөн нэмэгдэж байгаа</li> <li>7. Бизнес эрхлэхэд шаардлагатай талбай ихтэй, орон нутгийн сууцны нөөцтэй</li> <li>8. Монгол шуудан, ХААН, Хас, Хадгаламж, Кредит банкууд үйл ажиллагаа явуулдаг</li> </ol>
----------------------------	---


Сул тал /W/	<ol style="list-style-type: none"> <li>1. Суманд бизнесийн таатай орчин бүрдээгүй. Ажилгүйдэл, ядруурал дорвитой буурахгүй байна</li> <li>2. Сум өөрийн гэсэн алсын хараа, зорилго, зорилгоо тодорхойлоогүйн улмаас ихэнхдээ дээд шатны байгууллагын шийдвэр хүлээж, сонгогдсон Засаг дарга нарын мөрийн хөтөлбөрт баригдсан бодлого үйл ажиллагаа явуулдаг.</li> <li>3. Удирдлага, төлөвлөлт, санхүүжилтийн хувьд босоо тогтолцоотойн улмаас өөрөө төсвөө бүрдүүлэх, захиран зарцуулах эрх хязгаарлагдмал</li> <li>4. Бизнес эрхлэгчдийн санхүүгийн чадавхи сул учир өрсөлдөөн бага, үүнийгээ дагаад хөгжил нь ч удаан</li> <li>5. Төвөөс алслагдсан багуудын барилга болон засвар, хөгжлийн төлөвлөгөө орхигдсон</li> </ol>
Нөөц боломж /O/	<ol style="list-style-type: none"> <li>1. Төв замаа дагаж хөгжих боломжтой</li> <li>2. Мал аж ахуйг эрчимжүүлэх, газар тариаланг хөгжүүлэх нөхцөл бүрдэж байна</li> <li>3. Олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажиллах боломжтой</li> <li>4. Говьсүмбэр, Дундговь аймгийн нутгийг дамжин орших Хараатын ураны хүдрийг ашиглах, олборлох боломжтой;</li> <li>5. Байгалийн болон түүхийн дурсгалт газруудыг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх бололцоотой;</li> <li>6. Говьсүмбэр аймаг нь давуу талууддаа түшиглэн говийн бүсийн аймгуудын иргэдийн суурьшилтын нэг томоохон төв болох боломжтой.</li> </ol>
Болзошгүй аюул /T/	<ol style="list-style-type: none"> <li>1. Байгалийн давагдашгүй хүчний нөлөөгөөр мал сүрэг хорогдох магадлалтай</li> <li>2. Байгаль экологийн тэнцвэр алдагдан цөлжилт идэвхтэй явагдаж, бэлчээр хомсдож буй</li> </ol>

## Хоёрдугаар бүлэг. АЙМГИЙН ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН БҮТЭЦ АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ

### 2.1. Сумын газрын нэгдмэл сангийн бүтэц

2016 оны жилийн эцсийн байдлаар Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Газрын нэгдмэл санд:

Газрын нэгдмэл сангийн ангилал	Талбайн хэмжээ	Эзлэх хувь
Хөдөө аж ахуйн газар	312644.91	82.96
Хот, тосгон бусад суурины газар	1865.54	0.49
Зам, шугам сүлжээний газар	2743.45	0.72
Усны сан бүхий газар	731.3	0.19
Улсын тусгай хэрэгцээний газар	58833.8	15.61




Газрын нэгдмэл сангийн ангилалд гарсан өөрчлөлт

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2015	2016	Зөрүү
<b>Нийт газар</b>			<b>376819</b>	
1	Хөдөө аж ахуйн газар		312644.9	
2	Хот, тосгон бусад суурины газар		1865.54	
3	Зам, шугам сүлжээний газар		2743.45	
4	Ойн сан бүхий газар			
5	Усны сан бүхий газар		731.3	
6	Улсын тусгай хэрэгцээний газар		58833.8	

**2.1.1. Хөдөө аж ахуйн ангиллын газрын бүтэц, ашиглалт, хамгаалалтын байдал**

Хөдөө аж ахуйн газар нь нэгдмэл сангийн нийт нутаг дэвсгэрийн 312644.91га буюу 82.96 хувийг эзэлж байна. Үүнд:

Газрын ангилал	Талбайн хэмжээ	Эзлэх хувь
Бэлчээрийн газар	300461.90	96.1
Хадлангийн талбай	7810	2.49
Тариалангийн газар	249.52	0.07
Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар	30.67	0.009
Хөдөө аж ахуйн хэрэгцээнд тохиромжгүй газар	4092.82	1.30



#### Тариалангийн газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал

2016 онд 39.4 га талбайд тариалалт хийснээс төмс 18.1 га-д, хүнсний ногоо 11.0 га-д, тэжээлийн ургамал 10.6 га-д, жимс, жимсгэнэ 0.06 га-д тариалсан байна. Өмнөх онтой харьцуулахад нийт тариалсан талбай 23.9 га буюу 2.5 дахин нэмэгдсэн байна.

#### **Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэл:**

Аймгийн хэмжээнд 0.315 га буюу 3152 м/кв талбайтай 31 хүлэмжид тариалалт хийж 3.7 тонн хэмх, лооль, амтат чинжүүний ургац хураан авав. Хамгаалалттай хөрсний тариалалтын талбай өмнөх оноос /2454/ 698 м/кв буюу 28,0 хувиар нэмэгдсэн байна.

Тайлант онд 310 м/кв талбай бүхий 5 хүлэмж шинээр ашиглалтанд орсоноос Сүмбэр суманд 304 м.кв бүхий 4 шинэ хүлэмж баригдаж ашиглалтад орсон байна.

Сүмбэр сум нь нийт 1840 м<sup>2</sup> талбайд хүлэмжийн аж ахуй эрхэлж байна.

#### **Усалгаатай газар тариалангийн талаар:**

Одоогийн байдлаар усалгаатайгаар бага хэмжээний газар тариалан эрхэлж байна. Сүмбэр сумын 4-р багийн Тэвш гэдэг газарт Сүмбэр айраг хоршооны “Бороожуулах усалтын систем”-ыг 2008 онд ашиглалтад оруулж нийт 64.5 га талбайд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалсан байна.

#### ХАА-н барилга байгууламжийн газар

**Өвөлжөө, хаваржаа:** Тус аймагт нийт 1231 малчин өрхийн 376 өвөлжөө, хаваржаа байгаагаас Сүмбэр суманд 281 байна.

**Худаг:** 2017 оны байдлаар аймгийн хэмжээнд тоологдсон нийт 7796 худаг байгаагаас Сүмбэр суманд 163 худаг байршиж байна.

№	Сумын нэр	Худгийн тоо		
		Өрөмдмөл	Гар худаг	Нийт
1	Сүмбэр	77	86	163

**Услалтын систем:** Сумын хэмжээнд Тэвшийн бороожуулах услалтын систем ажиллаж байгаа ба 2016 оны байдлаар талбайн ашиглалт 11,6 хувьтай байна.

**Зоорь:** Сумын хэмжээнд 526 тоннын багтаамжтай 12 ногооны зоорь байдаг ба төмс, хүнсний ногооны холимог 2 ширхэг зоорьтой.


Хөдөө аж ахуйд ашиглах боломжгүй газар

2016 оны Говьсүмбэр аймгийн газрын тайлангаар аймгийн хэмжээнд зөвхөн Сүмбэр суманд л 4092.82 га хөдөө аж ахуйд тохиромжгүй газар бүртгэгдсэн нь уулсын хад асгатай хэсэг мөн нутгийн баруун урд хэсэгт мал бэлчээрлэх боломжгүй цөлөрхөг газрууд орж байгаа болно.

**2.1.2. Хот, тосгон бусад суурины ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын одоогийн байдал**

Хот, тосгон бусад суурины газар нь аймгийн нийт нутаг дэвсгэрийн **1865.54** га буюу **0.49** хувийг эзэлж байна. Үүнд:

Газрын ангилал	Талбайн хэмжээ	Эзлэх хувь
Барилга байгууламжийн дэвсгэр газар	346.14	18.55
Нийтийн эдэлбэр газар	745.66	39.97
Үйлдвэрийн газар	267.43	14.33
Уурхайн газар	0	0
Гэр хорооллын газар	506.31	27.14



Барилга, байгууламжийн дэвсгэр газар нийт 346.14 га, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа барилга, байгууламжийн доорхи газар 333.59 га, амралт, рашаан сувиллын газар 12.55 га, нийтийн эдэлбэрийн газрын хэмжээ 745.66 га, гудамж талбай, замын газар 66.6 га, оршуулгын газар 3 га, хог хаягдлын газар 20 га, сул чөлөөтэй газар 655.56 га, үйлдвэрийн газар 267.43 га, уурхайн газар 269 га, гэр хорооллын газрын нийт хэмжээ 506.31 га газар байна.


#### ***Аялал жуулчлал:***

2011 онд тусгай хамгаалалтанд авсан Чойрын Богд уул, түүний ойр орчимд орших Зүүн Чойрын хийдийн туурь, Цагаан дарь эх бурхан, Дагвасүндэл бурхан, Хүүхдийн овоо, Хиагт-Өргөө, Бээжинг холбож байсан харилцаа холбооны төмөр утасны хорооны балгасууд, Зараагийн болон Хөшөөтийн Түрэгийн үеийн хөшөө, Баянбулаг, Чингэлийн хадны хиргисүүр зэрэг түүх соёлын үзмэрүүдээр баялаг. Эдгээр түүх дурсгалын өвүүдэд түшиглэн аялал жуулчлалыг түүх соёлын болон байгаль экологийн төрлүүдээр хослон хөгжүүлэх боломжтой.

#### ***2.1.3. Зам, шугам сүлжээний ангиллын газар, түүний ашиглалтын байдал***

Зам, шугам сүлжээний газар нь Сүмбэр сумын нийт нутаг дэвсгэрийн 2743.45 га буюу 0.72 хувийг эзэлж байна. Үүнд: Авто замын газар 1343 га буюу 48.95 хувь, шугам, сүлжээний газар 849.54 га 30.96 хувь, төмөр замын газар 550.91 га буюу 17.1 хувийг тус тус эзэлж байна.

Газрын ангилал	Талбайн хэмжээ	Эзлэх хувь
Авто замын газар	1343	48.95
Шугам сүлжээний газар	849.54	30.96
Төмөр замын газар	550.91	17.1



Тус сумын нутаг дэвсгэр дээгүүр дайран өнгөрдөг А01 чиглэлийн улсын чанартай авто замын хөдөлгөөний эрчим, нөхцөл байдлыг Зам, тээврийн хөгжлийн яамнаас хийсэн судалгаагаар тогтоосон байна.

Хүснэгт 18. /1 хоногт өнгөрөх машины тоо. 2016 он/

Тооллого хийсэн замын чиглэл	Оргил цаг	жилийн дундаж
УБ-Налайх-Чойр	3231	2660
Чойр-Налайх-УБ		
Налайх-Чойр	1524	1252
Чойр-Налайх		
Чойр-Сайншанд	96	241
Сайншанд-Чойр		

Сумын хэмжээнд байгаа нийт авто замын газрын 367.3 га-г улсын чанартай авто зам, 975.7 га-г орон нутгийн чанартай авто замын талбай эзэлж байна.

Төмөр замын нийт 550.91 га газраас төмөр замын далангийн талбай, хамгаалалтын зурвас газар 471.57 га-г, өртөө, зөрлөгийн барилга, байгууламжийн талбай 79.34 га-г тус тус эзэлж байна.

#### Инженерийн шугам сүлжээний зурвас газар

Сүмбэр суманд шугам сүлжээний дэд ангилалд хамаарах 849.54 га газар байгаа бөгөөд үүний 74 хувь буюу 629.28 га эрчим хүчний шугам, холбооны шугам,

холбооны мэдээлэл хүлээн авах станцын эзлэх талбай 206.9 га бөгөөд 24.3 хувийг, ус, дулаан дамжуулах хоолой 11.03 га буюу 1.3 хувийг, ус шахах өргөх байгууламжийн 2.33 га буюу 0,003 хувийг тус тус эзэлж байна.


Цахилгаан дамжуулах шугам нь Хэнтий аймгийн Өндөрхааны дэд станцаас гарч Сүмбэр, Баянтал сумын нутгаар дайрч Чойрын дэд станц дээр ирээд Шивээ-Овоогийн уурхай болон Шивээговь сум, Дорноговь аймгийн Далантүрүү мөн Дундговь аймгийн Говь-Угтаал сумруу салбарлан явдаг байна.

Эдгээр шугам сүлжээний газрууд нь эрчим хүчний шугамын зурвас газар болон холбооны шугамын зурвас газар нэрээр бүртгэгдэж байдаг боловч бэлчээрийн газарт ашиглагдаж байдаг онцлогтой.

#### 2.1.4. Усны сан бүхий газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал

Усан сан бүхий газар нь Сүмбэр сумын нийт нутаг дэвсгэрийн 731.3 га буюу 0.19 хувийг эзэлж байна. Үүнд: гол, мөрний газар 4.2 га буюу хувь, нуур цөөрмийн эзлэх талбай 802.5 га хувийг тус тус эзэлж байна.

Газрын ангилал	Талбайн хэмжээ	Эзлэх хувь
Гол, мөрний газар	59.8	8.17
Нуур цөөрмийн газар	671.5	91.8



Сумын хэмжээнд тал хээрийн бүсэд хамаарагдах ба жилийн турш байнга устай байдаг тоотой хэдэн нуураас өөр гадаргын усны сүлжээ байхгүй юм. Хаврын шар ус,



зуны борооны үеэр түр зуурын урсгал ус үүсч улмаар ширгэж алга болдог байна. Байнгын урсгалтай гол горхи, нуур талбайн болон орчны хэмжээнд гадаргуугийн усан сүлжээгүй, зөвхөн ухаа гүвээт талын хонхор, хотгоруудад ширгэдэг. жижиг нуур, тогтоол ус /тойром/ тохиолддог.

**2.1.6. Тусгай хэрэгцээний газар, түүний ашиглалт хамгаалалтын одоогийн байдал**

Тусгай хэрэгцээний газар нь Сүмбэр сумын нийт нутаг дэвсгэрийн 58833.8 га буюу 15.61 хувийг эзэлж байна.

Газрын ангилал	Талбайн хэмжээ	Эзлэх хувь
Улсын тусгай хамгаалалттай газар	3814.36	6.48
Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	10.9	0.01
Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгийн ажиглалтын талбай	3.89	0.0006
Аймаг дундын отрын бэлчээрийн газар	55004.65	93.49



**Тусгай хамгаалалттай газар нутаг**

Нийт тусгай хамгаалалттай газрын 3814.36 га нь улсын тусгай хамгаалалттай газар, 63409.12 га нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар байна.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт оршдог Чойрын богд уулыг 2011 онд УИХ-ын тогтоолоор улсын тусгай хамгаалалтанд авсан байна. Уг тусгай

хамгаалалттай газар нь 5258 га талбайг эзлэх бөгөөд байгалийн цогцолборт газрын ангилалд хамааруулжээ.

Говьсүмбэр аймагт байгалийн нөхцөл, өвөрмөц тогтоц, ховор амьтан ургамал бүхий газрууд цөөнгүй байх бөгөөд эдгээр газруудаа нутгийн ардууд хайрлан хамгаалж тахин шүтэж байдаг. Одоогийн байдлаар орон нутгийн хамгаалалтад авсан 8 тусгай хамгаалалттай газар байдаг нь 44555.74 га талбайг эзэлдэг байна

#### Хүснэгт 21. Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрууд

д/д	Орон нутгийн хамгаалалтад авах газрууд	Хамгаалах зүйл	Талбайн хэмжээ
1	Сүүл өндөр	Амьтан, ургамал, усны нөөц газар	33296.78
2	Хөшөөтийн хүн чулуу	Түүхийн дурсгал	399.69
3	Чингэлийн хадны хиргисүүр	Түүхийн дурсгал	5107.02
4	Хүрий ногоон	Ургамал, усны нөөц газар	124
5	Хөмүүлтэйн гүүрнээс зараа булан хүртэл	Амьтан, ургамал, усны нөөц газар	5093.65
6	Зүүн өврийн хүн чулуу	Байгаль, түүхийн дурсгалт газар	100.32
7	Сүлд овоо	Байгаль, түүхийн дурсгалт газар	29.08
8	“Тэрэгт” усны эх үүсвэр	Усны эх үүсвэр, тэжээгдлийн муж цэнгэг усны нөөцийг хамгаалах	405.2

Говьсүмбэр аймгийн хэмжээнд Улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах зориулалтаар болон цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай зэрэг нийт тусгай хэрэгцээний газар 838.9 га гэж бүртгэгдсэн байна.

Үүнээс 3.89 га газар нь цаг уурын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай, 10.9 га газар нь Чойр хотод байх хорих ангийн талбай, 55004.65 га аймаг дундын отрын бэлчээрийн газар зэрэг хамаарагдана.


## Гуравдугаар бүлэг. НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

### 3.1. Хүн амын өсөлтийн хэтийн төлөв

Сум орон нутгийн цаашдын хөгжил нь оршин суугаа хүн амаас шууд хамааралтай байдаг. Иймд Сүмбэр сумын нийт хүн амын өсөлтийн хэтийн төлөвийг ердийн болон нийгмийн өөрчлөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн, төрөлт нас баралт, ажиллах хүчний тоо, нэн шаардлагатай байгаа ажлын байрны тоо зэрэгтэй уялдуулан нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хэрэгжих 5 жилийн буюу 2018-2022 он хүртэлх хугацаанд тооцож гаргав. 2022 оны түвшинд Сүмбэр сумын хүн ам 13970 орчим хүн амтай болж өсөх ба 4497 орчим өрхтэй болох тооцоог гаргасан.

Хүснэгт 22. Сүмбэр сумын хүн амын хэтийн өсөлт /хүйсээр/

Сум	Хүйс	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Сүмбэр	<b>нийт</b>	<b>12711</b>	<b>12900</b>	<b>13290</b>	<b>13580</b>	<b>13970</b>
	Эр	6286	6383	6581	6728	6925
	Эм	6424	6517	6709	6852	7045



2016 онд нийт хүн ам 12352 байснаас эрэгтэй 6125, эмэгтэй 6227 хүнтэй байна. Нийт хүн амын 49.6 хувийг эрэгтэйчүүд, 50.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Харин төлөвлөлтийн хугацаанд 2022 он гэхэд нийт хүн ам 13970 хүн амтай болж өсөх төлөвтэй байна.

### 3.1. Өрхийн тооны хэтийн өсөлт

Тус аймгийн өрхийн тоо 2018 оны түвшинд 5522 өрх, 2019 онд 5689 өрх, 2020 онд 5856 өрх, 2021 онд 6023 өрх, 2022 онд 6190 өрх болж өсөх хандлагатай байна. Үүнээс Сүмбэр суманд 2018 онд 3997, 2019 онд 4122, 2020 онд 4247, 2021 онд 4372, 2022 онд 4497 өрхтэй болох тооцоог хийлээ.

Хүснэгт 23. Өрхийн хэтийн төлөв

	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Говьсүмбэр	5522	5689	5856	6023	6190
<b>Сүмбэр</b>	<b>3997</b>	<b>4122</b>	<b>4247</b>	<b>4372</b>	<b>4497</b>

### Дөрөвдүгээр бүлэг. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭРЭГЦЭЭТ БАЙДАЛ

Тус аймгийн хүн амын хүнсний хэрэгцээг хангахад хүн ам хэрэгцээний өсөлтөөс, орон нутгийн хөгжлийн өсөлтийг тусгасан байх хэрэгтэй юм.

Хүн амыг насны бүлэг, эрхэлж байгаа ажил төрөл, эрэгтэй, эмэгтэй хүйсийн байдлаар нь бүлэглэж нэгж хүнд хоногт шаардагдах калорийн хэмжээг тогтоосон нормоор тооцож үзэхэд Говьсүмбэр аймгийн нэг хүнд хоногт дунджаар 2864.5 калори бүхий хүнс, тэжээл хэрэглэх шаардлагатай байна. Үүнийг хангахад 10 хувийн нэмэгдэл нөөцтэй байх нь зүйтэй гэж үзвэл 2864.5 калорийн илчлэг өгөх хүнсний нөөцтэй байх хэрэгцээ гарна.

Хүснэгт 24. Нэг хүнд шаардагдах хүнсний илчлэгийн хэмжээ

№	Хүнсний бүтээгдэхүүний төрөл	1 хүний хэрэгцээний норм		Хоногт оногдох шимт бодис, илчлэг			
		Хоногт /гр/	Жилд /кг/	Уураг	Өөх тос	Нүүрс ус	Илчлэг
1	Сүү-сүүн бүтээгдэхүүн	233	85.0	23.80	34.30	30.80	542.85
2	Цөцгийн тос	20	7.3	-	19.01	-	176.83
3	Мах, махан бүтээгдэхүүн	374	136.5	28.42	38.70	-	476.44
4	Өндөг	30	11.0	11.83	1.42	-	61.72
5	Загас-загасан бүтээгдэхүүн	4.4	1.6	0.40	0.28	-	4.24

6	Ургамлын тос	225	82.1	0.03	4.93	-	45.95
7	Гурил-Гурилан бүтээгдэхүүн	770	281.1	32.17	2.23	230.13	1096.20
8	Будаа	269	98.2	2.25	0.29	23.02	105.92
9	Төмс	123	44.9	1.68	-	19.60	87.25
10	Хүнсний ногоо	28	10.2	1.71	-	5.76	30.61
11	Сахар, чихрийн зүйл	92	33.6	-	-	56.99	233.66
12	Жимс, жимсгэнэ	265	96.7	10.03	0.16	0.25	2.88
13	Буурцагт ургамал	84	30.7	1		20	
	Бүгд	2517.4	918.9	113.32	101.32	386.55	2864.55
	Калори	-	-	430.616	891.616	1542.32	2864.55

Нэг хүнд хоногт буюу жилд оногдох хүнсний бүтээгдэхүүний өсөлт нь хүн амын хүнсний хэрэгцээний өсөлтийг тодорхойлох хэмжигдэхүүн болж байна. Говьсүмбэр аймгийн хүн амд шаардагдах хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээг хүнсэндээ ихэвчлэн хэрэглэж буй мах, сүү, гурил гэх зэрэг 13 гол бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрээр төлөвлөлтийн 3 үе шатуудаар тойдорхойллоо.

## Хүснэгт 25. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ, хэтийн төлөв

№	Хүнсний бүтээгдэхүүний төрөл	Жишсэн 1 хүний жилийн хүнсний хэрэгцээ /кг/	Хүнсний бүтээгдэхүүнийг нэг бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох коэффициент		2018 он		2019 он		2020 он		2021 он		2022 он	
					Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/
1	Мах, махан бүтээгдэхүүн	73	5 хошуу малын мах	1	12711	927903	12900	941700	13290	970170	13580	991340	13970	1019810
		73	Гахай шувуу загасны мах	1	12711	927903	12900	941700	13290	970170	13580	991340	13970	1019810
2	Сүү	54.8	Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү	1	12711	696563	12900	706920	13290	728292	13580	744184	13970	765556
		54.8	Уламжлалт аргаар боловсруулсан сүү	1	12711	696563	12900	706920	13290	728292	13580	744184	13970	765556
3	Сүүн бүтээгдэхүүн	73			12711	927903	12900	941700	13290	970170	13580	991340	13970	1019810
4	Гурил	36.5	Буудайн гурил	1	12711	463952	12900	470850	13290	485085	13580	495670	13970	509905
5	Гурилан бүтээгдэхүүн	80.3	талх	0.74	12711	755313	12900	766544	13290	789718	13580	806951	13970	830125
6	Төрөл бүрийн будаа	28.5		1	12711	362264	12900	367650	13290	378765	13580	387030	13970	398145
7	Сахар, чихрийн зүйл	8.4		1	12711	106772	12900	108360	13290	111636	13580	114072	13970	117348
8	Төмс	51.1		1	12711	649532	12900	659190	13290	679119	13580	693938	13970	713867
9	Хүнсний ногоо	73		1	12711	927903	12900	941700	13290	970170	13580	991340	13970	1019810
10	Жимс, жимсгэнэ	65.7		1	12711	835113	12900	847530	13290	873153	13580	892206	13970	917829
11	Буурцагт ургамал	32.9		1	12711	418192	12900	424410	13290	437241	13580	446782	13970	459613
12	Өндөг	6.9		1	12711	87706	12900	89010	13290	91701	13580	93702	13970	96393
13	Хүнсний тос	9.1		1	12711	115670	12900	117390	13290	120939	13580	123578	13970	127127

#### 4.1. Газар тариалангийн үйлдвэрлэлийн хэтийн төлөв

Сүмбэр сумын хүн амын хэрэгцээнд зориулж 2022 онд 506.9 тн гурил, 830.1 тн гурилан бүтээгдэхүүн, 713.8 тн төмс, 1019.8 тн хүнсний ногоо, 917.8 тн жимс, жимсгэнэ бэлтгэх хэрэгцээ гарч байна. Энэ нь одоогийн орон нутгийн үйлдвэрлэлээр 78.7 тонн төмс, 38.5 тонн хүнсний ногоо, 5.16 тонн тэжээлийн ургамал, 1.98 тн жимс, жимсгэнэ тариалж байгааг 2022 он гэхэд үр тариаг 100 хувиар, төмсийг 9.0 хувиар, хүнсний ногоог 26.5 хувиар, жимс, жимсгэнийг 463.5 хувиар тус тус нэмэгдүүлэх шаардлагатай болж байна.

#### Хүснэгт 26. Гурил, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний хэрэгцээ, хэтийн төлөв

№	Хүнсний бүтээгдэхүүний төрөл	Жишсэн 1 хүний жилийн хүнсний хэрэгцээ /кг/	Хүнсний бүтээгдэхүүнийг нэг бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох коэффициент		2018 он		2019 он		2020 он		2021 он		2022 он	
					Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/
1	Гурил	36.5	Буудайн гурил	1	12711	463952	12900	470850	13290	485085	13580	495670	13970	509905
2	Гурилан бүтээгдэхүүн	80.3	талх	0.74	12711	755313	12900	766544	13290	789718	13580	806951	13970	830125
3	Төмс	51.1		1	12711	649532	12900	659190	13290	679119	13580	693938	13970	713867
4	Хүнсний ногоо	73		1	12711	927903	12900	941700	13290	970170	13580	991340	13970	1019810
5	Жимс, жимсгэнэ	65.7		1	12711	835113	12900	847530	13290	873153	13580	892206	13970	917829

Төлөвлөлтийн хугацаанд сумын хүн амд зориулан жилд 1733.6 тонн төмс, хүнсний ногоо, 917.8 тн жимс, жимсгэнэ худалдаж байх шаардлага гарна. Мөн зорь агуулахын багтаамжийг 1000 тонн төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ хадгалж чадах хэмжээнд хүргэх хэрэгтэй.

#### 4.2. Мал аж ахуйн хэтийн төлөв

Сүмбэр сумын хүн амын хэрэгцээнд зориулж 2018 онд 5 хошуу малын 927.9 тн мах, 2019 онд 9417 тн мах, 2020 онд 970.1 тн мах, 2021 онд 991.3 тн мах, 2022 онд 1019.8 тн мах, махан бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх хэрэгцээ гарна

#### Хүснэгт 27. Мах, махан бүтээгдэхүүний хэрэгцээ, хэтийн төлөв

№	Хүнсний бүтээгдэхүүний төрөл	Жишсэн 1 хүний жилийн хүнсний хэрэгцээ /кг/	Хүнсний бүтээгдэхүүнийг нэг бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох коэффициент		2018 он		2019 он		2020 он		2021 он		2022 он	
					Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /кг/
1	Мах, махан бүтээгдэхүүн	73	5 хошуу малын мах	1	12711	927903	12900	941700	13290	970170	13580	991340	13970	1019810
		73	Гахай шувуу загасны мах	1	12711	927903	12900	941700	13290	970170	13580	991340	13970	1019810

Сумын нийт малын өсөлтийг төлөвлөлтийн хугацаанд буюу 2018-2022 оны түвшинд тооцож үзэхэд 251 мянга болж өсөхөөр байна. Үүнээс адуу 29 мянга, үхэр 17 мянга, хонь 98 мянга, ямаа 149 мянга, тэмээ 621 мянга толгой болно. Бид ерөнхий төлөвлөгөө хэрэгжих хугацаанд малын тоотой уялдуулан бэлчээрийн даац, хүрэлцээ ямар хэмжээтэй байх тооцоог “бэлчээр зохион байгуулалтын төлөвлөгөө” хэсэгт оруулан тооцсон.

Хүснэгт 28. Сүмбэр сумын малын өсөлтийн хэтийн төлөв

Малын төрөл	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
<b>Бүгд</b>	<b>223504</b>	<b>230389</b>	<b>237274</b>	<b>244159</b>	<b>251045</b>
Адуу	19549	22061	24573	27085	29597
Үхэр	12439	13685	14931	16177	17423
Хонь	89710	91917	94123	96329	98535
Ямаа	131021	135701	140380	145059	149739
Тэмээ	617	626	597	613	621

### **Тавдугаар бүлэг. ГАЗАР АШИГЛАЛТЫН ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**

ГХГЗЗГ-ын даргын тушаалын 2015 оны 9-р сарын 9-ний өдрийн А/200 тоот “Газрын тохиромжтой байдлын үнэлгээний аргазүй, шалгуур үзүүлэлтүүд батлах тухай” тушаалд зааснаар Сүмбэр сумын бэлчээр, тариалан, хот суурин, ой, зам, шугам сүлжээ болон аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээг дараахь шалгуур аргачлалын дагуу хийсэн.

#### **Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ**

Зорилго нь Монгол оронд хот, суурин газар байгуулахад тохиромжтой болон тохиромжгүй бүс нутгийг үнэлэх ажлыг нэгдсэн зааварчилгаагаар хангахад оршино.

Шинээр байгуулах хот суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийхэд шаардагдах хүчин зүйл, тэдгээрийн шалгуур үзүүлэлтийн талаар Монгол улсын Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны 2010 онд боловсруулсан "Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар" (УББ 30-201-09)-т бүрэн тусгагдсан учраас энэхүү батлагдсан баримт бичигт үндэслэн тохиромжтой байдлын үнэлгээг хийнэ. Ингэхдээ дээрх аргачилсан зааварт тусгагдсан




4 үндсэн, 43 дэд үзүүлэлтээс 3 үндсэн 19 дэд үзүүлэлтийг хэвээр үлдээж, 1 үндсэн, 16 дэд үзүүлэлтийг шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. Үүнд:

Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, инженер геологийн нөхцөл, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Шинээр байгуулах хот суурины дэвсгэр газрын тохиромжтой байдлын иж бүрэн үнэлгээ”-г боловсруулна.

Шинээр байгуулах хот суурины дэвсгэр газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийхэд Схем №8.3-д тусгагдсан нийт 3 үндсэн, 35 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.


1. Байгаль орчны үнэлгээ	2. Инженер дэд бүтцийн үнэлгээ	3. Газар ашиглалтын суурь нөхцлийн үнэлгээ	
1.1. Газрын гадаргын үнэлгээ;	2.1. Улсын чанартай авто замаар хангагдах байдал;	3.1. Ой бүхий талбай;	3.7. Археологийн үнэт олдвор;
1.2. Гидрологийн үнэлгээ;	2.2. Төмөр замаар хангагдах байдал ;	3.2. Хот суурингийн газар;	3.8. Гол, мөрөн;
1.3.Инженер-геологийн үнэлгээ;	2.3.Агаарын тээврээр хангагдах байдал;	3.3. Зам, шугам сүлжээний газар;	3.9. Булаг, худаг уст цэг;
1.4. Хөрсний үнэлгээ;	2.4. Цахилгааны, дулааны эх үүсвэрээр хангагдах байдал;	3.4. Тариалангийн талбай;	3.10. Манхан элс;
1.5.Байгаль экологийн үнэлгээ	2.5. Хүн ам төвлөрсөн суурин газраас алслагдах байдал;	3.5. Уул уурхайн талбай;	3.11.Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай
		3.6. Түүх соёлын дурсгалт газар;	3.12.тусгай хамгаалттай газар

Схем №5.1. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээний



Хүснэгт № 291. Шинээр байгуулах хот, суурин газарт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	19843.75	5.32
Нэн тохиромжгүй	137787.5	36.95
Тохиромжгүй	93756.25	25,14
Хязгаарлагдмал тохиромжтой	121487.5	32.58



**Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ**


Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Тариалангийн газрын тохиромжтой байдлын иж бүрэн үнэлгээ”-г боловсруулна.

Тариаланд тохиромжтой газрын иж бүрэн үнэлгээ өгөхдөө хүрээлэн буй орчныг нэгдсэн систем гэж үзэж, байгаль болон нийгэм эдийн засгийн хүчин зүйлүүдийг хослуулж 5 шатлалтай ангиллаар үнэлгээний хүчин зүйлсийн үзүүлэлт бүрт тохируулан тогтоосон онооны (баллын) аргаар үнэлгээг боловсруулна. Үүнд:

<b>1. Геофизик хүчин зүйлийн үнэлгээ</b>	<b>2. Уур амьсгалын үнэлгээ</b>	<b>3. Газар ашиглалтын суурь нөхцлийн үнэлгээ</b>	
1.1. Газрын гадаргын үнэлгээ;	2.1. Агаарын температур;	3.1. Ой бүхий талбай;	3.6. Түүх соёлын дурсгалт газар;
1.2. Гидрологийн үнэлгээ;	2.2. Хур тунадас;	3.2. Хот суурингийн газар;	3.7. Археологийн үнэт олдвор;
1.3. Инженер-геологийн үнэлгээ;	2.3. Дулаан хангамжийн нөхцөл;	3.3. Зам, шугам сүлжээний газар;	3.8. Гол, мөрөн;
1.4. Хөрсний үнэлгээ;	2.4. Чийг хангамжийн нөхцөл;	3.4. Тариалангийн талбай;	3.9. Булаг, худаг уст цэг;
		3.5. Уул уурхайн талбай;	3.10. Манхан элс;


Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийхэд Схем №8.1-д тусгагдсан нийт 3 үндсэн, 29 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэсэн.

*Схем №5.2. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд*



Хүснэгт №30. Тариаланд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	19946.25	5.33
Нэн тохиромжгүй	6.48	0.0001
Тохиромжгүй	3969.81	1.06
Хязгаарлагдмал тохиромжтой	204537.9	54.69
Тохиромжтой	104015.3	27.81
Нэн тохиромжтой	41501.97	11.10



**Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээ**


Байгалийн нөөц рекреацийн нутаг дэвсгэр ашиглалтын урьдчилсан нөхцлүүдийн нэг гол хүчин зүйл, байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн төдийгүй түүний иж бүрдлийг бүхэлд нь хамардаг онцлогтой юм.

Говьсүмбэр аймгийн Ландшафт-рекреацийн чадавхийн үнэлгээнд дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзэж шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Үүнд:

<b>1. Ландшафтын үнэлгээ</b>	<b>2. Байгаль, түүх, соёлын дурсгалт газрын үнэлгээ</b>	<b>3. Дэд бүтцийн үнэлгээ</b>	<b>4. Газар ашиглалтын суурь нөхцөлийн үнэлгээ</b>
1.1. Газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээ	2.1. Байгаль-соёлын дурсгалт газар	3.1. Гатлага, зам (даваа, ус, элс, намаг, шавар, сөөгөн ширгэнэ)	4.1. Тариалангийн талбай
1.2. Уур амьсгалын аялал-рекреацийн үнэлгээ	2.2. Түүх-соёлын дурсгалт газар	3.2. Хот болон байнгын оршин суух газарт ойрхон эсэх	4.2. Одоо байгаа хот суурин газар
1.3. Гадаргын ус-рашааны аялал-рекреацийн үнэлгээ		3.3. Тохижилтын түвшин	4.3. Уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай
1.4. Био нөөцийн аялал-рекреацийн үнэлгээ			4.4. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн онгон болон онцгой бүс
1.5. Ландшафтын гоо зүйн үнэлгээ			

Тухайн орон нутаг, бүс нутгийн ландшафт, байгаль, түүх, соёлын дурсгалт, дэд бүтэц, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Байгалийн аялал- рекреацийг хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээ”-г боловсруулна. Байгалийн аялал- рекреацийг хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээг 3 шатлалтай ангиллаар нийт 4 үндсэн, 27 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.


*Схем №5.3. Ландшафтын үнэлгээний схем*



Хүснэгт № 31. Аялал жуулчлалын газарт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	19759.14	5.28
Хязгаарлагдмал тохиромжтой	326954	87.43
Тохиромжгүй	24103.1	6.45





### Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

**Экологийн бүс нутгийн үнэлгээний арга зүй:** Эко-бүс нутгийн үнэлгээ нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд: (1) тухайн судалгаанд хамрагдсан газрын биологийн олон янз байдлыг хамтатган төлөөлж чадахуйц зүйл, экосистем, бусад олон янз байдлыг илэрхийлэх сонгосон элементийг тодорхойлж, газрын зурагт буулгах; (2) хамгаалахаар төлөвлөж буй биологийн олон янз байдлын экологи, эволюцийн шаардлагыг удаан хугацааны туршид тэтгэхүйц тоо толгойн элбэгшил, тархацыг тооцсон зорилтыг дэвшүүлэх; (3) хамгаалахаар зорьж буй биологийн олон янз байдлын харьцангуй амьдрах чадвар, экологийн нийлэмж чанар, учрах аюул уршиг, тархац (бүлгэмдэл, популяци, экосистем гэх мэт)-ын төлөв байдлыг үнэлэх; (4) экологийн харьцангуй нийлэмж чанарыг илэрхийлэх, ирээдүйд учирч болох аюул уршгийн хамгийн бага эрсдэлийг даван туулж чадах, хамтдаа төлөөлүүлэн хамгаалах зорилтыг хангаж чадахуйц биологийн олон янз байдлын элементийн тохиолдлыг илрүүлэхэд дээр дурдсан мэдээллийг ашиглана.

#### **Экологийн бүс нутгийн үнэлгээний үе шатууд**

Экологийн бүс нутгийн үнэлгээ нь дараах үндсэн 5 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

#### ***I. Хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлыг тодорхойлох:***

Төлөвлөлт хийх багийг бүрдүүлж, тухайн экологийн бүс нутгийг төлөөлж чадах экосистем, бүлгэмдэл, амьтан ургамлын зүйлүүдийг тодорхойлно.

#### ***II. Мэдээлэл цуглуулж, зураглалд оруулах:***

Хамгаалахаар сонгосон экосистем, бүлгэмдэл, амьтан ургамлын зүйлүүдийн байршил, одоогийн тоо толгойн төлөв байдлын талаарх мэдээлэл цуглуулж, зураглалд оруулна.

#### ***III. Хамгаалах зорилтыг тогтоох:***

Хамгаалах биологийн олон янз байдлын экологи, эволюцийн шаардлагыг хангаж чадахуйц тархац нутаг, тоо толгойг харгалзан хамгаалах зорилтыг дэвшүүлнэ.

#### ***IV. Амьдрах чадварыг үнэлэх:***


Хамгаалах шаардлагатай экосистем, бүлгэмдэл, амьтан ургамлын зүйл тус бүрийн одоогийн төлөв байдлыг тодорхойлсны үндсэн дээр харьцангуй хүний үйл ажиллагаанд бага өртсөн газрыг тогтооно. Энэ үнэлгээг хийхдээ хүний нөлөөллийг орон зайн хувьд тогтоож, хамгаалах шаардлагатай зүйлийн одоогийн тархац нутагтай давхцуулах аргыг ашиглаж болно.

***V. Хамгаалах шаардлагатай газрыг сонгох:***

Дээр дурдсан мэдээлэлд үндэслэн бүс нутгийн биологийн олон янз байдлын төлөөллийг хамгаалахад чухал ач холбогдол бүхий чухал газруудыг тогтооно. Экологийн бүс нутгийн үнэлгээний үр дүнд тогтоосон хамгааллын ач холбогдолтой газруудыг “Хамгаалах шаардлагатай газрууд” эсвэл “Биологийн янз байдлын хувьд чухал газрууд” эсвэл “Экологийн хувьд чухал газрууд” гэх мэтчилэн ялгаатай нэрлэж болох хэдий ч агуулгын хувьд зайлшгүй хамгаалбал зохих чухал ач холбогдол бүхий газрууд гэж ойлгох хэрэгтэй юм. Хамгаалах газруудыг тогтооход "Марксан" зэрэг хамгааллын төлөвлөлт боловсруулахад хэрэглэдэг компьютерийн программ ашиглана.

*Хүснэгт №32. Хадгалан хамгаалах зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ*

<b>Үнэлгээ</b>	<b>Талбай, га</b>	<b>Эзлэх хувь</b>
Бусад газар ашиглалт	296413	79.26
Тохиромжтой	77564.79	20.74




**Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ**

Тухайн орон нутаг, бүс нутгийн ой- ургамалжлын муж, хошуу, өндрийн бүслүүр ангилалд үндэслэн гадаргын нөхцөл, хөрсний шинж чанарыг илтгэх үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээ”-г боловсруулна. Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээг байгалийн 3 өөр муж, 9 хошуу, өндрийн бүслүүрээр ялгаатай 22 ойн хэв шинжид үндэслэн нийт 3 үндсэн, 11 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.


<b>1.Газрын гадаргын үнэлгээ</b>	<b>2. Хөрсний физик-химийн хүчин зүйлийн үнэлгээ</b>	<b>3. Газар ашиглалтын нөхцөлийн үнэлгээ</b>
1.1. Газрын хэвгий; 1.2.Зүг зовхис 1.3.Гадаргын өнпдөршил	2.1.Хөрсний хэв шинж 2.2.Хөрсний механик бүрэлдэхүүн 2.3.Ялзмагт үеийн зузаан 2.4.Хөрсний ус нэвчүүлэх чадвар 2.5.Хөрсний ялзмагийн агууламж 2.6.Хөрсний урвалын орчин 2.7.Кальцийн карбонат 2.8.Хөрсний цахилгаан дамжуулах чадвар 2.9.Хөрсний чийг	3.1. Ой бүхий талбай; 3.2. Хот суурингийн газар; 3.3. Зам, шугам сүлжээний газар; 3.4. Тариалангийн талбай; 3.5. Уул уурхайн газар; 3.6.Гол горхи, нуур 3.7. Түүх соёлын дурсгалт газар;

Схем №5.4. Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээний



Хүснэгт № 33. Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	19946.25	5.33
Нэн тохиромжгүй	283155	75.71
Тохиромжгүй	70956	18.97




**Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ**

Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, инженер геологийн нөхцөл, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын үнэлгээ”-г боловсруулна.

Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын үнэлгээг хийхэд зураг 1-д тусгагдсан нийт 3 үндсэн, 6 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.

<b>1. Авто болон төмөр замын зориулалтаар ашиглаж болох газрын үнэлгээ</b>	<b>2. Цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалтаар ашиглаж болох газрын үнэлгээ</b>
1.1. Газрын гадаргын үнэлгээ	2.1. Газрын гадаргын үнэлгээ
1.2. Инженер-геологийн үнэлгээ	2.2. Инженер-геологийн үнэлгээ
1.3. Газар ашиглалтын суурь нөхцлийн үнэлгээ	2.3. Уур амьсгалын үнэлгээ
	2.4. Газар ашиглалтын суурь нөхцлийн үнэлгээ

Схем №5.5. Шугаман байгууламжийн тохиромжтой байдлын үнэлгээний







*Хүснэгт № 34. Цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ*

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	19944.63	5.33
Хүндрэлтэй	72119.97	19.28
Хэвийн	281889.7	75.38

*Хүснэгт № 35. Авто зам болон төмөр замын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ*

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	19946.25	5.33
Хүндрэлтэй	65589.75	17.54
Хэвийн	288441.8	77.13





### Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Тухайн орон нутаг, бүс нутгийн бэлчээрийн ургамлын анги, бүлэг төрөл, идэмж, байгалийн бүс бүслүүр, гадаргын нөхцөл, усан хангамж, бэлчээрийн хэв шинж зэрэг үзүүлэлтэд үндэслэн үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтиг нэгтгэн “Хадлан, бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ”-г боловсруулна. Хадлан, бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг бэлчээрийн ургамлын 250 анги, бүлэг төрлөөр 7 үндсэн үзүүлэлтэд үндэслэн гүйцэтгэнэ. /Схем №8.4./

<b>1.Хадлан авах газрыг сонгон шалгуур үзүүлэлт</b>	<b>3.Газар ашиглалтын суурь нөхцөлийн үзүүлэлт</b>
Га-аас авах ургац Шингэх уураг Тэжээлийн нэгж	Хот суурины эдэлбэр газар Ой Тариалангийн газар Уул уурхайн эвдрэлд өртсөн газар Гол нуур Авто зам

Схем №5.6

### Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний схем




Хүснэгт.№ 36. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /зун намрын улиралд


Өвөл-хавар	Талбай, га
------------	------------


	Адуу	Хонь	Тэмээ	Үхэр	Ямаа
Бусад газар ашиглалт	16217.82	16217.82	16217.82	16217.82	16217.82
Тохиромжгүй	6591.78	6586.92	6925.5	6949.8	6586.92
Дунд зэрэг тохиромжтой	358.02	542.7	8900.28	60516.72	542.7
Тохиромжтой	102396.15	92981.52	251020.62	228692.97	92981.52
Нэн тохиромжтой	249040.98	258275.79	91540.53	62227.44	258275.79

Хүснэгт № 37. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /өвөл-хаврын улиралд /


Зун-намар	Талбай, га				
	Адуу	Хонь	Тэмээ	Үхэр	Ямаа
Бусад газар ашиглалт	16217.82	16217.82	16217.82	16217.82	16217.82
Тохиромжгүй	1046.52	1020.6	6919.83	46442.16	1020.6
Дунд зэрэг тохиромжтой	5981.85	5929.2	115107.48	120778.29	5929.2
Тохиромжтой	30223.53	23440.59	197017.92	86405.94	23440.59
Нэн тохиромжтой	321135.03	327996.54	39341.7	104760.54	327996.54





























**Хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээ:**

Хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлыг тогтоохдоо байгалийн болон хүний хүчин зүйлсийг харгалзах нь зүйтэй. Үүнд:

***Байгалийн хүчин зүйлс***

1. Хонхор, хотгор газрын хэмжээ
2. Гадаргын урсцын чиглэл
3. Ус хурах талбай
4. Газрын хэвгий
5. Хөрсний ус нэвчиц хөрсний физик шинж чанар
  - а. Намагших буюу ус үл нэвчүүлэх гадарга – байгалийн тогтоц
  - б. Инженерийн хийц – ус үл нэвчүүлэх гадарга үүсгэх
6. Хур тунадасны хэмжээ
7. Ууршиц
8. Урсцын модуль
9. Ойн сан

***Хүний хүчин зүйлс***

1. Газар тариалан
2. Авто зам
3. Хот суурин
4. Уул уурхай
5. Газар ашиглалтын бусад хэлбэр

Мөн хөв, цөөрөм байгуулахад дараах онолын (conceptual) загварыг баримтална.





Схем № 8.7 Концепцийн (conceptual) загвар

Хамгийн гол хүчин зүйлс нь геоморфологийн шинж чанар, хур тунадас, голын урсцын оролтын хэмжээ, ууршицын гаралтын хэмжээ юм. Үүний дараа хөрсний ус нэвчиц бөгөөд үүнийг инженерийн шийдлээр багасгах боломжтой. Эдгээртэй зэрэгцэн гадаргын урсцын модуль болон ус хурах талбай нь хөв, цөөрөмд хуримтлагдах усны нөөцийн хэмжээг тогтооход нөлөөлнө.



Схем № 8.8. Хөв цөөрөм байгуулах тохиромжтой байдлын үнэлгээний схем





## Зургаадугаар бүлэг. ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН БҮСҮҮД, ТҮҮНИЙ НӨӨЦ, НӨХЦӨЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

### 6.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

#### 6.1.1. Тариалангийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт

Дэлхийн жишиг газар тариалан тогтвортой эрхэлж болох газар нутгийн дулааны баланс, жилийн хур тунадастай орнуудтай харьцуулахад монгол орон бүхэлдээ газар тариалан тогтвортой эрхлэх найдлага муутай бүсэд хамрагддаг. Гэвч хүн амыг хүнсний бүтээгдэхүүнээр хангах, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулах зорилгоор 1960-аад оноос газар тариаланг хөгжүүлж эхэлсэн юм.

Монголын нийгмийн тогтолцоо өөрчлөгдөн тариалан эрхлэдэг аж ахуйн нэгжийн эдийн засгийн хүчин чадал хомсдоноос болж газар тариалангийн үйлдвэрлэл уналтын байдалд орсон нь газар ашиглалтанд сөрөг нөлөө үзүүлж тариалах газрын хэмжээ 1990 оныхоос бараг 4 дахин буурчээ.

Үүнд нийгэм, улс төр, эдийн засагт гарсан өөрчлөлтийн зэрэгцээ хөрсний үржил шимийн бууралт, цаг агаарын хуурайшилт зэрэг нь тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэх үндэстэй юм.

Сүмбэр сумын хүн амын хэрэгцээнд зориулж 2022 онд 506.9 тн гурил, 830.1 тн гурилан бүтээгдэхүүн, 713.8 тн төмс, 1019.8 тн хүнсний ногоо, 917.8 тн жимс, жимсгэнэ худалдаж байх шаардлага гарна. Хүн амд шаардагдах хүнсний бүтээгдэхүүний нийт өсөлт нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хүнсний аж үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлыг тодорхойлно.

Хүн амын өсөлт, хүнсний хэрэгцээнээс хамаарч газар тариалан эрхлэх бүс нутаг ба тариалангийн газрын байршил, хэмжээг тогтоох ажил юу юунаас чухал асуудал байдаг. Тиймээс бид хүн амын ердийн өсөлтийг 5 жилээр авч үзсэн бөгөөд тэрхүү үе шатанд шаардагдах тариалангийн эргэлтийн талбайг тооцож үзсэн юм. Ийнхүү тооцоход 2018 оноос жилд 10.7 га-д төмс, 115.9 га-д үр тариа, 11.5 га-д хүнсний ногоо, 41.5 га-д жимс, жимсгэнэ тариалж нийт 179.6 га эргэлтийн талбайтай байх хэрэгцээ гарч байна. 2022 он гэхэд жилд 197.6 га талбайд төмс, хүнсний ногоо, үр тариа, жимс, жимсгэнэ тариалах тооцоо байна. Мөн төлөвлөлтийн эцэст буюу 2022 онд нийт 939.8 га тариалангийн эргэлтийн талбайтай байж Сүмбэр сумын тэр үеийн хүн амын хүнсний хэрэгцээг хангах шаардлагатай болж байна.

**Хүснэгт 44. Газар тариалангийн үйлдвэрлэлд шаардлагатай газрын тооцоо**

№	Төрөл	Шаардлагатай нийт үйлдвэрлэл /мянган тн/	Жилд тариалалт хийх шаардлагатай талбай /га/	Шаардлагатай нийт эргэлтийн талбай /га/
2018 он	Төмс	649.5	10.7	179.6
	Хүнсний ногоо	927.9	11.5	
	Үр тариа	463.9	115.9	
	Жимс, жимсгэнэ	835.1	41.5	
	<b>Бүгд</b>	<b>2876.4</b>	179.6	
2019 он	Төмс	659.1	10.9	182.5
	Хүнсний ногоо	941.7	11.8	
	Үр тариа	470.8	117.7	
	Жимс, жимсгэнэ	847.5	42.2	
	<b>Бүгд</b>	<b>2919.1</b>	182.5	
2020 он	Төмс	679.1	11.2	188.0
	Хүнсний ногоо	970.1	12.1	
	Үр тариа	485	121.2	
	Жимс, жимсгэнэ	873.1	43.4	
	<b>Бүгд</b>	<b>3007.3</b>	188.0	
2021 он	Төмс	693.9	11.5	192.1
	Хүнсний ногоо	991.3	12.4	
	Үр тариа	495.6	123.9	
	Жимс, жимсгэнэ	892.2	44.4	
	<b>Бүгд</b>	<b>3073</b>	<b>192.1</b>	
2022 он	Төмс	713.8	11.8	197.6
	Хүнсний ногоо	1019.8	12.7	
	Үр тариа	509.9	127.4	
	Жимс, жимсгэнэ	917.8	45.7	
	<b>Бүгд</b>	<b>3161.3</b>	197.6	
<b>Нийт</b>		15037.1		<b>939.8</b>

*Хүснэгт 38. Цаашид газар тариалан шинээр хөгжүүлэх саналтай газрын тохиромжтой байдлын үнэлгээ*

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	19946.25	5.33
Нэн тохиромжгүй	6.48	0.0001
Тохиромжгүй	3969.81	1.06
Хязгаарлагдмал тохиромжтой	204537.9	54.69
Тохиромжтой	104015.3	27.81
Нэн тохиромжтой	41501.97	11.10

**Усалгаатай газар тариалан эрхлэх**

Говьсүмбэр аймаг нь говийн тариалангийн бүсэд хамаардаг бөгөөд байгаль цаг уурын онцлог нөхцлөөс шалтгаалж усалгаатай газар тариаланг хөгжүүлэхэд илүүтэй анхаарвал зохино.

Тус аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр жилдээ дунджаар 100 мм орчим хур тунадас ордог гэсэн дүн мэдээ байна. Энэ нь бүрэн усалгаатай нөхцөлд газар тариалан эрхлэх шаардлагатайг харуулж байна. Хур тунадас бага унадаг, цаг уурын хувьд гандуу, чийг дутагдалтай нөхцөлд усалгаатай тариалан эрхлэх нь баталгаатай өндөр ургац авч газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх гол үндэс суурь болохоос гадна хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, МАА-г тэжээлээр хангахад ихээхэн нөлөөтэй юм.

Усалгаатай нөхцөлд жимс жимсгэнэ, төмс, хүнсний ногоо, гуатан, тэжээлийн ургамлыг үрийн ба хүнс тэжээлийн чиглэлээр тариалах боломжтой.

Ургамлын амьдралд нөлөөлөх гол хүчин зүйл нь ус чийг байхаас гадна дулааны хангамж чухал үзүүлэлт юм. Үр ургахад температур хэдий чинээ тохиромжтой бол үр төдий чинээ түргэн ургаж, түргэн соёолно. Ихэнх таримал ургамлын үр 20-30°C-д хамгийн түргэн ургана. Ургамал нь хөгжлийн янз бүрийн үе шатандаа дулааныг харилцан адилгүй шаарддаг ба буудай, арвай, овъёос зэрэг үр тарианы ургамлууд хөгжлийнхөө эхний үед дулаан нөхцлийг бага шаардах бөгөөд цаашид нэмэгдэн цэцэглэлтийнхээ үед дулаанд хамгийн өндөр шаардлага тавьж үрийн боловсрох үед дулааны шаардлага дахин буурдаг.

Усалгаатай нөхцөлд хөрсийг хавар юмуу намар боловсруулдаг. Ингэж хавар эрт намар орой болсон хойно хөрсийг хавар намрын хагалгаагаар боловсруулахад хэдийгээр хөрс тохиромжтой чийгтэй байх боловч дулаан дутагдалтайгаас микроорганизмын үйл ажиллагаа суларснаас буюу зогссоос хөрсөнд хөдөлгөөнт тэжээлийн бодис хүрэлцэхүйц хэмжээтэй хуримтлагдаж чадахгүй. Ийм учраас аль болох дулаан үед намар эрт хөрсийг боловсруулах хэрэгтэй. Хөрсний ихэнх ашигтай микроорганизмын амьдралын үйл ажиллагаа хөрсний температур 30-35 байхад хамгийн идэвхтэй явагдана. Хөрсний температурын хэлбэлзэл бага байх нь микроорганизмын амьдралд тохиромжтой.

### ***Тариалангийн талбайг услах арга, техник***

Ус нь бусад бүх шингэний адил урсамтгай чанартай учираас түүнийг суваг

шуудуу, турба хоолойгоор газрын гадаргын дурын цэгт хүргэж болно.

Орчин үед усалгаатай тариаланд усалгааны хэд хэдэн аргыг хэрэглэж байна.

1. Гадаргаар услах арга: Энэ нь усыг өөрийн урсгалаар нь талбайд урсгаж услах.
2. Бороожуулан услах арга: Энэ нь усалгааны ус бороо хэлбэрээр талбайд цацагддаг.
3. Хөрсөн доороос нь услах: Энэ нь хөрсөн дор байрлуулсан тусгай хоолой төхөөрөмжийн тусламжтайгаар хөрсийг доороос нь чийглэж услана. Энэ арга нь одоогоор манайд хэрэглэгдээгүй байна.
4. Дуслын усалгаа: Энэ нь усыг дусал байдлаар бага хэмжээгээр өгч ургамлын үндэсний систем орчмын хөрсийг байнга чийглэж өгдөг усалгаа юм.

5. Турба хоолой, шлангийг ашиглан даралттай усаар талбайг услах:

Орчин үед усалгааг ихэвчлэн бороожуулагч машины тусламжтайгаар усалж байгаа боловч гар усалгааг ашигласаар байна. Ер нь гар усалгааг бороожуулагч усалгаатай хослуулан хэрэглэх нь ашигтай. Усалгааны аргыг услах талбайн тэгш эсэх, хөрсний ус нэвтрүүлэх чадвар, газар доорхи усны орших төвшин зэргээс хамааруулан сонгох ёстой.

Усыг талбай дээгүүр тараан хөрсөнд шингээж услахыг гадаргуугийн усалгаа гэнэ. Гадаргаар усалгааг явуулахад усны зарцуулалт их, ус нь хөрсний доод үе давхарга руу алдагдах нь их, ус талбайд жигд тархахдаа муу байдаг.

#### ***Усны эх булаг, түүнээс ус авах арга.***

Услах системийг усаар хангах үндсэн элемент нь усны эх булаг бөгөөд түүнээс хамааруулж тариалах талбайн хэмжээ, уг системийн техникийн онцлогийг шийдвэрлэнэ.

Усны эх булагт гадаргуугийн ба газрын доорхи ус мөн ахуйн бохир ус ашиглагдана. Эдгээрийн дотроос хамгийн өргөн дэлгэр ашиглахад дөхөмтэй нь гол горхи, нуур цөөрөм зэрэг гадаргуугийн ил ус (гол горхи, нуур гэх мэт) юм. Гэвч ил ус газар бүр харилцан жигд тархаагүй, тархсан ч усны нөөц нь усалгаанд шууд авахад хүрэлцээгүй байдаг.

Ийм учраас байгалийн аль боломжтой нөхцлийг ашиглан усан сан, цөөрөм байгуулах, гол горхи, булгийн усыг хуримтлуулж, түүнийгээ хуваарилан ашиглах нь ач хобогдолтой бөгөөд боломжтой юм. Гэхдээ орон нутгийн хүчээр усалгаа явуулах боломжийг ашиглах нэрийдлээр урьдчилан тооцоо, үндэслэлгүйгээр усыг дурын

газраар хамаагүй тавьж урсгах, суваг шуудууны хэвгийг тохируулахгүй ухуулах, шаардлагатай барилга байгууламжийг хэрэглэхгүй байх, услах бүдүүвчийг зөв сонгож авахгүйгээр ажлыг эхлэх зэрэг зүй бус үйлдэл нь хөрсийг эвдрэлд оруулан, ганга, жалга үүсгэж, хөрсийг угааж үгүй хийх, давсжуулах, намагжуулах, усны горимыг алдагдуулах зэрэг хэзээ ч нөхөшгүй хохиролд учруулдаг гэдгийг анхаарч энэ ажилд тун болгоомжтой хандвал зохино.

### ***Гадаргаар услах арга, техник***

Гадаргуугийн усалгааг хөрсний усны түвшин 3 м-ээс дор сул ба дунд зэргийн ус нэвтрүүлэх чадвартай хөрс бүхий тэгш талбайтай газар ашиглана. Хөрсний гадаргуугаар услах арга нь хэд хэдэн хэлбэртэй байна. Үүнд:

1. Шангаар услах / ариг /
2. Зурвасаар услах
3. Халиаж услах,
4. Лиманаар услах,
5. Бороожуулж услах,
6. Дуслаар услах.

### **Хаа-н таримлын усалгаанд хаягдал усыг ашиглах**

Аль ч улс оронд хүн ам олноор өсч, аж үйлдвэр ХАА-н хөгжилд жилээс жилд эрчимтэй явагдан хот, суурин олноор бий болж хотын оршин суугчдын ахуйн хэрэглээ өсч байгаа нь цэвэр усны хэрэглээг нэмэгдүүлж энэ хэрээр хаягдал усны хэмжээ ихсэж байна.

Хаягдал ус гэдэг нь үйлдвэр болон ахуйн хэрэглээнд ашиглагдан улмаар түүний хаягдлыг агуулж байгаа ус юм.

Хаягдал ус нь органик ба эрдэс бодисоор бохирдсон байна. Органик хэсэг нь янз бүрийн бичил биетнүүд, ургамал ба амьтны үлдэгдэл, химийн бусад нэгдлүүд орно. Хүн амьтанд өвчин үүсгэгч бичил биетнүүд ч агуулагдаж байна. Эрдэс хэсэг нь үйлдвэрийн янз бүрийн хаягдал, давсны уусмалууд, элс, шаварлаг хэсгүүд орно.

Бохирдуулж байгаа зүйлүүд нь хатуу ба ууссан байдлаар агуулагдаж байна. Иймд хатуу зөөвөрлөгдсөн хэсгийг механик аргаар цэвэрлэх боломжтой. Харин органик нэгдлүүдийг бичил биетний тусламжтайгаар задалж эрдэсжүүлэх ёстой.

Хаягдал ус нь гарал үүслээсээ хамаарч бордооны ач холбогдолтой байна. ОХУ-ын

эрдэмтэн Ю.П.Беличенко, Л.Я.Поляников (1979) нарын судалгаанд 1 м<sup>3</sup> хотын хаягдал ус нь азот 80 кг, кали 15 кг, фосфор 15 кг, кальц 80 кг агуулж байна. Энэ нь 10-15 тн бууцтай тэнцэх хэмжээ юм.

Хаягдал ус нь хөрсний үржил шимийг сайжруулан ургацыг нэмэгдүүлдэг. Хаягдал усаар усалгаа хийхдээ ус нэвтрүүлэх чадвар, агааржилт сайтай элсэн, хөнгөн элсэн ашиглалт багатай хаягдмал талбайг ашиглах нь илүү зохистой. Хаягдал усаар усалгаа хийхэд голдуу их нормоор усалдаг учраас шаварлаг ус нэвтрүүлэх чадвар муутай шаварлаг хөрс тохиромж муутай. Хаягдал усыг гүний ус 1.2 м-ээс ойр оршдог талбайд хэрэглэж болохгүй энэ тохиолдод хөрс давсжих, намагжих болно. Ялангуяа артезийн болон бусад худаг, булаг, шандыг бохирдуулахыг эрс хориглоно.

Хаягдал усыг усалгаанд ашиглахдаа дараах зүйлд анхаарах ёстой.

- Эмнэлэг эрүүл ахуйн шаардлагыг хангах
- Хаягдал ус гадагш алдахгүйгээр далан хаалтыг хийсэн байх
- Хүн амын оршин суугаа газраас 250-300 метрээс баггүй зайд байх
- Ажилагсадын амрах, хооллох, хувцас, багаж хэрэгслэлийг хадгалах тусгай байруудтай байх
- Ажиллагсад нь хаягдал усаар усалгаа хийх эмнэлэг-ариун цэврийн дүрэм журмыг мэддэг байх
- Ургацыг хураахын өмнө усалгааг хүнсний ногоонд 20 хоног, жимс жимсгэнд 2 сар, бусад тарималд 14 хоногийн өмнө зогсооно.

Гарал үүслээр нь хаягдал усыг ахуйн, үйлдвэрийн, холимог, мал аж ахуйн, үерийн гэж ангилдаг.

**Ахуйн хаягдал ус** гэдэг нь орон сууц, халуун усны ба угаалгын газар, гуанз хоолны газрууд зэрэг ахуйн газруудын хаягдал ус юм. Энэ ус нь биокарбонат-сульфатын давс агуулсан саармаг ба сул шүлтлэг урвалтай, эрдэсжилт багатай, бордох чадвар сайтай ялангуяа азотыг нилээд агуулсан ус юм. Судалгаанаас үзэхэд 1л ахуйн ус нь 30-80мг азот, 5-20мг фосфор, 6-30мг кали, 30-100мг кальцийг агуулна. Ахуйн хаягдал усанд ходоод, гэдэсний өвчин үүсгэгч агуулагдаж байх тул энэ усыг ургамалд хэрэглэхийн өмнө механик цэвэрлэгээ хийхээс гадна байгалийн нөхцөлд цөөрөмд хэдэн цаг байлгах шаардлагатай.

**Аж үйлдвэрийн хаягдал ус** гэдэг нь үйлдвэрүүдээс хаягдаж байгаа ус юм. Химийн



бүтэц чанараараа янз бүр байна. Үйлдвэр бүр өөрийн технологийн онцлогоос хамаарч янз бүрийн бүрэлдэхүүнтэй усыг гадагш хаядаг байна. Үйлдвэрийн хаягдал усанд янз бүрийн бодис агуулагдахаас гадна үндсэндээ хүн ба ургамал, амьтанд хортой бодисууд агуулагдана. Үйлдвэрийн хаягдал усанд нүүрс, хүдэр олборлох явцад гарсан гарсан уурхайн ус орно. Уурхайн ус нь эрдэс бодис, хий, органик бодис зэргийг агуулсан гүний ус юм. Эрдэжилт нь 1 литрт 3-5 г байна. Сульфатын давс голдуу агуулна. Бордох чадвар муутай. 1 литрт 10 мг азот, 3-20 мг кали агуулагдана. Уурхайн ус нь эрдэжилт ихтэй ялангуяа сульфат, хлоридыг нилээд агуулдаг тул усалгаанд хэрэглэхдээ хөрсөнд давс хуримтлагдахаас болгоомжлох хэрэгтэй.

**Мал аж ахуйн хаягдал ус** нь шингэрүүлсэн бууц, тэжээлийн хаягдал, үлдэгдэл, малыг угаах түүний бүтээгдэхүүн боловсруулахад хэрэглэсэн ус юм. Энэ нь байран малалгааны үед гардаг ус юм.

Мал аж ахуйн комплексоос гарч байгаа энэ ус нь 1 литрт 1.3-2 г давс агуулахаас гадна азот 5000, фосфор 2500, кали 4500 мг-ыг 1 л усанд агуулж байдаг тул бордооны их ач холбогдолтой ус юм. Натрын катионы кальц магнийн катионы нийлбэрийн харьцаа их тохиромжтой байдаг. Харин өвчин, эмгэг үүсгэгч бичил биетнүүд агуулагдах тул ариутгаж хэрэглэх нь тохиромжтой.

Мал алж ахуйн хаягдал усан дахь химийн нэгдлүүд нь хөрсөнд түргэн задардаг онцлогтой. Мал аж ахуйн хаягдал усны тундас нь бууцнаас илүү ач холбогдолтой бордоо болно. Түүнд 2.9-4.5% азот, 1.2-2.7% фосфор, 0.2-0.5% кали агуулагдана.

**Үерийн хаягдал ус** нь бороо, цасны ус болон орон сууц, үйлдвэр аж ахуйн газраас орж ирсэн ус юм. Түүнд элс, тоос, шавар зэрэг механик хольц их агуулагдана. Энэ ус нь бордооны ач холбогдол багатай юм. Гэвч механик цэвэрлэгээ хийсний дараа ХАА-н таримлын усалгаанд хэрэглэнэ. Урьдчилсан цэвэрлэгээ хийсний дараа усалгаанд хэрэглэгдэнэ.

Хаягдал усанд агуулагдах хорт бодисын зөвшөөрөгдөх хэмжээ нь 1 л усанд доорх хэмжээтэй байна. Үүнд: хлорид 300, сульфат 500, метанол 200, сод 100-200, фепол 40, цианид 10, нигритүүд 0.5 мг, мышьяк 0.2мг байна.

**Хаягдал усыг усалгаанд ашиглах** ажлын үр ашиг нь таримал, сорт, тариалж байгаа хөрс, цаг уурын нөхцлөөс хамаарна. Хаягдал ус цэвэрлэх байгууламжаас ирж байгаа ус нь цагаан хорхойн өндөгөөс бүрэн цэвэрлэгдээгүй эмнэлэг-ариун цэврийн шаардлага хангаагүй байдаг учраас ариун цэврийн дүрэм, журмыг сайтар хэрэгжүүлэх хэрэгтэй байдаг. Ялангуяа тарвас, амтат гуа зэрэг гуатан болон хүнсэнд шууд

хэрэглэгдэх хүнсний ногоо, жимс жимсгэнийг хаягдал усаар услахыг хориглоно.

Тэжээл, техникийн болон мод бутлаг ургамлыг хаягдал усаар услах нь зохистой. Харин их нормоор услах шаардлагатай тул үр тариа нь ихээр налдаг онцлогтой. Хаягдал усаар олон наст өвсийг услах нь илүү зохистой бөгөөд эдгээр ургамал нь чийгийг илүү их шаарддагаас гадна азотыг нилээд шаарддаг тул энэ хэрэгцээг нь хаягдал усаар хангах боломжтой.

Олон наст соргүй согоовор, дурвалаг, үнэгэн сүүл, нугын ботуул зэрэг үет ургамлууд хошоонгор, хөх царгас зэрэг олон наст буурцагт ургамлуудыг тэжээлд тарих нь илүү зохистой юм. Эдгээрээс 10-13 жилийн турш өндөр ургац авах боломжтой.

Судан өвс нь хаягдал усаар услахад тохиромжтой бөгөөд дулаан нутгуудад 3-4 удаагийн хадалт хийж ногоон масс хураах боломжтой. Уурхайн усаар үндэс үртэн, царгасыг услах нь зохистой бөгөөд мал аж ахуйн хаягдал усыг тэжээлийн олон наст өвс, эрдэнэшиш, үндэс үртэнг услахад ашиглаж байна.

Хаягдал усыг усалгаанд ашиглахад таримлын усалгааны горим нь нилээд онцлогтой байна. Үүнд:

- Энэ ус нь ургамлын өсөлт, хөгжилт, хөрсний чийгийн хэрэгцээг хангах гол хүчин зүйл болно
- Хаягдал ус нь шим тэжээлийн бодисыг агуулж байх ёстой Хлорид, сульфат, карбонат зэрэг эрдэс давсуудыг агуулж байдаг учираас эдгээрийн илүүдэл нь хөрс давсжих, хөрсний үржил шим буурхад нөлөөлнө
- Аж үйлдвэрийн хаягдал ус нь хортой элемент, нэгдлүүдийг агуулж байдаг

Иймд хаягдал усаар усалгаа хийхдээ дээрх онцлогуудыг харгалзан үзэх ёстой. Усалгааны усны концентраци түүнд агуулагдаж байгаа бодисын хэмжээ нь зөвшөөрөгдсөн хэмжээнд байх ёстой.

Усалгааны норм, хугацаа нь тухайн таримлын биологийн онцлогоос хамаарна. Ургалтын хугацааны усалгааны норм нь 200-500 м<sup>3</sup>-га байна. Ихэвчлэн бага нормоор услах нь зохистой. Энэ тохиолдолд хаягдал усанд агуулагдаж байгаа шим тэжээлийн бодисын ашиглалт сайжирч, хортой нөлөөг багасгах процесс түргэсгэнэ.

Хаягдал усаар усалгаа хийхдээ гадаргаар болон бороожуулагч, хөрсний доороос гэх мэт усалгаатай тариаланд хэрэглэж байгаа бүх аргаар услаж болно.

Хаягдал усаар усалгаа хийх талбайн хөрсийг аль болох гүн хагалж боловсруулана. Ингэснээр хаягдал усанд агуулагдаж байгаа шим бодис эрчимтэй түргэн эрдэсжихээс гадна зохистой ус агаарын горим бий болдог. Усалгаа бүрийн дараа сийрүүлэлтийг гүн хийхээс гадиа талбайн тэгшилгээг сайн хийх ёстой. Мал аж ахуйн хаягдал ус нь бордооны их ач холбогдолтой учраас ургацыг 4-6 дахин нэмэгдүүлж байна. Хаягдал усыг усалгаанд ашиглахдаа байгаль орчинг бохирдуулахгүйгээр биологийн цэвэр бүтээгдэхүүн авахад анхаарвал зохино.

#### **Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх талаар гаргасан зөвлөмж**

1. Говьсүмбэр аймгийн хүн амын өсөлт, хүнсний хэрэгцээнээс дүгнэлт хийхэд хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, боловсруулах, ханган нийлүүлэх үйл ажиллагааг уялдуулан эрчимтэй хөгжүүлэх асуудлыг дэвшүүлж байна. Иймээс агропаркийн цогцолборыг зохистой байгуулахын тулд бодлогоор дэмжин иргэд, аж ахуйн нэгж, байгууллага болон гадаад, дотоодын төсөл арга хэмжээ, зээл тусламжтайгаар зохион байгуулах нь зүйтэй.
2. Усалгаатай газар тариалан эрхлэлтийг дэмжиж усалгааны худгийн цахилгааны зардлыг хөнгөлөх, чөлөөлөх, бүтээгдэхүүн борлуулсан зардлаас төлүүлэх /дараа төлбөрт ашиглалт/ гэх зэрэг урамшууллыг бодлогоор дэмжих нь зүйтэй байна.

#### **6.1.2. Хадлангийн газрын төлөвлөлт**

Говьсүмбэр аймгийн Газрын нэгдмэл сангийн тайланд бүртгэлтэй хадлангийн талбай Сүмбэр сумын 6-р багийн нутаг дэвсгэрт байх ба нийт 7810 га талбайтай. Энэ талбайг хур тунадас унасан өнтэй жилд хадланд ашигладаг ба хээр талын хадлан гэсэн ангилалд ордог. Хадлангийн ургацыг сайжруулах явдал нь уг талбайг ээлж дараатай зөв ашиглах, арчлалт, хамгаалалтын ажлыг сайн хийснээс шалтгаална.

Хадлангийн талбайн сайжруулалтыг өнгөн хөрсний ба үндсэн сайжруулалт гэсэн 2 аргаар хийнэ. Хадлангийн талбайн чулуу, бургас, бутыг цэвэрлэх, дов сондуулыг тэгшлэх, нэмэлт үр цацах, борнойдох бордох зэрэг арчлалт хийж өнгөн хөрсийг сайжруулах арга хэмжээ авах нь зүйтэй. Мөн хөрс боловсруулж хадлангийн ургамлыг шинээр тарих, услах суваг шуудуу татах зэргээр үндсэн сайжруулалт хийдэг.

Хадлангийн талбайг услах түүнд цас тогтоож чийг хуримтлуулах, бордох нь хадлангийн талбайн ургацыг нэмэгдүүлэх чухал арга хэмжээ юм. Мөн хадлангийн талбайг зөв зохистой ашиглах нэг чухал асуудал бол хадланг ээлжлэн хадах юм.

Экологийн харилцан адилгүй нөхцөлд олон зүйл ургамлаас бүрддэг байгалийн хадланг бэлтгэхдээ юуны өмнө ургамал ургалтын хугацааг нарийн баримталж өсөн хөгжих, үр боловсрох хугацааг нарийн харгалзан ашиглах шаардлагатай байдаг.

Говьсүмбэр аймгийн хадлангийн талбайг нэг удаа хадаж ашигладаг ба 4 хэсэг болгон хувааж хэсэг бүрийг ашиглах, тэдгээрт зохицсон нарийн хуваарийг 4 жилийн эргэлттэйгээр дараах байдлаар төлөвлөлөө.

Хүснэгт 41. Хадлангийн сэлгээ хийх төлөвлөлт

Ашиглалтын жил	I	II	III	IV	Хадлангийн талбайн хэмжээ /га/
Эхний жил	Түрүүлэлт	Цэцэглэж бүрэн гүйцэх	Цэцэглэлт	Үр боловсролт	1952.5
2 дахь жил	Цэцэглэлт	Үр боловсролт	Түрүүлэлт	Цэцэглэж бүрэн гүйцэх	1952.5
3 дахь жил	Үр боловсролт	Цэцэглэлт	Үр боловсролт	Түрүүлэлт	1952.5
4 дахь жил	Цэцэглэж бүрэн гүйцэх	Түрүүлэлт	Цэцэглэж бүрэн гүйцэх	Цэцэглэлт	1952.5

Хадлангийн ургацын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд 4-5 жилд 1 удаа 40-60 т/га малын өтөг бууц болон азот, фосфорын бордоогоор бордоно. Түүнчлэн мал хотлуулж бордох нь хамгийн хямд төсөр арга юм.

Мөн Говьсүмбэр аймагт хур бороотой жил ургамлын гарц сайн гардаг бэлчээрийн газраас хадаж болох хадлангийн талбайг шинээр бий болгохоор Сүмбэр суманд нийт 11218 га-г, Баянтал суманд нийт 2104 га талбайг тус тус төлөвлөж байна.

Хүснэгт 42. Төлөвлөж буй хадлангийн талбайн байршил, нөөц

№	Сумын нэр	Талбайн байршил	Талбайн хэмжээ /га/	Га-ын ургац /цн/	Тэжээлийн нөөц цн/га	Хадах хугацаа
1	Баянтал 2-р баг	Давайн тал	1125	7.2	8100	IX.01-IX.15
2	Баянтал 2-р баг	Давайн хоолой	979	6.8	6657.2	IX.01-IX.15
3	Сүмбэр 6-р баг	Бөөндөрийн хоолой	4504	9.1	40986.4	IX.01-IX.15


4	Сүмбэр 6-р баг	Наран	2236	6.3	14086.8	IX.01-IX.15
6	Сүмбэр 4-р баг	Хэрээгийн хонхор	2349	7.1	16677.9	IX.01-IX.15
	Бүгд		13322		109927.3	

Малчид өвөлжөө, хаваржааныхаа ойр орчимд таримал хадлан бий болгож гаднаас үнээр худалдаж авалгүй өөрсдийн хэрэгцээгээ хангах боломжтой. Таримал хадлангийн нийт ургамлын 60 хувь нь буурцагт ургамал, 40 хувь нь үетэн байхаар бодож үрээ хольж тарих нь зүйтэй. Ингэхдээ үрийн норм нь царгас 4-5 кг/га, ерхөг 5-6 кг/га байх ба хавар 5 сарын 20-ны үеэр тариалбал тохиромжтой.

Хадлангийн талбайг бордох, услах, цас, борооны ус ашиглах, голоос шуудуу татах, өвөл ус халиаж, тошин гүйлгэх, цас, мөс тогтоох зэрэг олон аргаар сайжруулж болно.

Хүснэгт 43. Таримал тэжээл ашиглахад малыг хонинд шилжүүлэх коэффициент

Үзүүлэлт	Хонь		Үхэр		Ямаа	Адуу	Тэмээ
	Нутгийн	Цэвэр эрлийз	Нутгийн	Цэвэр эрлийз			
Хонин толгойд шилжүүлэх коэффициент	1.0	1.2	6.0	8.0	0.9	6.6	5.7



### 6.1.3. Бэлчээр зохион байгуулалтын төлөвлөгөө

Бэлчээрт хамгийн их нөлөөлөл үзүүлж буй хүчин зүйл нь малын тоо толгойн өсөлт байна. Бэлчээрийн ургамлын бүтцийн өөрчлөлтөнд хүн, мал амьтны үйл ажиллагаа ихээхэн нөлөөтэй. Иймээс бэлчээр ашиглалтыг зохицуулахдаа түүний даацыг нарийн тохируулах шаардлагатай юм.

#### Сүмбэр сумын бэлчээрийн даац /багаар/

№	Багийн нэр	Талбай н хэмжээ	1 га ургацын хэмжээ цн/га	Бэлчээрийн н нөөц цн/га	1 хонины жилд идэх өвсний хэмжээ /цн	Бэлчээр ийн даац хонин тол	Бэлчээрт байгаа малын тоо	Бэлчээрийн даац хэтэрсэн эсэх -+ %
1	Тэвш 4-р баг	115008.0	0.9	103507.2	5.6	18483	110953.7	-6.0
2	Уулзвар 5- р баг	102451.3	0.9	92206.2	5.6	16465	118600.5	-7.2
3	Малах 6-р баг	65588.0	1.4	91823.2	5.6	16397	152 391	-9.3
	<b>Нийт</b>	<b>283047.3</b>		<b>283047.3</b>	<b>5.6</b>	<b>50544</b>	<b>381945.3</b>	-7.6

Сүмбэр сумын бэлчээрийн даац дунджаар 7.6 дахин хэтэрсэн ба үүнээс 4-р баг 6 дахин, 5-р баг 7.2 дахин, 6-р баг 9.3 дахин даацыг хэтрүүлэн ашиглаж байна. Үүнээс харахад цаашид Сүмбэр суман дахь аймаг дундын отрын бэлчээрт мал оторлуулах, өөр аймаг сумын мал оруулах боломжгүй болсон байна.

#### 6.1.3.1. Бэлчээрийг улирал, сараар сэлгэн ашиглах төлөвлөгөө

Говьсүмбэр аймгийн хэмжээгээр нийт 90814 га бэлчээр газар бага зэргийн талхагдалд орсон байна. Үүнээс Сүмбэр суманд 51471.9 га бэлчээр байна.

Эдгээр бэлчээрийн газруудад бэлчээрийн ургамлын сэргэн ургалтыг дэмжих үүднээс бутлалын болон үр боловсрох үеэр бэлчээрийг аль болох хөнгөн ашиглах, ачааллыг бууруулах зорилгоор энгийн хуваарьтай ашиглах.

Энгийн хуваарьтай ашиглалтыг нэвтрүүлж, бэлчээрээ 5-7 хэсэгт хувааж шон, чулуун овоо босгох, байгалийн таних тэмдгийг ашиглан ээлжлэн ашиглах, байнгын хариулгаар малаа бэлчээрлүүлэх. Бутлалтын болон үр боловсрох үеэр бэлчээрийг аль болох чөлөөлөх зорилгоор сарын хугацаанд 2 талбайт сэлгээг нэвтрүүлэх шаардлагатай. Бэлчээр хүрэлцээтэй нөхцөлд 1 зуны турш ашиглалтаас чөлөөлөх нь үр дүнтэй.

## Хүснэгт 44. Улирал, сараар сэлгэн ашиглах бэлчээр

№	Багийн нэр	Газрын нэр	Талбайн хэмжээ /га/	Төлөвлөж буй арга хэмжээ	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа /он/
1	6-р баг	Их уулаас урагш Тэрэг толгой орчим	13557	Улирлаа р сэлгэх	Бэлчээрийг улирлаар сэлгэн ашиглах тухай нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр гаргах. Үүний дагуу малчидтай бэлчээрийг улирал, сараар сэлгэх 3 талт гэрээ байгуулах. Шийдвэр ба гэрээний биелэлтэд багийн Засаг дарга нар хяналт тавих. Гэрээний биелэлтийг дүгнэж урамшуулал болон хариуцлага тооцох.	2018
2		Их цагаан толгой орчим				2019
3	5-р баг	Дөрвөлжин толгойгоос баруун арагш Өгөөмөр толгой-Шар бүрдийн хоолой	8529.9			2019
4		Ар цагааны голын орчим				2020
5	4-р баг	Мөнхийн улаан нуур орчим	6341			2018
6		Эхэн эрэгцэгийн худаг Эрэгцэгийн ганц бууц худаг орчим	23044			2019
7		Найман толгойгоос урагш Шивээгийн ухаа	8529.9			2020
8		Сүүл толгойгоос зүүн тийш Улаан эрэг толгой-Эмээлт толгой орчим	13557			2021
	<b>БҮГД</b>		51471.9			

## 6.1.3.2. Бэлчээрийг жилээр сэлгэн ашиглах төлөвлөгөө

Говьсүмбэр аймгийн хэмжээгээр нийт 96589 га бэлчээр дунд зэргийн талхагдалд орсон байна. Үүнээс Сүмбэр суманд 86335.64 га бэлчээр байна.

Дунд зэргийн талхагдалд орсон бэлчээрийн газрыг 3 жил дараалан ургамлан нөмрөг сэргэтэл ургалтын хугацаанд ашиглалтаас чөлөөлөх. Ачааллыг боломжит даацаас 15 хувиар багаар тооцон 2 жил дараалан ургамал ургалтын хугацаанд ашиглах. Ахин 3 жилээр ургалтын хугацаанд ашиглалтаас чөлөөлөх. Малын тоог боломжит даацаас 15 хувиар багаар тооцон ахин 2 жил дараалан ургамал ургалтын хугацаанд ашиглах нь зүйтэй. Мөн бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготонотой тэмцэж хор цацах, биологийн аргаар тэмцэх, утах, ус цутгах гэх зэрэг ажлуудыг хийх хэрэгтэй.

## Хүснэгт 45. Жилээр сэлгэн ашиглах бэлчээр

№	Багийн нэр	Газрын нэр	Талбайн хэмжээ /га/	Төлөвлөж буй арга хэмжээ	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа /он/
---	------------	------------	---------------------	--------------------------	---------------------------	--------------



1	6-р	Хэрлэн голын дагуу Зараагийн булан орчим	2304	Жилээр сэлгэн ашиглалта ас чөлөөлөх	Бэлчээрийг жилээр сэлгэн ашиглах тухай нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр гаргах. Үүний дагуу малчидтай бэлчээрийг жилээр сэлгэх 3 талт гэрээ байгуулах. Шийдвэр ба гэрээний биелэлтэд хяналт тавих. Гэрээний биелэлтийг дүгнэж урамшуулал болон хариуцлага тооцох. Отор нүүдэл хийх газрыг заан өгөх.	2018
2		Муу гашууны худгаас зүүн тийш Билүүгийн худаг хүртэл	2790			2022
3		Баянбулгын худгаас зүүн хойш Наран худаг орчим	1903			2019
4		Хэмээн толгойгоос баруун урагш Ивээгийн ухаа толгой хүртэл	8534			2021
5		Аман хужирын хонхор	505			2020
6		Бумбат ихэр худаг	311			2019
7		Муу хөөтийн нуур орчим	648			2018
8	5-р баг	Их зостын толгойгоос зүүн тийш Шинэ усны худаг хүртэл	14320			2018
9		Хүрэн өндөр толгойгоос зүүн урагш Жаргалант толгой хүртэл	5074			2022
10		Жаргалант толгойгоос зүүн хойш Ханан толгой орчим	654			2019
11	4-р баг	Адгын ус худгийн орчим	1550			2022
		Лүн уулаас зүүн урагш Овоот худаг хүртэл				2021
12		Овоот худгаас зүүн урагш Хүрий ухаа-баруун урагш Хүрийн ногоон тойром- баруун урагш Холбоо нуур хүртэл	42816			2020
13		Цовхон худаг орчим	2393			2019
14		Бага зост толгой орчим	1420	2018		
	БҮГД		<b>86335.67</b>			

Дунд зэрэг талхагдалд орсон бэлчээрийн бүлгэмдэлд зонхилогч, дэд зонхилогчийн үүрэг солигдсон, ургамал нөмрөгт агь, шарилж болон талхагдлыг илэрхийлэгч бусад ургамал орж ирсэн, идэмж сайтай үет, буурцагт ургамлын оролцоо багассан, бут хоорондын сул зайд хөрс хучлагагүй болж иүцгэрсэн, олон төрлийн мэрэгч олширсон, ургамлын бүрхэц багассан байна.

### **6.1.3.3. Бэлчээрийг чөлөөлөх өнжөөж, амраан ашиглах төлөвлөгөө**

Говьсүмбэр аймгийн хэмжээгээр нийт 98453 га бэлчээр хүчтэй талхагдалд орсон байна. Үүнээс Сүмбэр суманд 74099 га бэлчээр байна.


Хүчтэй талхагдалд орсон бэлчээрийн газарт олон наст ургамлын бүрхэцийг нэмэгдүүлэх замаар өнгөн хөрсний тогтвортой байдлыг хангах нь чухал. Идэмж сайтай үндсэн зүйл ургамлууд бараг устаж үгүй болсон тул эргэн сэргэхдээ удаан 10-аад жил шаардагдана. 3 жил дараалан ургалтын хугацаанд ашиглалтаас чөлөөлөх. Ачааллыг боломжит даацаас 15 хувиар багаар тооцон 2 жил дараалан ургамал

ургалтын хугацаанд ашиглах. Ахин 3 жилээр ургалтын хугацаанд ашиглалтаас чөлөөлөх. Малын тоог боломжит даацаас 15 хувиар багаар тооцон ахин 2 жил дараалан ургамлан нөмрөг сэргэтэл ургамал ургалтын хугацаанд ашиглах нь зүйтэй.

Хүснэгт 46. Ашиглалтаас чөлөөлөх, өнжөөж амрах бэлчээр

№	Багийн нэр	Газрын нэр	Талбайн хэмжээ /га/	Төлөвлөж буй арга хэмжээ	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа /он/
1	6-р баг	Ар булагын амнаас зүүн урагш Цагаан толгой- баруун урагш Цахиурын тал-Банзарын хоолой-Хэмээн толгой хүртэл	50429	Ашиглалтаас чөлөөлөх, 3 жил дараалан өнжөөж амрах	Бэлчээрийг чөлөөлөх, 3 жил өнжөөж амрах тухай нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр гаргах. Үүний дагуу малчидтай бэлчээрийг ашиглалтаас чөлөөлөх 3 талт гэрээ байгуулах. Шийдвэр ба гэрээний биелэлтэд хяналт тавих. Гэрээний биелэлтийг дүгнэж урамшуулал болон хариуцлага тооцох. Бэлчээр чөлөөлөх үед отор нүүдэл хийх газрыг заан өгөх, өөр аймаг, сумын нутагт оторлох бол сумдын удирдлагуудын түвшинд тохиролцон хамтран шийдвэр гаргах.	2018
2		Ганц өндөр толгой орчим				2019
3	5-р баг	Шинэ-Усны хоолойгоос зүүн тийш Хойд толгой-урагш Улаан толгой	11326			2020
4		Улаан өндөр толгойгоос баруун хойш Цагаан эрэг толгойс орчим	3852			2021
5	4-р баг	Лүн уулаас зүүн хойш Ширүүн толгой хүртэл	2338			2022
6		Өөхийн цагаан толгой орчим	6154			2018
			74099		2019	

Хүчтэй талхагдсан бэлчээрийн бүтэц бүрэлдэхүүн үндсээрээ өөрчлөгдөж, агь, шарилж болон талхлагдлыг илэрхийлэгч бусад ургамал зонхилсон, нэгж талбайд байх ургамлын тоо эрс цөөрч, шингэрсэн, мал иддэг ургамал бараг үгүй болсон бүрхцийг мал иддэггүй ургамал бүрдүүлэх болсон, хөрсний өнгөний үржил шимтэй хэсэг салхинд хийсч хайргажин хөрс нягтарсан бутны ёроолд элс шуурч хурсан, оготоно зурамны нүх эзгүйрч, үлий хоосорсон байна.




**6.1.3.4. Бэлчээрийн улирлын хуваарийн төлөвлөлт**

Бэлчээрийг зөв зохион байгуулалттай, дэс дараатай ашиглуулахын тулд бэлчээр ашиглах улирлыг 4 биш, 6-аар тогтоох нь чухал юм. Үүнд:

1. Хавар эрт ашиглах бэлчээр /3, 4 дүгээр сард/
2. Хавар орой ашиглах бэлчээр /5 ба 6 дугаар сарын эхний хоногууд/
3. Зунд ашиглах бэлчээр /6 дугаар сарын 2-р хагасаас 7, 8-р сарууд/
4. Намар эрт ашиглах бэлчээр /6 дугаар сарын 2-р хагасаас 7, 8-р сарууд/
5. Намар орой ашиглах бэлчээр /10 дугаар сарын 2-р хагас, 11 дүгээр сар/
6. Өвлийн бэлчээр /12, 1, 2 дугаар сар/-уудад ашиглах.

Бэлчээрийг ийм хуваарьтайгаар ашиглах нь өвөл-хаврын хэцүү улирлыг өнтэй өнгөрүүлэх, малыг нэмэгдэл тэжээлээр тэжээх бэлтгэлийг урьдаас төлөвлөн хангах, бэлчээр, хадлангийн талбайг хамгаалах боломжийг олгоно.



### 6.1.3.5. Дэрст бэлчээрийг ашиглах, хамгаалах

Дэрс нь тус аймгийн толгод хоорондын хөндий, хотос нам газар, хуурай тойрмын орчмоор ургадаг байна.

Дэрс нь өндөр ургацтай бөгөөд дунджаар 1 га-с 25-30 цн-ийг ашиглах боломжтой жилийн дөрвөн улиралд мал иддэг тул малын сайн тэжээл болдог байна.

Хээрийн бүсийн уул нуруу ховор нөхцөлд малыг салхи шуурганаас хамгаалах чухал хэрэгсэл учраас ялангуяа байнга тохиолдох хүчтэй цасан ба шороон шуурганаас дэрстэй бэлчээрт яваа мал даарах уруудахаас хамгаалж нөмөрлөх боломжтой. Иймд дэрстэй нутгийг малын өвөл, хаврын стратегийн ач холбогдолтой бэлчээрийн газар гэж ойлгох нь зүйтэй.

Дэрст бэлчээрийн ач холбогдлыг дутуу ойлгож дэрс ургах хаврын сүүлч зуны улиралд нутаг сэлгэхгүй мал бэлчээснээс малын хөлд давтагдаж талхагдах нь хааяагүй дайралдаж байна.

Дэрс нь хөхөрч доройтсон бэлчээр



Сүмбэр сум 6-р баг

Энэ нь дэрсний ургацыг доройтуулж ургах боломжгүй болоход хүргэх төдийгүй бэлчээрийн даац хэтэрч цөлжилт үүсэх үндсэн шалтгаан болох тул малчид, орон нутгийн удирдлагууд цөлжихөөс урьдчилан сэргийлж дэрстэй бэлчээрийг сэлгэж ашиглах, хашиж хамгаалах арга хэмжээ авах нь нэн чухал.

Дэрсний захад өвөлжөө, хаваржаатай малчид дэргэдээ хүрэлцээтэй дэрст бэлчээртэй бол түүнээсээ 4-5 га талбайг нь хашиж хамгаалах замаар өвөл, хаврын тэжээлийн нөөц арвинтай бэлчээртэй болж цас шуургатай үед малаа оруулж хохирол багатай гарах боломжтойг зөвлөж байна. Ингэхийн тулд дараахь зүйлүүдийг анхаарах нь зүйтэй. Үүнд:

1. Ихээхэн хэмжээний дэрст бэлчээрийг аль болох өвөл, хавар ашиглах замаар улирлын ялгавартай сэлгэж байх
2. Дэрст бэлчээрийн багтаамжийг нарийн тооцож малын тоог хязгаарлаж бэлчээрийн даац хэтрүүлэхгүй байх
3. Өвөлжөө, хаваржааны дэргэд 4-5 га дэрст бэлчээрийг малчдад гэрээгээр ашиглуулах
4. Өвөлжөө, хаваржааны дэрст бэлчээр ургаж эхлэхээс өмнө бэлчээрийг чөлөөлж сэргэн ургах боломжийг олгох
5. Боломжтой нөхцөлд дэрст бэлчээрийг хашиж хамгаалах
6. Талхагдсан дэрст бэлчээрийг сэлгэх, өнжөөх зэрэг энгийн аргаар сайжруулах
7. Дэрс нялхаруулах аргаар дэрсний ургалтыг нэмэгдүүлэх зэрэг болно.

Аливаа ургамлыг мал идэх, эсвэл хадсаны дараа эд эрхтэнээ нөхөн сэргээж төлжин ургах чадварыг хэнзлэлт буюу хэнзлэх чадвар гэнэ. Мал бэлчээрлүүлэх болон хадланг хадсаны дараа нэгж талбайд тодорхой хугацааны дараа бий болох хуурай бодисын хэмжээг хэнз ургац гэдэг. Хэнзлэлтийн давтамж хээр бүсийн нутагт: 1-2 удаа хэнз ургац өгдөг. Бэлчээрийг хэнзлүүлж ашигласнаар мал сүргийг нялх зөөлөн 10-40%-иар илүү шимт чанартай, эслэг багатай тэжээлээр хангах боломжтой болно. Хоёр удаа хэнзлүүлэн ашигласнаар малчдын нүүдлийн тоог цөөрүүлж, нэгж талбайгаас 10-30 % -ийн нэмүү ургац авдаг байна.

#### **6.1.3.6. Бэлчээрийн усан хангамж**

Урьд ашиглагдаж байсан худгууд эвдэрч тоногдсон учир одоо ашиглаж байгаа худгаа бараадан айлууд бөөгнөрөн бууснаас бэлчээр талхагдах нэгэн хүчин зүйл болж байна.

Сүүлийн жилүүдэд малчид өөрсдийн хүчээр гар худаг гаргах боловч бэлчээр усжуулалтын хэмжээнд ахиц гарахгүй байна.

Усны нөөцийг зохистой ашиглаж хамгаалахад эдийн засгийн хөшүүрэг, механизмыг хэрэглэн ус ашигласны төлбөрийг ногдуулж, хуримтлуулж орон нутгийн төсөвт төвлөрүүлж эхлээд нилээдгүй хугацаа өнгөрсөн боловч энэ хөрөнгө усны

нөөцийг зохистой ашиглах, хамгаалахад чиглэгдсэн оновчтой арга хэмжээнд бус, орон нутгийн төсөвт зарцуулагдаж байгаагаас нутаг бэлчээрийг усжуулах, уст цэгүүдийг хамгаалах, усны нөөцийг арвижуулах ажил зогсонги байдалтай байна. Энэ байдалд дүгнэлт хийж ус, рашаан ашигласны төлбөрийг оновчтой тогтоох, төлбөрийг усны аж ахуйн менежментэд зарцуулах, худаг ус гаргах ажлыг төрийн бодлогоор дэмжих замаар нутаг бэлчээрийн ашиглалтыг сайжруулах нь чухал.


Энэ тайлбар бичгийн “Усны сан бүхий газрын хамгаалалт, ашиглалтын төлөвлөгөө” хэсэгт гол, горхи, булаг, шанд, нуур, худаг усны хамгаалалтын бүсийг татаж, зурагт харуулсан болно.

Бэлчээр дэх худгийн мал усалгааны радиусыг хээрийн бүс нутагт бог мал ба үхэр услах 2.5 км-ээр тогтоолоо. Сумын хэмжээгээр усжуулагдсан бэлчээр 205423.6 га, усжуулагдаагүй 169455.4 га бэлчээр байна.

Хүснэгт 47. Усжуулагдсан бэлчээрийн талбай

<i>Гадаргын усны төрөл</i>	<i>Тоо хэмжээ</i>	<i>Нэг худгийн мал усалгааны радиус</i>	<i>Нэг худгийн усжуулсан талбайн хэмжээ /га/</i>	<i>Усжуулагдсан нийт бэлчээрийн хэмжээ /га/</i>	<i>Усжуулагдаагүй талбайн хэмжээ /га/</i>
<i>Бэлчээрийн усан хангамж, худаг</i>	<i>190</i>	<i>2.5 км</i>	<i>1963 га</i>	<i>205423.6</i>	<i>169455.4</i>





Говьсүмбэр аймагт бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар нийт 292 худаг ашиглагдаж байгаагийн 150 худаг нь ажиллагаатай, 14 худаг ямар нэгэн байдлаар эвдэрсэн байна. Эвдэрсэн худгийг сэргээн засварлаж ашиглалтгүй бэлчээрийг эргэлтэд оруулах арга хэмжээг дор дурьдсанаар төлөвлөв.

Хүснэгт 48. Эвдэрсэн худгийг сэргээн засварлах төлөвлөгөө

Худгийн байршил	Худгийн төрөл	Ашиглалтад орсон он	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа /он/
<b>Сүмбэр</b>				
Эргэнэ-Ус	Энгийн уурхай	1975	засварлах	2020-2021
Сайн аяганы дэнж	Өрөмдмөл	2006	засварлах	2019-2020
Алгат	Энгийн уурхай	1973	засварлах	2022-2023
Адуун чулуу	Энгийн уурхай	1975	засварлах	2021-2022
Бага мухар	Өрөмдмөл	2008	засварлах	2024-2025
Уулзвар	Энгийн уурхай	1984	засварлах	2026-2027
Таван толгой 1	Энгийн уурхай	1970	засварлах	2021-2022
Асгана булаг	Өрөмдмөл	2007	засварлах	2021-2022
Алсын худаг	Өрөмдмөл	2005	засварлах	2025-2026
Хөх ус	Энгийн уурхай	1985	засварлах	2020-2021
Эхэн эрэгцэг	Өрөмдмөл	1970	засварлах	2027-2028
Аяганы хонхор	Энгийн уурхай	1984	засварлах	2018-2019
Зост	БХУХ	1975	засварлах	
Талын худаг		1974	засварлах	
Хув шанд		2014	засварлах	
Хурэн чулуу		2007	засварлах	
Шархад		1975	засварлах	
Өлийн овооны хойд тал		1974	засварлах	
Толгон		2007	засварлах	
Ханан		1985	засварлах	
Малах		1978	засварлах	
Малах		1970	засварлах	
Билүү төлүү		1970	засварлах	

Цагаан толгой 1		1980	засварлах	
Хар нуурын худаг		2011	засварлах	

**Хүснэгт 49. Уст цэгүүдийг сэргээн засварлах болон шинээр уст цэгүүд гаргах зардлын томсгосон үзүүлэлт (сая төгрөг)**

№	Сумын нэр	Засварлах худаг						Шинээр гаргах			Сумын хэмжээнд шаардагдах нийт зардал (сая төг)	Усжуулагдах бэлчээр (мян га)
		Өрөмдмөл			Энгийн уурхай			Гүн өрмийн				
		Тоо (ш)	Нэгж зардал	Нийт зардал	Тоо (ш)	Нэгж зардал	Нийт зардал	Тоо (ш)	Нэгж зардал	Нийт зардал		
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Сүмбэр	5	4.5	22.5	7	2.5	17.5		9.0			
	Дүн			22.5			17.5					

**6.1.3.7. Өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх талаар**

“Газрын тухай” хуулийн 52 дугаар зүйлийн 52.7 дах заалтад “Өвөлжөө, хаваржааны доорхи газрыг Монгол Улсын иргэн хот айлаар дундаа хамтран эзэмшиж болно” гэж заасан боловч газрын хэмжээг тодорхой заагаагүй байдаг нь энэ зориулалтаар бэлчээрийн газрыг ашиглуулах, эзэмшүүлэхэд хүндрэл тулгардаг бөгөөд орон нутгууд янз бүрийн хэмжээгээр газрыг эзэмшүүлж, ашиглуулдаг байна.

Малчин, хот айл өвөл, хаврын улиралд ойр орчмын газартаа малаа бэлчээх зорилгоор уулын энгэр, нөмөр газрыг сонгон хүн, малын ая тухтай байх нөхцөлийг бүрдүүлж, өөрийн гэр, сууц, малын хашаа хороо, саравч, бууц, өвс, тэжээлийн хашаа, мал нарладаг талбай, морины уяа, нөөцөлсөн түлээ, түлшний байр, үнс, хог хаях газар, ариун цэврийн газар зэргийг барьж байгуулан ашиглаж байгаа газрыг өвөлжөө, хаваржааны доорх газар гэдэг.

**Хүснэгт 50. Өвөлжөө, хаваржааны доорх газрын жишиг хэмжээ**

№	Өвөлжөө, хаваржааны доорх газрын бүтэц	Хангайн бүс	Говийн бүс	Тал хээрийн бүс
1	Малчны гэр, сууцны газар	56-100 м <sup>2</sup>	56-100 м <sup>2</sup>	56-100 м <sup>2</sup>
2	Түлээ нүүрсний байр	2-4 м <sup>2</sup>	2-4 м <sup>2</sup>	2-4 м <sup>2</sup>
3	Үнс хог хаях газар	3-6 м <sup>2</sup>	3-6 м <sup>2</sup>	3-6 м <sup>2</sup>
4	Ариун цэврийн байр	1-2.5 м <sup>2</sup>	1-2.5 м <sup>2</sup>	1-2.5 м <sup>2</sup>

5	Малын хашаа хороо, саравч, пүнз	100-600 м <sup>2</sup>	100-700 м <sup>2</sup>	100-800 м <sup>2</sup>
6	Бууц асгах газар	10-20 м <sup>2</sup>	10-20 м <sup>2</sup>	10-20 м <sup>2</sup>
7	Өвс тэжээлийн хашаа	15-25 м <sup>2</sup>	15-25 м <sup>2</sup>	15-25 м <sup>2</sup>
8	Мал нарладаг талбай	200-700 м <sup>2</sup>	300-800 м <sup>2</sup>	400-900 м <sup>2</sup>
9	Морины уяа	20-50 м <sup>2</sup>	20-50 м <sup>2</sup>	20-50 м <sup>2</sup>
<b>Бүгд хэмжээ /м<sup>2</sup>/</b>		<b>400-1500 м<sup>2</sup></b>	<b>500-1700 м<sup>2</sup></b>	<b>600-1900 м<sup>2</sup></b>
<b>Нийт тойргийн хэмжээ /га/</b>		<b>0.07-0.2</b>	<b>0.09-0.3</b>	<b>0.1-0.4</b>

Өвөлжөө, хаваржааны доорх газрын хэмжээг сансрын зураг ашиглан тодорхойлсон зураг

Жишээ



Тэгэхээр Говьсүмбэр аймаг нь тал хээрийн бүсэд багтах бөгөөд өвөлжөө, хаваржааны доорх газрыг 0.1-0.4 га-аар эзэмшүүлэх нь тохиромжтой хэмжээ юм.

Өвөлжөө, хаваржааны доорх газарт хамгийн их зай, талбай эзлэх газар нь малын хашаа хороо, саравч, пүнз болон мал нарладаг талбай байдаг. Тиймээс малын хашаа, саравчны талбайн хэмжээ, багтаамжийг бод болон бог малын хэвтрийн эзлэх хэмжээгээр тооцож гаргана. Мөн мал нарладаг талбайн хэмжээг бод, бог малын хэвтрийн хэмжээгээр тооцно.

Хүснэгт 51. Бод малын хашаа, саравчны талбайн хэмжээ, багтаамжийг тооцох

Үзүүлэлт	Үхрийн нас, хүйс	Хэмжих нэгж	Саравчны хэвтрийг тооцох талбай
1	6 сараас дээш настай тугал	М <sup>2</sup>	1.0-1.2

Монгол үхэр	2	Бяруу	М <sup>2</sup>	1.0-2.0
	3	Гунж, шүдлэн	М <sup>2</sup>	2.2-2.4
	4	Хээлтэй үнээ	М <sup>2</sup>	2.8-3.0
	5	Тугалтай үнээ	М <sup>2</sup>	4.2
	6	Нас гүйцсэн шар, бух	М <sup>2</sup>	4.5-5.0
Сарлаг үхэр	7	Тугал	М <sup>2</sup>	0.8-1.0
	8	Бяруу	М <sup>2</sup>	1.4-1.8
	9	Гунж, шүдлэн	М <sup>2</sup>	2.0-2.2
	10	Хээлтэй үнээ	М <sup>2</sup>	2.6-2.8
	11	Тугалтай үнээ	М <sup>2</sup>	3.8-4.0
	12	Нас гүйцсэн шар, бух	М <sup>2</sup>	4.5-5.0

Үхрийн өвөлжөөний хашааны багтаажийг тооцохдоо шөнө саравчинд хэвтүүлэх, орой, өглөө 1-2 цаг нарлах хашаанд байлгаж шээлгэх, цан хүүргийг унагах, суурийн нийт үхрийн 50 орчим хувьд нэмэгдэл тэжээл өгч байх технологийг үндэс болгоно.

Хонь, ямааны нас хүйс, үүлдэр угсаанаас хамааран эзлэх зай нь битүү дулаан пүнз болон саравчтай хашаанд ялгаатай байна.

Хүснэгт 52. Бог малын хашаа байрны талбайн хэмжээ, багтаамжийг тооцох /м<sup>2</sup>/

№	Малын нас, хүйс, үүлдрийн ялгаа	Битүү дулаан байр	Саравчтай хашаа
1	Нарийн нарийвтар ноост хонь, ноолуурын ямаа	1.0	0.6
2	Нутгийн үүлдрийн хонь, ямаа	0.7	0.5
3	Эр, сувай, өсвөрийн хонь, ямаа	-	0.4

Бог малын хашааны багтаамж нь хэвтрийн, нарлагааны, тэжээллэгийн, бусад гэсэн 4 хэсгээс бүрдэнэ. Бог малын хашаа, байрны талбайн хэмжээг дараах журмаар тооцно.

Хашааны багтаамж:

$$ХБТ = X + H + T + B \text{ м}^2$$

X-хэвтрийн талбай,  $x = N \times S \text{ м}^2$

N-нэг суурьт байх малын дундаж тоо

S-нэг малд ногдох талбай

Нэг суурьт нийт эм хонь, ямаа 650 толгой бол  $X = N \times S$

$650 \times 0.6 = 390 \text{ м}^2$  хэвтрийн талбайтай байна.

H-нарлагааны талбай,  $H = K_1 \times X \text{ м}^2$   $K_1 = 2.0$

Нэг толгой нэг настай малын хашааны нарлагааны талбай  $= 0.4 \times 2 = 0.8 \text{ м}^2$

Суурийн нэг наст малын тоо 800 толгой бол  $H = 800 \times 0.8 = 640 \text{ м}^2$

Тэжээллэгийн талбай,  $T=K_2 \times H \text{ м}^2$   $K_2=1.5$

Нэг толгой эм хонь, ямааны тэжээллэгийн талбай  $1.5 \times 0.6 \times 2=1.8 \text{ м}^2$  болно.

Нийт суурийн 650 толгой малд  $T=1.8 \times 650= 1170 \text{ м}^2$  болно.

Нийт 650 толгой малтай нэг суурийн хашаа, байрны талбайн хэмжээ нь 2200 м<sup>2</sup> гарч байна.

Тус аймагт өөр аймаг, сумын буюу Дундговь аймгийн Цагаандэлгэр, Төв аймгийн Баян, Баянжаргалан, Дорноговь аймгийн Даланжаргалан зэрэг сумдаас малчид отор нүүдэл хийж орж ирэн бэлчээр усыг ашиглаж байгаад нутгийн малчид ихээхэн дургүй бөгөөд бэлчээрийн маргаан ч гардаг байна. Мөн малчид өөрсдийн өвөлжөө, бууцаа тэдэнтэй наймаалцаж, гадны малчдыг өөрийн нутагт байрлуулж бэлчээрийн даац ашиглалтыг нэмэгдүүлж байна. Сүмбэр сумын Тэвшийн 4-р багийн иргэдийн нийтийн хурал 2017 оны 10 сарын 4-нд хуралдаж, өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэхдээ дараах зарчмыг баримтлахаа хуралд ирсэн малчид тохиролцсон юм. Үүнд:

- Энэ онд өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшүүлэхгүй байх
- Өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшсэн бол дахин газар олгохгүй байх
- Тус багт шилжиж ирээд дор хаяж 3 жил амьдарч, иргэний бүртгэлийн шилжилт хөдөлгөөнөө хийлгэж бүртгүүлсэн малчдад л газар эзэмшүүлэх
- Малаа өөрийн гараар маллаж байгаа малчин өрхөд газар эзэмшүүлэх
- Шинээр өрх тусгаарласан малчин өрхөд газар эзэмшүүлэх зэрэг зарчмыг бусад багууд баримтлан өвөлжөө, бууцын доорх газрыг эзэмшүүлэх нь зүйтэй юм.

#### **6.1.3.8. Малчдын бүлэг, бэлчээр ашиглалтын хэсэг байгуулах талаар**

Зах зээлийн нийгэмд шилжсэн өнөөгийн нөхцөлд малчид малын тоо толгойг дураараа өсгөж ашиг олох зорилгоор бэлчээр нутгийг хайр гамгүй ашиглан талхлан доройтуулж, үржил шимгүй болгон нөөцийг шавхан ашиглах явдал гарсаар байна. Мөн нөгөө талаас байгаль, цаг уурын нөлөөлөл, хуурайшилтаас хамаарч бэлчээрийн төрх байдал өөрчлөгдөх, элсний нүүлт ихсэх, булаг, шанд ширгэх зэрэг шалтгаанаар бэлчээрийн газар өдөр ирэх тутам багассаар байгаа нь газар зохион байгуулалтын тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Дэлхийн банкны санхүүжилтээр “Бэлчээрийн эрсдлийн менежментийг сайжруулах төсөл” Говьсүмбэр аймагт 2007 онд хэрэгжиж сум, багт малчдын бүлэг

байгуулан, газар нутгийг малчдын бүлгийн хил, заагт хуваах ажлыг хийсэн. Гэвч энэ нь амьдрал дээр хэрэгжээгүй, цаасан дээр зураг болж үлдсэн байна.

Иргэний хуулийн 481.1.-дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.2.8-дахь заалтын дагуу сайн дурын үндсэн дээр байгуулагдаж, бэлчээрийн ургамал, ойн сан, зэрлэг амьтан зэрэг байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, гэрээгээр давуу эрхээр ашиглах, эзэмших эрх бүхий байгууллага нь нөхөрлөл болон малчдын бүлэг гэж ойлгоно.

**Малчдын бүлэг** гэж жилийн аль нэг буюу хэд хэдэн улиралд нэг дор нутаглаж, бэлчээрийн аль нэг нөөцийг хамтран ашиглаж, хамгаалах нийтлэг ашиг сонирхол бүхий тодорхой тооны малчин өрхийн нэгдлийг бэлчээр ашиглалтын бүлэг гэдэг.

**Бэлчээр ашиглалтын хэсэг** гэж малчдын бүлгийн ашиглаж, хамгаалж байгаа тодорхой хил зааг бүхий бэлчээрийн нэгдмэл нөөц нутгийг бэлчээр ашиглалтын хэсэг гэнэ.

Тиймээс өвөл, хаврын бэлчээрээ түшиглэн нэг дор нутаглан бэлчээр усаа ашигладаг малчид **сайн дурын** үндсэн дээр өөр хоорондоо нэгдэн бүлэг байгуулах боломжтой.

“Газрын тухай” хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалтад “... Өвөлжөө, хаваржааны **тодорхой нутаг бэлчээрийг ... малчдад** болзол, гэрээний дагуу **хэсэг, бүлгээр ашиглуулж** болно” гэж заасан нь малчид өөр хоорондоо нэгдэн бүлэг байгуулж, гэрээний журмаар бэлчээрээ ашиглана гэсэн үг юм.

Малчдын бүлгийн ашиглаж буй бэлчээр, хадлангийн газрын даац тооцох, бэлчээрийн ачаалалд зохицуулалт хийх, хамгаалах, сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах зорилгын үүднээс сумын нутаг дэвсгэрийг бэлчээр ашиглалтын хэсэгт хувааж болно.

Бид энэхүү төлөвлөлтийн ажлын хүрээнд Говьсүмбэр аймгийн хэмжээгээр малчдын бүлгийн байршил, түүний бэлчээр ашиглалтын хил заагийн хувилбар боловсруулж зураглах ажлыг гүйцэтгэлээ. Уг хувилбарыг боловсруулахдаа малчин өрх өвөлжөө, хаваржаанаасаа богино хөлт малаа бэлчээх 3 км хүртэлх зайг баримталж тогтоосон болно.

Хүснэгт 53. Малчдын бүлэг, бэлчээр ашиглалтын хэсэгт хамрагдах мөлчин өрхийн нэр

№	Бэлчээр ашиглалтын хэсгийн нэр	Нийт талбайн хэмжээ /га/	Өрхийн тоо	Малын тоо
<b>4-р баг</b>				
1	1-р хэсэг	8631	Л.Бямбаа	507
2			О.Энхбат	250
3			Д.Пүрэвдорж,	510
4			Алтанхүү	474
5			Х.Батбаяр,	518
6			Д.Адарсүрэн	317
<b>Бүгд</b>		<b>8631</b>	<b>6 өрх</b>	<b>2576</b>
7	2-р хэсэг	11331	Н.Борхүү	630
8			Б.Баттулга	1 111
9			М.Батсайхан	1236
10			М.Батхишиг	481
11			Ж.Насанбат/Д.Баасанхүү	
12			Ч.Сандагдорж	257
13			Б.Түвшинжаргал	33
14			Б.Энхтуяа	284
<b>Бүгд</b>		<b>11331</b>	<b>8 өрх</b>	<b>2921</b>
15	3-р хэсэг	12652	Ц.Энхжаргал	2786
16			Т.Шинэтөр	131
17			Р.Янжин	1241
18			Ц.мөнхпүрэв	255
19			Б.Цогтсайхан	1156
20			Ж.Ууганбаяр	506
21			Т.Баярсайхан	386
<b>Бүгд</b>		<b>12652</b>	<b>7 өрх</b>	<b>6461</b>
22	4-р хэсэг	13693	Ц.Туяацэцэг 1+	742
23			С.Алтандөш	184
24			Отгондаваа	274
25			О.Энхбаатар	1202
26			М.Дэлгэрсайхан	280
27			Г.Төмөрбаатар	218
28			Цэрэгбаяр	358
29			Б.Батбилэг	252
<b>Бүгд</b>			<b>13693</b>	<b>8 өрх</b>
30	5-р хэсэг	16839	Х.Төмөрбаатар	502
31			Ц.Алтанзул	1321




32			Т.Болдбаатар	930
33			О.Наранбаатар	394
34			У.Сайнбуян	637
35			М.Мөнхзаяа	615
36			Л.Отгонбаатар	220
37			Л.Нямдорж	288
38			Ж.Цогтсайхан	1038
39			Ж.Мягмардорж	284
40			Л.Эрдэнэтоттох	845
41			Д.Эрдэнэбат	1375
42			С.Сүмбэрмаа	113
<b>Бүгд</b>		<b>16839</b>	<b>13 өрх</b>	<b>8562</b>
43,	6-р хэсэг	15269	Т.Ням-Эрдэнэ 1+	1164
44			Т.Өнөржаргал 1+	851
45			Т.Ариунболд	369
46			С.Баточир	293
47			О.Давга	638
48			Ж.Бямбадорж	613
49			Д.Баттулга	1293
50			Б.Батулга	1111
51			Б.Баттөмөр	413
52			Алтанхорол	776
<b>Бүгд</b>		<b>15269</b>	<b>10 өрх</b>	<b>7521</b>
53	7-р хэсэг	16004	Ю.Алтанхуяг	183
54			Ц.Адьяахүү	517
55			Ц.Угтахбаяр	645
56			Б.Баттөмөр	1185
57			Л.Манлайжаргал	426
58			Х.Чинбаатар	378
59			Д.Адьяадорж	748
60			Б.Цэрэнтогтох	612
61			Д.Отгонбаатар	368
62			Ч.Амартүвшин	745
63			Б.Баттөмөр	1185
64			Б.Отгонболд	30
65			Б.Баттөмөр	1185
<b>Бүгд</b>			<b>16004</b>	<b>13 өрх</b>
<b>5-р баг</b>				
66	1-р хэсэг	11171	О.Олонбаатар-3	1393
67			Ендон	3-р баг

68			А.Цогбаатар	801
69			Г.Шүрэнчулуун	2016
70			Р.Цэдэв	67
71			Б.Батэрдэнэ	500
72			Б.Цогтсайхан	1166
73			Д.Бат эрдэнэ	220
74			Т.Мөнхчулуун	541
75			А.Энхбаяр	388
<b>Бүгд</b>		<b>11171</b>	<b>10 өрх</b>	<b>7092</b>
76	2-р хэсэг	13578	Г.Уранцэнгэл	2236
77			Чойдавдаш	234
78			Ч.Баярсайхан	1401
79			Д.Зоригтсайхан	3177
80			Б.Ууганболд	829
81			Г.Шүрэнчулуун	2016
82			Г.Уранцэнгэл	2236
83			Х.Лувсан цэрэн	1000
<b>Бүгд</b>		<b>13578</b>	<b>8 өрх</b>	<b>13129</b>
84	3-р бүлэг	13129	М.Алтанбаяр	461
85			Н.Дашзэвэг	180
86			Октябрь	578
87			Ш.Ариунболд	
88			Э.Эрдэнэчулуун	1455
89			Э.Өсөхбаяр	277
90			Д.Өлзийсүрэн	
91			Г.Галпүрэв	114
92			Э.Мянганбаяр	
93			Б.Түмэндалай 1+	335
94			Г.Эрдэнэбилэг	820
<b>Бүгд</b>		<b>13129</b>	<b>11 өрх</b>	<b>4220</b>
95	4-р бүлэг	13921	Л.Отгонбаяр	21
96			Б.Батбуян	735
97			С.Баттөр	344
98			Х.Лувсанцэрэн	1000
99			Л.Батаа 1+	462
100			Ш.Алтангэрэл	998
101			Д.Отгонсүрэн	1029
102			Т.Батжаргал	1408
103			О.Эрдэнэбазар	915
<b>Бүгд</b>		<b>13921</b>	<b>9 өрх</b>	<b>6912</b>
104	5-р бүлэг	9656	М.Гүрбазар	253
105			Б.Пагма	543

106			В.Ганбат	26
107			Ц.Сумъяа	178
108			Д.Нямсүрэн	223
109			Цэрэгбаяр	358
110			Ө- Х.Ганзориг 1+	206
<b>Бүгд</b>		<b>9656</b>	<b>7 өрх</b>	<b>1787</b>
111	6-р бүлэг	10308	Г.Санжаа	678
112			Д.Зоригтсайхан	3177
113			Б.Түвшин	704
114			Лхамсүрэн	144
115			Б.Батбуян 1+	735
116			Ш.Даваа	182
117			Ц.Энхжаргал	2786
118			Т.Батжаргал	1408
119			Б.Пүрэвдорж	1023
<b>Бүгд</b>		<b>10308</b>	<b>10 өрх</b>	<b>10837</b>
120	7-р хэсэг	12868	О.Олонбаатар х-	21
121			Түвшин	704
122			Г.Алтанцэцэг	500
123			О.Ганбаатар	314
124			О.Майнбаяр	1356
125			Лхамсүрэн	15
126			Б.Бааст	82
127			Д.Зоригтсайхан 1+	3177
128			Ц.Цэрэгноён	641
129			Ц.Нямсүрэн	614
130			П.Гонгорбаатар 2+	359
131			Н.Мөнхбаяр	32
132			Б.Түвшин	704
<b>Бүгд</b>		<b>12868</b>	<b>13 өрх</b>	<b>8519</b>
133	8-р хэсэг	8174	Б.Мөнхчулуун	541
134			Б.Чойсүрэн	463
135			Г.Санжаа	678
136			Б.Бат эрдэнэ	500
137			Б.Түвшин	704
138			Гэлэнхүү	<i>шивээгийинх</i>
139			Д.Мөнхбаатар	627
140			Т.Жииеэ	644
<b>Бүгд</b>		<b>8174</b>	<b>8 өрх</b>	<b>4157</b>

141	9-р хэсэг	14611	О.Майнбаяр	1356-Г
142			Э.Одбаатар	438
143			С.Пүрэвжав	1383
144			Г.Майнбаяр 3+	1356
145			М.Насанбуян	2235
146			С.Сүхбаатар	96
147			Э.Ариунжаргал	720
148			М.Насан буян	2235
149			Д.Төмөрхуяг	454
<b>Бүгд</b>			<b>14611</b>	<b>9 өрх</b>
<b>6-р баг</b>				
150	1-р хэсэг	10317	Ж.Хүрэлбаатар	1029
151			Ж.Түмэннасан	271
152			Д.Амаржаргал	649
153			Ш.Сумьяа	959
154			Ц.Ерөөлт	1512
155			Т.Амгалан	458
156			Т.Шижирболд	414
<b>Бүгд</b>			<b>10317</b>	<b>7 өрх</b>
157	2-р хэсэг	9582	Б.Болдбаатар	2193
158			А.Батсүх	846
159			А.Даваадалай	474
160			Ц.Сухбаатар	452
161			Б.Баярсайхан	959
<b>Бүгд</b>		<b>9582</b>	<b>5 өрх</b>	<b>4924</b>
162	3-р хэсэг	12688	Ц.Бат-эрдэнэ	306
163			О.Давга	638
164			Ж.Сосорбарам	287
165			М.Оюунгэрэл	
166			П.Доржсайхан	733
167			Д.Цолмонбаатар	73
168			Ц.Шинэбаяр	870
169			Б.Тулга	1390
<b>Бүгд</b>		<b>12688</b>	<b>8 өрх</b>	<b>4297</b>
170	4-р хэсэг	17731	Б.Нацагдорж	590
171			Л.Энхамгалан	571
172			Б.Нацагдорж	590
173			О.Мартхүү	330
174			О.Мөнхдөл	228
175			Ц.Готов	233
176			А.Уламбаяр	768

177			Л.Буяндэлгэр	255
178			Маамуу	778
179			Ш.Пүрэв	1341
180			М.Балжинням	654
181			В.Дагзмаа	272
<b>Бүгд</b>		<b>17731</b>	<b>12 орх</b>	<b>6610</b>
182	5-р хэсэг	11157	Б.Болд	274
183			Н.Баярцогт	831
184			М.Амарбаян	390
185			М.Аюурсэд	527
186			Б.Энхтайван	791
187			Н.Ган эрдэнэ	269
188			Д.Сансаргүр	128
189			Г.Энхболд	433
190			М.Амарбаян	390
<b>Бүгд</b>		<b>11157</b>	<b>9 орх</b>	<b>4033</b>
191	6-р хэсэг	15260	О.Одонжаргал	1378
192			Ж.Одгэрэл	1015
193			А.Дуламаа	бхгуй
194			Б.Баярхүү	632
195			<b>Б.Баатар-с</b>	309
196			Н.Ганзориг	2-р баг
197			Г.Балжинням	1276
198			З.Хөхөө	581
<b>Бүгд</b>			<b>15260</b>	<b>8 орх</b>
199	7-р хэсэг	10896	Ц.Мөнххуяг	275
200			О.Мөнхбат	765
201			А.Гантулга	734
202			Лхагвасурэн	300
203			О.Одонжаргал	1378
204			Б.Цоожилдорж	155
205			Л.Мөнхбаяр	798
<b>Бүгд</b>		<b>10896</b>	<b>7 орх</b>	<b>4405</b>



Бидний энэхүү тогтоосон малчдын бүлгийн байршил болон бэлчээр ашиглалтын хэсгийн хил, заагийг практикт буулгах ажлыг зохион байгуулах нь зүйтэй. Малчдын бүлэг байгуулах, бэлчээр ашиглалтын хэсгийн хилийн заагийг тогтоох ажлыг сумын мал эмнэлэг үржлийн тасгийн бэлчээрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, газрын даамал, багийн Засаг дарга, малчид, малчдын бүлгийн нэр хүндтэй нөлөө бүхий малчидтай хамтран бэлчээр ашиглалтын уламжлал, тухайн нутгийн онцлогтой уялдуулан доорх зарчмыг баримтлан бэлчээр ашиглалтын хэсгийн хилийн заагийг байгалийн болон гараар барьж байгуулсан объектоор баримжаалан тогтоож, хэсэг бүрт оноосон дугаар өгнө. Ингэхдээ дараах асуудлыг анхаарах хэрэгтэй.

а). Мал, мал маллагааны уламжлалт арга технологи, нүүдлийн хэв шинж, бэлчээр хамтран дундаа ашиглаж ирсэн нөхцөл байдлыг харгалзах

б). Нэг дороо байнга нутагладаг малчдаас ирсэн саналыг баримтлах

в). Өвөлжөө, хаваржаа, худаг усны байршил ойролцоо байх

г). Хил нь тухайн бүлэгт багтах захын айлаас богино хөлт мал бэлчих зайд буюу 2-3 км дотор байх

д). Нэг бүлэг дотор орж байгаа өрхүүд нь бие биеэ сайн мэддэг, бэлчээр, усны ашиглалтын талаар нэгдмэл шийдвэр гаргах чадвартай байх

е). Газрын гадаргуу, уул, ус, ой мод, гол мөрөн, жалга гэх мэт малын бэлчээрийг заагладаг байгалийн хүчин зүйлс ашиглан хил заагийг тогтоож зурагт буулгах

### 6.1.3.9. Суурин мал маллагааны бүс нутгийн төлөвлөлт

Төлөвлөлтийн сүүлийн шат буюу 2030 он гэхэд аймгийн хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээнд зориулан жилд 1067.7 литр үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, мөн тооны уламжлалт аргаар боловсруулсан сүү, 1422.3 литр сүүн бүтээгдэхүүн худалдаж байх шаардлага гарна.

#### Хүснэгт 54. Сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээ, хэтийн төлөв

№	Хүнсний бүтээгдэхүүний төрөл	Жишсэн 1 хүний жилийн хүнсний хэрэгцээ /л/	Хүнсний бүтээгдэхүүнийг нэг бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох коэффициент	2018-2020 он		2021-2025 он		2026-2030 он	
				Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /л/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /л/	Хүн амын тоо	Хүнсний хэрэгцээ /л/

2	Сүү	54.8	Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү	1	17053	934504.4	18268	1001086.4	19484	1067723.2
		54.8	Уламжлалт аргаар боловсруулсан сүү	1	17053	934504.4	18268	1001086.4	19484	1067723.2
3	Сүүн бүтээгдэхүүн	73			17053	1244869	18268	1333564	19484	1422332

Говьсүмбэр аймаг нь газар нутаг багатай, цаг агаарын аюулт үзэгдэл нилээн тохиолддог зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан малынхаа үүлдэр угсааг сайжруулан чанар сайтай, цөөн тооны малыг хагас эрчимжүүлэн суурин хэлбэрийн аж ахуй эрхлэх шаардлагатай. Үүний зэрэгцээ Чойр хот ирээдүйд томоохон хот суурин болон хөгжиж хотжилт эрчимтэй өсөх бүрэн боломжтой тул эрчимжсэн болон хагас эрчимжсэн фермерийн аж ахуй хөгжүүлэх хэрэгтэй. Иймд Чойр хотын орчимд сүүний чиглэлийн эрчимтэй фермерийн аж ахуй, усалгаатай газар тариалангийн чиглэлийн фермерийн аж ахуй, хагас суурин бэлчээрийн мал аж ахуйн фермер зэрэг чиглэлүүд бий болно гэж үзлээ.

Үүнээс гадна энэ бүсэд гахай, тахиа үржүүлдэг фермерийн аж ахуйнууд байгуулах шаардлагатай. Эдгээр фермерүүд нь тус тусдаа нарийн арга технологи онцлогтой тул олгогдсон газарт цаашид нарийвчилсан төлөвлөгөө хийж төрөлжүүлнэ.

Сүү бол өдөр тутмын хүнсний хэрэгцээний 20-25 хувийг эзэлж байх шаардлагатай бөгөөд сүүнээс гадна бусад төрлийн цагаан идээ, тараг, аарц, ааруул, ээзгий, гүүний айраг, лаазтай өтгөрүүлсэн ба хуурай сүү нилээд хэмжээгээр хэрэгтэй.

Тус хотын хүн амыг дотоодын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр түргэн шуурхай хангах зорилгоор эрчимжсэн суурин мал аж ахуйн бүс нутгийг хэрэглэгчдэд хамгийн ойр зам, харилцаа сайтай газар төвлөрүүлэх. Сүүг аль болох хямд үйлдвэрлэхэд дөхөм үзүүлэх нөөц боломж, эрчим хүч, түлш зэрэг холбогдох асуудлыг харгалзан Сүмбэр сумын 4-р баг аймгийн төвийн зүүн урд одоогийн гахай, тахианы эрчимжсэн фермерийн залгаа нийт 2900 га газарт хөгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Цаашид эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэхэд 8 ширхэг сүүний чиглэлийн фермер, 700 орчим га-д төмс, хүнсний ногоо тариалдаг аж ахуй, 1500 га-д хагас суурин мал аж ахуйг бий болгосноор хүн амын мах, сүү, цагаан идээ, төмс, хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангах боломж бүрдэх юм.



**Хүснэгт 55. Сүүний чиглэлийн фермерийн аж ахуйн тоо**

Он	Фермерийн аж ахуйн тоо	
	30 үнээтэй	50 үнээтэй
2018-2020	2	1
2021-2022	3	1

**Хүснэгт 56. Сүүний стандарт аж ахуйн үйлдвэрлэх бүтээгдэхүүн**

Үзүүлэлт	30 үнээтэй /мян.литр/	50 үнээтэй /мян.литр/
Үйлдвэрлэх сүү, (мян.л)	2484.0	3240.0
Үйлдвэрлэх мах, (амьдын жингээр)	1.6	2.6
Үржилд борлуулах гунж, /тол/	5	8
Шир, /ширхэг/	2	4

2022 онд Говьсүмбэр аймгийн сүүний эрэлтийн тодорхой хувийг дотоодын сүүгээр хангахын тулд Чойр орчмын бүсэд 5 ширхэг 30 үнээний фермерийн аж ахуй, 2 ширхэг 50 үнээний фермерийн аж ахуй байршуулах шаардлагатай б байна.

2022 он гэхэд 5 ширхэг 30 үнээтэй аж ахуй жилд 563925 литр сүү борлуулж, 894.2 сая төгрөгийн орлоготой ажиллах, 50 үнээтэй фермер 365000 литр сүү борлуулж, 912.0 сая төгрөгийн орлоготой ажиллах боломжтой юм.

Энэхүү дэд бүсэд фермерийн аж ахуйн суурингаас гадна таримал хадлан бэлтгэх, тэжээлийн ургамал тариалах, дарш бэлтгэх талбайг оролцуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад улирал харгалзахгүй гэрээний дагуу газрыг хуваарилж тухайн жилийн төлөвлөгөөнд хэсэгчилэн зааж оруулан ашиглуулна.

Сүүний үхэрт тохирох хүрэлцэхүйц бэлчээр, хадлангийн талбай, тэжээлийн ургамал тариалах, таримал хадлан бэлчээр бий болгох боломж өөрөөр хэлбэл саалийн аж ахуйд гаднаас худалдаж авахгүй зөвхөн өөрийн үйлдвэрлэлийн тэжээлээр хангаж байх зарчмыг баримтлах нь зүйтэй хэмээн үзэж өндөр ашиг шимтэй сүүний чиглэлийн үхрийн аж ахуй нь өөрийн үйлдвэрлэлд шаардагдах шүүст тэжээл ба хадлангийн хэрэгцээг өөрсдөө хангахаар тооцов.

**Хүснэгт 57. Сүүний чиглэлийн фермерийн аж ахуйд жилд шаардагдах тэжээл, тариалангийн ба хадлангийн талбайн хэрэгцээ**

Он	Сүүний чиглэлийн	Жилд шаардагдах тэжээл, мян.т	
		Талбайн	Үүнээс /га/

	үнээний фермерийн тоо	хэмжээ га	Таримал, хашсан бэлчээр 80%	Суурингийн талбай 5%	Нэмэлт тэжээлийн талбай 15%
2018-2020	3	900	720	45	135
2021-2022	5	1000	800	50	150


Сүүний үхэр сүргийн үүлдрийг сайжруулан өндөр ашиг шимтэй цэвэр үүлдрийн үхэр сүргийг голчлон хөгжүүлж, үхэр сүргийн дотор өндөр ашиг шимтэй үнээний эзлэх хувийн жинг тогтоож хэрэгжүүлэх. Мөн үнээний 60-аас доошгүй хувийг жил бүрийн 9-12-р сард төллөхөөр хээлтүүлэх ажлыг сүүний хэрэгцээг харгалзан зохион байгуулах хэрэгтэй юм.

#### 6.1.3.10. Хагас суурин мал аж ахуйн бүс нутгийн төлөвлөлт

Цаашид нутгийн малын чанарыг сайжруулах, Сүмбэр үүлдрийн каракул хонины удмын санг хамгаалан тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор зохих арга хэмжээ авах, бодлогоор дэмжих үйл ажиллагааг нэн даруй хийх нь зүйтэй байна. Сүмбэр үүлдрийн хонь өсгөн үржүүлэх зорилгоор хагас эрчимжсэн бүс нутгийг Сүмбэр сумын 6-р багийн нутаг дэвсгэрт байхаар тогтоолоо.



Сүмбэр үүлдрийн хуц  
Adult ram




Сүмбэр үүлдрийн эм хонь  
Adult ewe



Сүмбэр үүлдрийн төлгөн хуц  
Young ram



Сүмбэр үүлдрийн охин төлөг  
Young ewe



### **6.1.3.11. Хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн газрын төлөвлөлт**

Хотын хүн амын хүнсний хэрэгцээний өсөлттэй уялдуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өсөлт ба төрөлжилтийг хэрэгжүүлэхэд эрчимжсэн ба хагас эрчимжсэн аж ахуйн ферм, ногооны шилэн цамхаг, агуулах зоорь, мал нядалгааны цех, мал эмнэлэг, хүнсний лаборатори, услалтын систем зэргийг барьж байгуулах, түүнд шаардагдах хөрөнгө оруулалтыг аж ахуй бүрээр тооцож хэрэгжүүлэх хэрэгтэй.

Түүнчлэн эдгээр аж ахуй бүрээс бүтээгдэхүүн бэлтгүүлж, нийлүүлэн авах орчин үеийн хүчин чадал, багтаамжтай хөргөх, халаах тоноглол бүхий тээврийн хэрэгсэлтэй **хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборыг** хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн бүрийн хоорондын үйлдвэрлэлийн уялдаа холбоо, байршилт, хэмжээ, төрөлжилт, байгаль цаг уурын нөхцөл, хот суурины хүн амын байршил, зам харилцааны онцлогтой нягт уялдуулан Сүмбэр сумын 4-р багийн Тэвшид Сүмбэр айраг хоршооны баруун урд 6 га талбайд байршуулахаар төлөвлөлөө

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборт мах, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногоо нийлүүлэх өөр бололцоо нөхцөлийг бүрдүүлэх, малчин өрхүүдийн түүхий эдийн нөөцийг ашиглах, газар дээр нь үйлдвэрлэлийн аргаар боловсруулж хадгалах, мөн нөөцийг нэмэгдүүлэх урамшууллын бодлогыг хэрэглэх нь зүйтэй юм.

### **Бэлчээрийг зохистой ашиглах зөвлөгөө**

Сүүлийн жилүүдэд бэлчээрийн менежментийн бодлого алдагдаж бэлчээр доройтон, талхлагдал ихсэж байгаатай холбогдуулан, малын тоо толгойг хэт ихээр өсгөхгүй байх, бэлчээрийн даацад тохируулах, бэлчээрийг амрааж хуваарьтай ашиглах, байгалийн аясаар нөхөн сэргээх, бэлчээрийг жилийн дөрвөн улирлын турш тухайн газар нутгийг, эргэн сэргэж ургах чадваргүй болтол нь ашиглаж байгаад хатуу хяналт тавих, бэлчээр усжуулалтыг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Бэлчээр зохион байгуулалтыг малын төрөл, тоо толгой, бэлчээрийн онцлог байдал, даац ашиглалт, ургамлын сэргэн ургах чадвар зэргийг харгалзан малчидтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр хийх,
- Бэлчээрийн газрыг улирлаар, сар өдрөөр хэзээ хаана, ямар төрлийн малыг, хэр хугацаатай бэлчээрлүүлэх хуваарь гаргах, эхний удаа ашигласан бэлчээрийг 25-

30 хоногийн дараа хэнз ногоо идүүлж байхаар тохируулж бэлчээрийн эргэлтийг тогтоох,

- Өвөл, хаврын бэлчээрийг эртнээс нөөцөлж түүнийг холын болон ойрын бэлчээр гэсэн 2 хэсэгт хуваан ашиглах.
- Холын бэлчээр нь өвөлжөө, хаваржааны эзэмшил бэлчээрт хамгийн алсын бэлчээр бөгөөд мал тарган, хээл нь хүндрээгүй үед буюу өдрийн урт, цаг агаар дулаан үед гаднаас нь дотогшлуулах замаар ашиглахад тохиромжтой.
- Ойрын бэлчээр нь өвөлжөө, хаваржааны дэргэд хамгийн ойр нөөцөлсөн бэлчээр байх учраас цагийн хүнд нөхцөлд мал тарга хүчээ алдаж сульдаж турж эцсэн юмуу хээл нь томорч хүндэрсэн мал төллөж байгаа үед л ашиглах нь зүйтэй.
- Зун, намрын улиралд отрыг алс хол соргог сэрмүүн бэлчээрт хийх нь бэлчээр ашиглалтыг сайжруулан өвөл, хаврын бэлчээрээ хамгаалах ач холбогдолтой байдгийг анхаарах.
- Бэлчээр усжуулалтыг сайжруулах, эвдэрсэн худаг усыг засч сэлбэх,
- эзэмшилтэй болгох.
- Нэгэнт талхлагдсан бэлчээрийг наад зах нь 2-3 жил ашиглахгүйгээр өнжөөх,
- тусгайлан хамгаалж хүний үйл ажиллагаагаар болон байгалийн аясаар нөхөн сэргээх, мөн бэлчээрийг услах, бордох, хөрсийг хагалалгүйгээр сэндийлэх, дов сондуулыг хэрчих, тэгшлэх, олон наст ургамлын үр нэмэрлэн тарих зэргээр сайжруулах, таримал бэлчээр, хадлан бий болгох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх.
- Малыг нэг дор хэт олноор бөөгнөрүүлэхгүй байх, бэлчээрийн даацыг
- тохируулах.
- Бэлчээрийн газрыг мал бүхий иргэдэд гэрээгээр ашиглуулан бэлчээр
- ашиглалтанд байнгын хяналт тавьж ажиллах.
- Байгалийн болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах
- Сумын төвийн ойр орчинд говийн нөхцөлд элсэрхэг хөрсөнд ургах боломжтой
- хайлаас, улиас болон бусад мод сөөг, өвслөг ургамлыг тарьж, ногоон бүс байгуулахад сумын иргэд, хүүхэд залуучуудыг идэвхитэй оролцуулах, элсний нүүлтгээс хамгаалах.


- Мал маллагааны уламжлалаа сэргээж, бэлчээрийг сэлгэн ашиглах, нүүдлийн
- давтамжийг нэмэгдүүлэх, уст цэгийг шинээр буй болгох, эвдэрсэн худгийг засварлан ашиглах зэрэг арга хэмжээг авч бэлчээр талхлахаас сэргийлэх нь зүйтэй.
- Чойр хот нь 4 аймгийн 10 гаруй сумдтай хиллэдэг. Говь хээрийн бүс
- оршдог, газар тариалан, төмс, хүнсний ногоо тариалах, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх хөрс ургамлын таатай орчинтой.

## **6.2. ХОТ, ТОСГОН, БУСАД СУУРИНЫ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ**

Хот суурин газрын ашиглалт хязгаарлагдмал орон зайд олон төрлийн зориулалтаар ашиглагддаг, нягтрал ихтэй, эзэмшил ашиглалтын нарийн горим хувиарлалттай, экологийн хямралд нэн өртөмтгий байдаг онцлогтой. Говьсүмбэр аймаг нь дэд бүтцийн хөгжлөө дагасан суурьшмал амьдралтай боловч үндэсний уламжлалт нүүдлийн мал аж ахуйн зэрэгцээ үйлдвэр, уурхай болон Оросын цэргийн ангийн бүтээн байгуулалтыг дагасан хот маягийн амьдрал эрчимтэй хөгжсөн юм.

### **1.2.1. Бүлэг суурин ба хөгжлийн таталцал**

Говьсүмбэр аймгийн нутаг нь засаг захиргааны нэгжийн хувьд 3 сумтай бөгөөд Дорноговь аймгаас тасарч тусдаа аймаг болсон. Говьсүмбэр аймаг нь газар зүйн байрлал, зам харилцаа, дэд бүтэц, хүн амын төвлөрлөөрөө томоохон аймгийн төв байх бүрэн нөхцөл бүрдсэн бөгөөд Дундговь аймгийн Говь-Угтаал, Цагаандэлгэр, Даланжаргалан, Хэнтий аймгийн Дархан, Дорноговь аймгийн Даланжаргалан, Айраг сумдууд таталцаж, бүлэг суурины төвөөр Чойр хот хөгжих хандлагатай байна. Бүлэг суурины төв болон хөгжсөнөөр Монгол улсын төвд тэмүүлсэн эдийн засаг, зам харилцаа, бизнесийн асар их төвлөрлийг даллан дуудаж чадах эдийн засаг, бизнес худалдаа, үйлдвэрлэл, соёл боловсролын чөлөөт хот болох нь дамжиггүй юм.



### 1.2.2. Сумын төвийн эзэмшил газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт

Сүүлийн жилүүдэд Говьсүмбэр аймгийн нийт хүн амын 60 хувь нь суурин амьдралын хэв маягаар амьдрах болсон байна. Иймээс аймаг, сумын төвүүдийн тогтвортой хөгжлийг хангахад газар ашиглалтыг байгалийн нөхцөл, нөөц, чадавхитай нь уялдуулан зөв төлөвлөж, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн нэгдмэл бодлогыг баримталж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан тогтвортой хөгжих үндсийг бүрдүүлэх шаардлагатай болжээ.

Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2014 онд “Форум арт” ХХК гүйцэтгэсэн байна. Аймаг, сумын төвүүдийг батлагдсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу эрчимтэй хөгжүүлэх зарчим баримтална.

Газар ашиглалтын чиглэлүүд

1. Цэцэрлэгийн
2. Сургуулийн
3. Онцгой байдлын
4. Жижиг дунд үйлдвэрлэлийн
5. Усан сангийн хамгаалалтын
6. Мэдээлэл холбоо сүлжээний
7. Одоо байгаа орон сууцны
8. Гэр хорооллын
9. Нийтийн цэцэрлэгт хүрээлэн, амралт зугаалгын
10. Эмнэлгийн
11. Ногооны талбай
12. Эмнэлгийн
13. Засаг захиргааны
14. Хамгаалалтын
15. Орон сууцны
16. Эдэлбэр газартай амины орон сууцны
17. Нөөц талбай
18. Таун хаусын
19. Худалдаа олон нийтийн
20. Үйлдвэрийн
21. Цагдаагийн
22. Хорих ангийн



Чойр хотын Газар ашиглалтын хэтийн төлөв

Д/д	Барилга байгууламжийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тайлбар
1	Нийт эдэлбэр газар	м2/га	1787800	1787.8га
2	Барилгажсан талбай /эдэлбэр газартай /	м2/га	5208900	520.89га
3	Авто зам В-20	м2/га	1150100	115.01га
4	Явган зам /өнгөт хавтан/	м2/га	652500	65.25га
5	Ногоон байгууламж	м2/га	10866500	1086.65га
6	Ногоон байгууламж	%	60	
7	Барилгын нягтрал /эдэлбэр газартай /	%	29.1	



ГАЗАР АШИГЛАЛТЫН ХУВИАРЛАЛТ

65 ХЭСГИЙН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ

1-р хэсэг	- 9.1га	34-р хэсэг	- 7.3га
2-р хэсэг	- 11.9га	35-р хэсэг	- 2.6га
3-р хэсэг	- 25.6га	36-р хэсэг	- 3.7га
4-р хэсэг	- 2.1га	37-р хэсэг	- 3.6га
5-р хэсэг	- 5.4га	38-р хэсэг	- 2.7га
6-р хэсэг	- 4.8га	39-р хэсэг	- 2га
7-р хэсэг	- 2га	40-р хэсэг	- 6.1га
8-р хэсэг	- 1.8га	41-р хэсэг	- 2.3га
9-р хэсэг	- 4.1га	42-р хэсэг	- 1.2га
10-р хэсэг	- 5.1га	43-р хэсэг	- а11.9га, 63.2га
11-р хэсэг	- 3.1га	44-р хэсэг	- 34.3га
12-р хэсэг	- 8.7га	45-р хэсэг	- 25.6га
13-р хэсэг	- 15.5га	46-р хэсэг	- 28.4га
14-р хэсэг	- 2.7га	47-р хэсэг	- 8.3га
15-р хэсэг	- 5.2га	48-р хэсэг	- 10.3га
16-р хэсэг	- 5.8га	49-р хэсэг	- 4га
17-р хэсэг	- 2.7га	50-р хэсэг	- 3.1га
18-р хэсэг	- 11.7га	51-р хэсэг	- 4.7га
19-р хэсэг	- 5.8га	52-р хэсэг	- 34га
20-р хэсэг	- 17.3га	53-р хэсэг	- 58.7га
21-р хэсэг	- 17.6га	54-р хэсэг	- 113.5га
22-р хэсэг	- 6.5га	55-р хэсэг	- 3.5га
23-р хэсэг	- 10га	56-р хэсэг	- 27га
24-р хэсэг	- 4.4га	57-р хэсэг	- 2.7га
25-р хэсэг	- 11.6га	58-р хэсэг	- 16.1га
26-р хэсэг	- 2.6га	59-р хэсэг	- 125.3га
27-р хэсэг	- 8.7га	60-р хэсэг	- 3.1га
28-р хэсэг	- 3.9га	61-р хэсэг	- 511.5га
29-р хэсэг	- 3.9га	62-р хэсэг	- 92.9га
30-р хэсэг	- 17.6га	63-р хэсэг	- 80.6га
31-р хэсэг	- 3.9га	64-р хэсэг	- Усны эх Үүсвэр
32-р хэсэг	- 2.2га	65-р хэсэг	-Цэвэрлэх байгууламж
33-р хэсэг	- 15.3га		

## ҮҮРЭГ ЗОРИУЛАЛТЫН БҮСЧЛЭЛ



## 1.2.2.1. Суурьшлын бүс

1. Одоо байгаа “Хонхор” хотхон буюу төмөр замын хэсэгт нягтралыг сайжруулан, УБ-аас Замын үүд чиглэлийн авто замын баруун хойт хэсэгт шинэ суурьшлын бүс 1000 айлын орон сууц, замын эсрэг талд газрын налууг ашиглан цэцэрлэгт хүрээлэн, амарч зугаалах газар байхаар төлөвлөх

2. Суурьшлын бүсийн худалдаа үйлчилгээний газрын үнэлгээний байдлыг харгалзан зам дагуух эсвэл суурьшлын бүстэй ойр орших, газрын үнийн хувьд өндөр байх магадлалтай газруудад үйлчилгээг байршуулав.

Газрын үнэнд нөлөөлдөг гол хүчин зүйлсүүд нь тухайн газрын байршил, ашиглалтын зориулалт байдаг. Худалдаа үйлчилгээний зориулалтаар ашиглаж буй газар нь үйлдвэрийн зориулалтын газраас ямагт үнэтэй байдаг. Өөрөөр хэлбэл тухайн газрыг худалдаа, үйлчилгээний зориулалтаар ашиглавал газраас олох ашиг, орлого их байна гэсэн үг юм. Төлөвлөлт хийж буй газар нь үйлдвэрийн парк боловч бусад үйлчилгээ, худалдаа эрхлэх сонирхолтой иргэд, компаниудын сонирхолыг татах нь

олон ашиг тусыг үзүүлнэ. Аливаа хот, сууринд суурьшлын бүс, худалдаа үйлчилгээний бүсийг зөв төлөвлөж өгснөөр тухайн бүс нутагт амьдрахад таатай, тохилог амьд орчин бүрдэж өгдөг. Иймд худалдаа, үйлчилгээний бүсийг хамгийн байршил сайтай, өндөр үнэтэй газруудаар байршуулав.

#### 1.2.2.2 Үйлдвэрлэлийн бүс

Одоогийн байгаа үйлдвэрийн бүс нь зонхилох салхины чиглэлээр доор нь байрладаг боловч салхи нь байгалийн тогтоцоосоо хамаарч чиглэл нь өөрчлөгддөг байна. Иймд шинээр нөөц үйлдвэр аж ахуйн бүсийг зүүн урд зүгт төлөвлөлөө.

Үйлдвэр аж ахуйн бүсэд хөнгөн ба хүнсний үйлдвэрүүд төв ба суурин газруудад үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг жижиг, дунд үйлдвэрлэл, хотын нийтийн аж ахуйн зориулалттай барилга байгууламжууд, тэдгээрийн туслах барилга, түүхий эд авах цэг, авто машины үйлчилгээ, засварын газрууд, гараж ,

ХАА-н чиглэлийн аж ахуйн чиглэлийн үйлдвэрлэл агуулахууд, эрчим хүч инженерийн барилга байгууламжууд орно.

Үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрийг улсын чанартай авто зам, төмөр замаар огтлолцуулахгүйгээр төлөвлөх учир Төмөр зам доогуур явган хүний гарц төлөвлөж өглөө.

Үйлдвэрийн бүсийг суурьшлын бүсээс төмөр зам болон авто замын 2 талын хамгаалалтын зурвас газраар тусгаарлагдсан бөгөөд шинээр төлөвлөх үйлдвэрийн нөөц бүсийг хор бохирдол багатай үйлдвэрийг суурьшил, худалдаа үйлчилгээний бүстэй ойр, бохирдол ихтэй үйлдвэрийг хол байхаар цэцэрлэгт хүрээлэнгээр зааглан тусгаарлаж төлөвлөх Зам, инженерийн дэд бүтэц нь хямд төсөр, энгийн байх зарчмыг баримталсан тул замын сүлжээг хот хоорондын замыг оглолцуулахгүйгээр 2 газарт эргүүлэгтэйгээр зам доогуур шинээр авто зам төлөвлөж, 1000 айлын төлөвлөлтийг төмөр замын хэсэгтэй хот хоорондын замын доогуур явган замаар гарахаар төлөвлөж холбож өгсөн болно.

Төмөр замын баруун талд үйлдвэрийн бүс газрын 61-р хэсэгт Аяганы гудамжинд өмчлүүлсэн 25.3 га газрыг тус бүсээс өөр газарт шилжүүлэх нь зүйтэй. Мөн төмөр замын баруун талд байх бохирын нуурыг төвлөрсөн бохирын шугамтай холбох ажлыг хийх хэрэгтэй.

#### 1.2.2.3 Ногоон байгууламжийн бүс

Аймгийн хэмжээнд Хот хоорондын замын баруун талд цэцэрлэгт хүрээлэн, амрах, зугаалах хэсгийг стадион, зочид буудлыг хамт байхаар нийт ... га-д төлөвлөж өгсөн.

о “Хонхор” хотхон болон үйлдвэрийн нөөц талбайн хооронд тусгаарлах цэцэрлэгт амралт зугаалгын ногоон байгууламжийг Орос цэргийн хөшөөтэй уялдуулан төлөвлөж өглөө.

о Мөн одоо байгаа гэр хорооллын баруун талд хонхор газар бороо цасны усыг цуглуулан цөөрөм байгуулж цэцэрлэгжүүлэн амралт зугаалгын хэсэг байхаар газрыг төлөвлөв.

о Хот хоорондын зам дагуу хамгаалалтын 80м өргөнтэй ногоон байгууламж, мөн хот хоорондын замын баруун талд цэцэрлэгт хүрээлэн, амрах, зугаалах хэсгийг стадион, зочид буудлыг хамт байхаар төлөвлөж өгсөн.

Чойр хот Монголын Дорнод тал нутгийн баруун зах тушаа, хуурай хээрийн бүсийн өмнөт хэсэгт байрлана. Уур амьсгалын хувьд хуурай сэрүүвтэр зунтай, хүйтэн өвөлтэй мужид багтана. Агаарын жилийн дундаж температур 0С, 7 дугаар сарын агаарын дундаж температур +18.7С, 1 дүгээр сарынх -20.5С байна. Зарим өвөл -32С-39С хүртэл хүйтэрч, зундаа +33С+36С хүртэл халуун болох ч бий. -30С буюу түүнээс бага температуртай их хүйтэн үе жилд дунджаар 20 шахам хоног үргэлжилнэ.

Харин +30С буюу түүнээс дээш температуртай их халуун өдрийн тоо 25 орчим байна. Жилд унах хур тундасны хэмжээ 196.4 мм, +10С-аас дээшхи агаарын идэвхитэй температурын нийлбэр жилд дунджаар 2017С байна. Хамгийн анхны цас 10 дугаар сарын 2-нд орж байсан бол сүүлчийн цасыг 5 дугаар сарын 7-нд ухаж байжээ. Өвөлдөө цасан бүрхүүл тогтвортой байх хугацаа дунджаар 12 дугаар сарын 3-аас, 02 дугаар сарын 17 хүртэл үргэлжилж, цасны хамгийн зузаан 14 см хүрнэ. Дулааны улиралд тохиолдох халуун, хуурай салхи харьцангуй цөөн, 25 хоног үргэлжилдгээрээ тал хээрийн бүсэд орших бусад аймгийн төвүүдээс ялгаатай.

Чойр хотын нутаг дэвсгэрийн доторхи хөрс ургамал нь хүний нөлөөгөөр устаж үгүй болсон, ойр орчмын бэлчээрийн даац хэтэрч, багагүй талхлагджээ. Ялангуяа автомашины олон салаа зам, цэргийн хаягдмал барилга байгууламжаас болж, орчин тойрны газар ихээхэн эвдэгдэж, газрын доройтолд сүрхий нэрвэгдсэн байна. Үүний зэрэгцээ хог хаягдал ихтэйн уршгаар хөрс, усны бохирдол үүсэх нөхцөл бүрджээ. Иймээс хот орчныг тохижуулах, хотын гудамж, талбайг зүлэгжүүлэх, мод сөөг тарих, хог хаягдлыг зайлуулах, ухаж сэлгэгдсэн газрыг тэгшлэх, хөрсний эвдрэлтэй тэмцэх,

бэлчээрийн ургамлыг нөхөн сэргээх талаар тодорхой зорилтот ажил зохион байгуулж, түр зуурын бус тогтмол үйл ажиллагаа явуулахгүй бол хуурайшилт, цөлжилтийн довтолгоон эрчимжиж буй өнөө үед эргэж нөхөшгүй экологийн гамшиг учирч болзошгүйг анхаарах хэрэгтэй.

Төлөвлөлт

1. Нийтийн хэрэгцээний зориулалттай цэцэрлэгжүүлэлт;

2. Хязгаарлагдмал зориулалттай цэцэрлэгжүүлэлт;

3. Тусгай зориулалттай цэцэрлэгжүүлэлт гэсэн 3 бүлэгт зориулалтаар нь ангилж төлөвлөлт хийсэн.

Нийтийн хэрэгцээний зориулалттай цэцэрлэгжүүлэлт-д цэцэрлэгт хүрээлэн, орон сууцны цэцэрлэгжүүлэлт, цэцэрлэгт талбай, цэцэрлэгт гудамж, модот гудамж болон зүлэгжүүлсэн гудамж хамрагдана.

Хязгаарлагдмал зориулалттай цэцэрлэгжүүлэлт-д сургууль, цэцэрлэг, ясли, эмнэлгийн байгууллага болон бусад иргэн, олон нийтийн барилгын эдэлбэрийн цэцэрлэгжүүлэлт орно.

Тусгай зориулалттай цэцэрлэгжүүлэлт-д орон сууцны хорооллыг үйлдвэрийн газраас тусгаарласан хамгаалалтын бүс, гудамж замын цэцэрлэгжүүлэлт, гуу жалга, хөрсний эвдрэл, элсний нүүлт зэргээс хамгаалсан ногоон байгууламж орно. Хот суурины төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм “БНБД30.01.03”-ийн дагуу аймгийн төв хотын 1 оршин суугчид 12 м<sup>2</sup> нийтийн хэрэгцээний ногоон суулгамал ногдож байх ёстой. Байгаль цаг уурын хагас цөл, цөлийн бүсэд 20.0-30.0-аас ихгүйгээр бууруулж болно. Иймд Чойр хотын нэг оршин суугчид эхний ээлжинд 9.6 м<sup>2</sup> ногдохоор төлөвлөв. Эхний ээлжинд 13.5 га, төлөвлөлтийн хугацаанд 21.6 га байх бөгөөд үүнээс зүлэгжүүлэх талбай нь эхний ээлжинд 6 га, төлөвлөлтийн хугацаанд 10 га байна. Төлөвлөлтийн нормын дагуу эхний ээлжинд 4050 мод, 12150 сөөг, 18 кг зүлэгний үр, төлөвлөлтийн хугацаанд 6480 мод, 19440 сөөг, 30 кг зүлэгний үр шаардлагатай.

Хязгаарлагдмал зориулалттай цэцэрлэгжүүлэлтэд орон сууцны хороолол, үйлдвэрийн газар, цэцэрлэг, ясли, эмнэлгийн орчны цэцэрлэгжүүлэлтийг хамруулна. Орон сууцны хорооллын 1 оршин суугчид 5.0 м<sup>2</sup> ногоон байгууламж ногдох ёстой. Тус хотын орон сууц, гэр хорооллын ногоон байгууламжийн нийт хэмжээ эхний ээлжинд 7.0 га, төлөвлөлтийн хугацаанд 12.6 га байх бөгөөд цэцэрлэгжүүлэхэд эхний ээлжинд 1050 мод, 3150 сөөг, төлөвлөлтийн хугацаанд 1890 мод, 5670 сөөг тус тус шаардлагатай

байна. Сургууль, цэцэрлэг, яслийн 1 хүүхдэд ба эмнэлгийн тохижуулалтанд 1 хүнд 30-50 м<sup>2</sup> ногоон байгууламж ногдож байх ёстой. Эхний ээлжинд сургуульд 5.7 га, цэцэрлэг яслид 1.05 га, эмнэлэгт 0.3 га, төлөвлөлтийн хугацаанд сургуульд 13.4 га, цэцэрлэг яслид 2 га, эмнэлэгт 0.6 га байна. Төлөвлөлтийн нормын дагуу тооцоход эхний ээлжинд сургуульд 570 мод, 1710 сөөг, цэцэрлэг яслид 105 мод, 315 сөөг, эмнэлэгт 30 мод, 90 сөөг, төлөвлөлтийн хугацаанд сургуульд 1340 мод, 4020 сөөг, ясли цэцэрлэгт 200 мод, 600 сөөг, эмнэлэгт 60 мод, 180 сөөг тус тус тарихаар төлөвлөв.

Тусгай зориулалтын цэцэрлэгжүүлэлтэд Мянганы авто зам дагуухи ногоон байгууламж төлөвлөж өгөв. Тухайн хамгаалалтын бүсийн замын нэг талын өргөн 30 м, урт 320 м, нийт талбайн хэмжээ 1.0 га байна. Хамгаалалтын нийт зурваст 2.0 га ногоон байгууламж байна. Үүнд: 10240 сөөг, 3328 мод ногдож байна. Говьсүмбэр аймгийн Чойр хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд хэрэглэх нийт мод сөөгний хэмжээ эхний ээлжинд 29.6 га, төлөвлөлтийн хугацаанд 50.2 га, тэдгээрийг цэцэрлэгжүүлэхэд эхний ээлжинд 7469 мод, 27655 сөөг, төлөвлөлтийн хугацаанд 9970 мод, 22620 сөөг тус тус шаардлагатай байна. Цэцэрлэгжүүлэлтэнд хэрэглэх ногоон суулгамлын ойролцоо өртөг эхний ээлжинд 36389.0 мян.₮, төлөвлөлтийн хугацаанд 38565.6 мян.₮ байна.

Зам дагуухи ногоон байгууламжийг төлөвлөхдөө агаарын бохирдол, өөрөөр хэлбэл, тээврийн хэрэгслээс гарч буй хий, утаа, тоосжилтонд тэсвэртэй мод сөөгийг сонгосон. Үүнд: анхилуун улиас, шар хуайс, эгэл нарс зэрэг мод ба сөөгийг төлөвлөж өгсөн.

Нийтийн хэрэгцээний ногоон байгууламжид орон сууцны ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг гоо үзэмж, эрүүл ахуйн шаардлага хангасан, хүн ам, иргэд амьдрах, амрах таатай орчныг бүрдүүлэх, бичил уур амьсгалыг сайжруулах зорилгоор: гацуур, анхилуун улиас, шинэс, нарс, жигд улиангар, дагуур тэрэлж, монос, хайлаас, нохойн хошуу, тавилгана, монгол бургас, шар хуайс, үрэл төлөвлөв.

Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэнд хэрэглэсэн мод ба сөөгний товч тодорхойлолт

1.Эгэл нарс Өтгөн саглагар титэмтэй, 40 м хүртэл өндөр, 80 см хүртэл бүдүүн гувартай, нимгэн хальслаг холтостой, холтос нь орой тийшээ дээшлэх тусам нимгэрч, улаан шаргал өнгөтэй болдог. Модны гуврын доод хэсгийн холтос хар саарал өнгөтэй. Нэг нахианаас 5 см урт, 1.5 мм бүдүүн хатуу ногоон саарал өнгийн 2 шилмүүс гардаг, 3-7 см урт, 1-2.5 см бүдүүн зуйван давирхайлаг боргоцойтой, тэр нь намар боловсорч,

өвөлжөөд хавар 3 дугаар сараас дулаарахад задарч үрээ хаядаг. Шилмүүс нь ээлжлэн унаж ургадаг учраас мөнх ногооноороо байдаг. Хотын гудамж талбайд тарихад чимэглэлийн ач холбогдолтой, тоос шороо өөртөө сайн барьдаг, анхилам үнэртэй боловч ургах орчин, нөхцөл арчилгаа шаарддаг. Наранд тэсвэртэй ч арчилгаа усалгааг агротехникийн дагуу тогтмол хийх шаардлагатай. Хөнгөн элсэрхэг хөрсөнд сайн ургадаг.

2.Сибирь гацуур Манай оронд ганцхан төрлийн гацуур ургадаг бөгөөд барзгар хар саарал холтостой, 30 м хүртэл өндөр ургадаг мод юм. Мөчир нь ишний ёроолоос салаалж, цацаг хэлбэр үүсгэдэг. Ерөнхий төрх нэг нахианаас нэг шилмүүс гаргадгаараа жодоотой төстэй боловч боргоцой нь унадаггүй, 3-5 см урт, өндгөн хэлбэртэй. Өргөсөрхүү хурц үзүүртэй, хатуу хар ногоон хааяа яарал өнгөр бүхий шилмүүстэй. Мөнх ногоон мод бөгөөд шилмүүс нь нэг нэгээрээ аажим солигдож байдаг. Мөнх цэвдэгтэй хад чулуурхаг ба хөвдтэй газар ургадаг. Хотын гол талбай чимэглэлийн зориулалтаар тарьдаг гол мод, үржил шимтэй хөр-сөнд суулгаж, арчилж тордвол дулаан, хүйтэн, нар, салхи чийгийг сайн тэсвэрлэж ургадаг. Гацуурыг хотын хувьд өргөн хэрэглэдэг бөгөөд хот чимэглэх чанараараа сайн, арчилгаа харьцангуй бага шаарддаг мод юм.

3.Сибирь шинэс Хөрс голдоггүй, бүх төрлийн хөрсөн дээр ургадаг. Модны өндөр 30 м, гол төлөв 24-26 м өндөртэй ургадаг, гуврын диаметр нь 26-28 см. Наранд дуртай, салхи, тортог утаа, тоосжилт ба хүйтэнд тэсвэртэй, тайралт хийгддэггүй. Титэм конус хэлбэртэй, цайвар ногоон өнгийн шилмүүстэй.

4.Лавр навчит улиас Цагаан шаргал холтостой, 25 м хүртэл ургадаг, навчит мод. Гувар нь голчоороо 40-50 см, заримдаа 70 см хүртэл бүдүүрдэг. Өргөн ногоон навчтай, хавар эрт молцоглож, зундаа ногоорон, намартаа навчаа гөвдөг анхилуун үнэрт мод. Нийслэл хотын олон гудамж талбайд зонхилж суулгасан хотыг чимдэг гол мод. Эр, эм улиасыг ялгаж тарихгүйгээр, эм улиаснаас мөчир бэлтгэн үржүүлж, хотод суулгаснаас өнөөдөр нас гүйцэж, үр өгч, түүний цацагт үр хийсэж, хотын дотор хог болоод зогсохгүй, зарим хүмүүст харшил өгдөг. Иймээс эр улиаснаас мөчир бэлтгэж, хот цэцэрлэгжүүлэлтэнд хэрэглэх нь зүйтэй.

5.Улиангар 15-20 м ургадаг, шаргалдуу юм уу, бор ногоон нимгэн холтостой, шингэн мөчиртэй, эгц шулуун ургадаг мод. Навчны бариул нүцгэн, уртаараа навчныхаа илтэстэй тэнцүү. Цэцгийн дагавар хайрс хүрэн, ерөнхийдөө өндгөрхүү

салбангуудад хуваагддаг. Дохиур 9, тоосовч нь улаан хүрэн. Залуу зулзган улиангарыг шилжүүлэн суулгах замаар хотын цэцэрлэгжүүлэлтэнд хэрэглэдэг.

6. Азийн монос Олон салаа мөчир бүхий саглагар мод. Газрын хөрснөөс дээш богинохон иш гарч тэр нь цааш бутлан салаалж ургадаг. Цацаг нь 10-15 см урт доошоо унжсан байдалтай. Урт шилбэн дээр суусан цагаан цэцэгтэй. 4-10 см урт, 2-4 см өргөн, зууван, эсвэл өргөвтөр тонгоруу өндгөн хэлбэртэй, шовх үзүүр, богино бариултай, нүцгэн навчтай. Мойл хэмээх жимс нь аргуун, ясархаг, гүйцэд боловсорсон нь тас хар өнгөтэй, шүүслэг. Сагсайж ургадаг учраас Парк, цэцэрлэгт чимэглэлийн зориулалтаар тарьж ургуулахад тохиромжтой. Цагаан цэцэг нь хавар жигд дэлгэрэхэд орчноо үзэмжтэй болгодог.

7. Үрэл Сааралдуу цагаан холтостой, бөөрөнхий титэмтэй, тахир богинохон иштэй жижгэвтэр мод. 1.5-4.0 см урт, өндгөрхүү, гонзгой нүцгэн навчтай, бөөрөнхий, улаан шаргал, эсвэл хүрэн улаан жимстэй, голчоороо 0.6-0.8 см цайвар буюу цайвар ягаан цэцэгтэй, наран тал нь улаан, сүүдэр тал нь шаргал, жимс нь алсаас гоо үзэмжтэй харагддаг. Үрлийг голдуу үрээр тарьж бойжуулан, хотод суулгана. IX сарын эхээр үр нь боловсорно.

8. Дагуур тэрэлж Олон салаа мөчиртэй, 0.5-2.0 м өндөр, үсэрхэг, нарийн улаан шаргал найлзууртай, туяхан нарийн иштэй, мөчир салаа нь бор саарал холтостой, илэглэг зузаан, судлаа дагасан үсэнцэр бүхий навчтай, ягаан цэцэгтэй. Хавар эрт цэцэглэдэг.

9. Монгол бургас Цайвар саарал холтостой, 4 м хүртэл өндөр ургадаг, газраас дээш ил гарсан богино иш нь цааш салаалан, өтгөн саглагар сөөг болдог. Залуу мөчир найлзуур нь бүдэг хүрэн, ногоон хүрэн өнгөтэй, 3-7 см урт, 4-6 мм өргөн, сууриараа нарийн, захаараа хөрөөн шүдлэг, зузаан, гонзгойвтор зууван, зэгэл ногоон өнгөтэй, навчных нь доод тал нь цайвар саарал өнгөтэй, навчны бариул нь урт, эм молцог нь 2-3 см урт бортгордуу хэлбэртэй бөгөөд навчирхаг богино найлзуур дээр оршино. Хөгширсөн иш мөчрийг тайрах тусам нялх найлзуур зүг бүрээс нь ургаж салаалдаг.

10. Шар хуайс 2-5 м хүртэл өндөр ургадаг, ногоовтор эсвэл боров-тор зөөлөн найлзууртай 4-7 хос навчинцар бүхий хос өдлөг нийлмэл навчтай. Навчинцар нь өндгөрхүү, эсвэл гонзгой зууван үсэрхэг эсвэл нүцгэн гадаргуутай. Цэцгийн нэг шилбэнээс 1-2 цэцэг гарч, улмаар 2-5 цэцэг бүхий баг үүсгэнэ. Дэлбээ нь цоморлигоосоо 3 дахин урт, шар өнгөтэй, бойтог хэлбэртэй, буурцаг нь шугамархуу. Үрээр ургахдаа хялбар.



11.Тарваган хайлаас 5-10 м хүртэл өндөр, шар холтостой, навчны нахиа мохоо өндгөрхүү, арьслаг зузаан юлд хэлбэртэй, жижиг навчтай, навчны голоос 2 тийш гарсан тэгш хэмтэй тод хээтэй. Хэлбэржүүлэлт даадаг, ганд тэсвэртэй.

12.Нохойн хошуу 2 м өндөр ургадаг, өргөслөг, 3-10 см урт өдлөг нийлмэл навчтай, зууван хэлбэртэй, хурц орой бүхий 5-7 навчинцраас бүрдэнэ. Голчоороо 3-6 см ягаан, хүрэн улаан өнгийн 5-7 дэлбээт цэцэгтэй, гоо үзэмжтэй.

13.Жигд 10 м өндөр, цагаан өнгийн хайрсан үсэнцэр бүхий салаа мөчиртэй. Гонзгой шугаман навчтай, 2-3 см өргөстэй. Цэцэг нь хос бэлэг-тэй. Шадар эрхтэн нь хонхон буюу бортгорхуу хэлбэртэй. Өндгөрхүү мая-гийн 4 далбангаас тогтоно. Навчны өнгөн тал нүцгэн, үзүүр хавиараа үсэр хэг, шаргал өнгөтэй, гадна тал нь цайвар хайрсан үсэнцрээр хучигдсан учраас мөнгөлөг цагаан харагддаг. Хуурай яст жимстэй. Ганд тэсвэртэй.

14.Удвал навчит тавилгана 0.4-1.0 м өндөр, улаан хүрэн өнгийн холтостой, залуу, мөчир найлзуур нь үсэрхэг, жижиг навчтай, тэр нь олон янзын хэлбэр дүрстэй. Навчны өвөрт 2-7 цэцэг бүхий цагаан өнгийн бамбай бага цэцэгтэй.

Ногоон байгууламж байгуулах технологи, онцлог

Навчит модны суулгацыг хэмжээ ба чанараар нь 3 зэрэгт ангилна. Навчит модны суулгацын гадаад байдал нь хэвийн холтос нь шалбарч гэмтээгүй, өвчин, хортонд нэрвэгдээгүй, нахиа нь хугацаанаасаа өмнө дэлгэрээгүй, уян зөөлөн, мөчир найлзуур ихтэй, гувар нь бүдүүвтэр, эгц шулуун бат бэх, үндэс ихтэй, өсөлт сайтай байх ёстой. Модны титэм зөв хэлбэртэй, гол ишний үзүүрээсээ 2/3 нь салаалсан хэлбэртэй. Модны гадаад байдал, хэлбэрт тавих шаардлага 3 зэрэглэлд адил байна. Үндэсний хувьд өсөлт, хөгжил сайтай, 3-аас доошгүй гол үндэс салаалсан, сахлаг үндэс ихтэй байх бөгөөд үржил шимт шороотой нь авчирна.

Мод үржүүлгийн газраас ухаж авсан улиас, хайлаас зэрэг мод сул хөрстэй газар байсан бол тэр нь асгарч, үндэс нь ил гарч болно. Энэ үед ухаж авсан модоо усан зуурмагт яаралтай хийх, нойтон элс шороогоор хучих, шан татаж, үндсийг нь далд ортол шороогоор булж услах зэргээр үндсийг нь нарнаас хамгаалах хэрэгтэй. Навчит модыг мод үржүүлэг, ойгоос авах стандарт УСТ 1135-74-г баримтлан ажиллана. Модны нар луу харсан талд нь даавуу уяж тэмдэг тавина. Энэ нь модны нар луу харсан талыг солихгүй байх зорилготой. Суулгацыг хавар (20.IV-25.V) газар гэссэний дараа намар (01.X хүртэл) ургалт зогссоны дараа суулгасан байна. Шилмүүст модны хувьд мөн хэмжээ чанараар нь 3 зэрэгт хуваах бөгөөд гадаад байдал хэлбэрт тавигдах

шаардлага нь навчит модныхтой төстэй байна. Титэм зөвтэй, салаалсан мөчрүүд нь гол ишний үзүүрийн 3/4-ийг эзэлсэн байх, үндэсний хувьд 3-аас доошгүй гол үндэстэй, салаалсан үндэс ихтэй, үржил шимтэй хөрстэй хамт авна. Шилмүүст модны суулгацын үндсэн салаа мөчрүүдийг доороос нь өөд шуухдаа холтосны гадаргаас 5-10 мм илүүгүй хэмжээнд огтолж, үлдсэн ёзоорыг тосон будгаар будаж, өвчлөхөөс сэргийлэх, нар хэт төөнөхөөс хамгаалж, шохойгоор будсан байна.

Ойгоос стандартын шаардлага хангасан мод авахын тулд ойн зах, чөлөөнд байгаа хэвийн өсөлттэй зулзган, 1.5-3.0 м өндөртэй модыг сонгоно. Тарих модыг сонгохдоо үндэсний хүзүүнээс дээш аажмаар нарийссан туяхан иштэй шовгордуу титэмтэй гоолиг модыг сонгож авах нь чухал. Авсан модныхоо үндэс, орчны хөрс, шороог хамгаалахын тулд даавуу, эсвэл шуудайгаар ороож сайтар баглана. Хөрс шороотой нь авчирсан модыг зөв суулгаж, сайн арчилбал, шинэ залуу үндэс гарч улмаар амьдрах чадвар нь жил ирэх тутам нэмэгдэж, эрчимтэй ургаж эхэлнэ. Үндэсний шороог 1.0-1.2 м диаметртэй нүхэд багтахгаар бодож, 40 см өргөнтэй шуудууг 0.6-0.7 м гүн ухаж модоо авах хэрэгтэй. Мод тарихдаа хайрга чулуутай хөрсийг зөөн зайлуулж, нүхний ханыг доош эгцэлж, тэгшилнэ. Дан хар шороо нягтарч, наанги болон хувирдаг тул хөрсийг сийрүүлэхийн тулд элс хайрга бага хэмжээтэй хийж өгнө. 2-3 м өндөр модонд голчоороо 80 см, гүнээрээ 60 см, бут сөөгөнд голчоороо 40-50 см, гүнээрээ 40 см нүхийг дээрхийн адил ухаж бэлтгэнэ.

Мод тарихаар бэлтгэсэн нүхээ урьдчилан услаад, авчирсан модоо нүхнийхээ голд эгц байрлуулна. Суулгасны дараа бэлтгэсэн хар шороо, элсийг нүхэндээ эргэн тойрон бага багаар хийж, дүүргэн, модны эргэн тойрон чигжиж нягтруулна. Үлдсэн шороогоор тогоо бэлтгэн, ямар нэгэн газраар сэтрэхээргүй нягтруулан барьцалдуулж ташиж өгнө. Тогооны хажуу ирмэгийн өндөр 10-15 см байна. Суулгасан модоо бэхлэх хэрэгтэй, учир нь модны үндэс шороонд булагдаж, нягтарч хүндрээгүй тул услах үед хазайх, хөрс зөөлрөх явдал гарч, бага зэргийн салхи гадны шүргэлтэнд хазайж, унах явдал гарна.

Мод сөөг, зүлэгний ургалтанд байгалийн хур тундаснаас гадна нэмэлт усалгаа шаардлагатай. Мод сөөгийг тарьсны дараа 7 хоногт 3-4 удаа нэг том модонд 40-50 л, нэг сөөгөнд 20-30 л ус ногдохоор бодож усална. Мод сөөг тарьсан эхний жилүүдэд усалсны дараа үндэсний хүзүү орчмын хөрсийг нягтруулна.

Зүлэгт талбайг 7 хоногт 2-3 удаа бороожуулах маягаар усална. Хур бороо орсны дараа буюу 7 сараас хойшхи усалгааг цөөрүүлнэ. Усалгааг улирлын чанараар

нь хаврын усалгаа, зуны усалгаа, намрын цэнэг усалгаа гэж ангилдаг. Мод сөөгний титэмд хийх засал таналт нь хотын өнгө үзэмж, хүмүүсийн ажиллаж, амьдрах орчинд таатай нөлөө үзүүлэхүйц байх ёстой. Арчилгаа, тордлогооны хэлбэрээр хийж буй таналт нь титмийн доторхи өвчилсөн буюу гэмтэж муудсан, бие биеэ сүүдэрлэж буй мөчрийг зайлуулах уг мод сөөгний хэвийн ургах нөхцөлийг хангахад чиглэгдэнэ.

Мод сөөгөнд засал таналт хийхдээ мод ургамал тайван үед орсон үе буюу намрын навч унаж, нахиа зангидсан 10 дугаар сарын дунд үеэс дараа оны 4 дүгээр сарын дунд үе хүртэлх хугацаанд хийдэг. Модыг тайрч, танах арчилгаа нь титмийг хэлбэржүүлэх, залуужуулах болон цэвэрлэгээний гэсэн 3 чиглэлээр хийгдэх бөгөөд мөчир найлзуурыг хөнгөн ширвэх, сийрүүлэх тайралтыг эрчимтэй хийх аргуудаар хэрэгжүүлнэ.

#### 1.2.2.4 Зам тээвэр

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын төв Чойр хот нь аймгийн нутаг дэвсгэрийн төв хэсэгт Төвийн бүсийн босоо тэнхлэгийн дагуу аймгийн төв Улаанбаатар хотоос 240 км зайд оршино.

Улаанбаатар хотоос Чойр хот хүртэл босоо тэнхлэгийн улсын чанартай 240 км хатуу хучилттай замаар холбогддог. Олон улсын транзит төмөр замын сүлжээгээр холбогдсон тааламжтай нөхцөлтэй юм. Бусад багуудтайгаа Чойр хот сайжруулсан болон хөрсөн замаар холбогддог байна.

Төлөвлөлтийн хугацаанд Олон улсын чанартай авто зам тус хотын дундуур дайран өнгөрдөг тул тэндээс салбарласан хорооллын чанартай болон хорооллын доторхи замыг хатуу хучилттай болгохоор төлөвлөж байна

Одоо байгаа болон төлөвлөж буй авто замын схем

Шинээр төлөвлөж буй 9м өргөнтэй авто замын урт -9,8 км

Шинээр төлөвлөж буй 7м өргөнтэй авто замын урт – 60 км байна.

Хот орчмын болон хот доторх зам нь хатуу хучилттай замаар сүүлийн жилүүдэд хийгдсэн боловч гэр хороолол болон хот дотор төлөвлөгдөөгүй газраар авто машин дураар явсанаас хөрсний эвдрэл, агаарын бохирдол тоосжилт бий болгож байгаа нь байгаль болон хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Иймд хот орчмын бүст байрлах бүх объектуудыг 2030 оны түвшинд хатуу хучилттай замтай болгох шаардлагатай юм.

Одоо байгаа гэр хороололд шинээр 7м өргөнтэй авто замыг төлөвлөсөн байдал.

Шинээр төлөвлөж байгаа гэр хорооллын авто замын зай хэмжээ, өндөржилтыг ерөнхий төлөвлөгөөний зургаас үз.

Тус ерөнхий төлөвлөгөөнд:

- Хот гадна зам тээврийн сүлжээ;
- Хотын чанартай авто зам;
- Хорооллын чанартай авто зам;
- Хорооллын /гэр/ доторхи авто зам;
- Явган зам талбай гэсэн ангиллын дагуу төлөвлөлөө.

Хотын чанартай авто зам нь 9 м байхаар, Хорооллын доторх авто замыг 7 м өргөнтэй байхаар төлөвлөлөө. Хотын чанартай авто зам нь хорооллын бусад хэсгүүдтэй хамгаалалтын зурвасаар холбогдоно. Замын уулзварын хэсэгт 30 м дотор замын хөдөлгөөнийг хаахуйц мод ургамал болон архитектурын бусад жижиг элементийг байршуулахгүй юм.

Төмөр замын баруун талд үйлдвэрийн бүс газрын 61-р хэсэгт Аяганы гудамжинд өмчлүүлсэн .... га газрыг тус бүсээс өөр газарт шилжүүлэх нь зүйтэй. Мөн төмөр замын баруун талд байх бохирын нуурыг төвлөрсөн бохирын шугамтай холбох ажлыг хийх хэрэгтэй.

### **1.2.3. Хот, тосгон бусад суурины тэг гортигийн доторхи газрын ашиглалт, хамгаалалтын байдал**

Говьсүмбэр аймгийн хотын хүн амын цэвэр өсөлт болон хот бүрдүүлэгч боловсон хүчний коэффициент хүн амын амьдрал зүйг аль ч талаас нь авч үзэхэд хот сууринд байх дундаж суурин хүн ам 2030 он гэхэд 13198-д хүрэх тооцоо байна. 2016 онд дундаж суурин хүн ам 10141 байснаас 1.3 хувиар өсөх хандлагатай байна.

Чойр хотын одоогийн газар нутгийн хэмжээ 1865.54 га бөгөөд хот сууринд амьдрах хүн амын өсөлтөөс хамаараад 2030 онд 6467.02 га болж тэлэх хандлагатай байна.

Эдийн засгийн дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн, бизнесийн таатай орчинтой, амжиргааны өртөг харьцангуй давуу талд татагдаж говийн бүсийн аймгуудын иргэдийн шилжилт суурьшилтын төв нь Говьсүмбэр аймаг болж хүн амын механик өсөлт тасралтгүй нэмэгдэх хандлагатай байгаа юм.

Сүмбэр суманд одоогоор ашиглалтгүй байгаа хуучин материал техникийн хангамжийн газрын контор, агуулах, хашаа, ачаа татах салаа төмөр зам, Баянхайрхан

ХК-ны гараж, агуулах, Баянтал суманд байгаа онгоцны буудал, нэг нь 80х20 метрийн багтаамжтай 40 орчим төмөр агуулах ангоруудыг ашиглан бөөний худалдааны нэгдсэн сүлжээ байгуулах бүрэн бололцоотой. Энэ нь нэмэлт ажил хийхэд төсөв хөрөнгө зардал бага зарах магадлалтай.

*Инженерийн шугам сүлжээ:*

Чойр хотын цэвэр усан хангамж 7.5 км газраас 2 чиглэлээр хангагддаг ба төмөр замын тосгоны усан хангамж, шугам хоолой олон жил ашиглагдаж байгаагаас ашиглалтын шаардлага хангахгүй солих болсон. Чойр хотын усан хангамжийн шугам хоолойн 5 км-ийг сольсон ба үлдэж буй 2.5 км шугам хоолойн хөрөнгийн эх үүсвэргүйгээс сольж чадаагүй байгааг яралтай солих шаардлагатай. Мөн тус хот цэвэрлэх байгууламжгүйгээс бохир усаа төмөр замын баруун талд Чойр хотын өмнө зүгт байгальд илээр хаяж байгаа нь хүрээлэн буй орчин, хүн амын эрүүл мэндэд муугаар нөлөөлж байгааг харгалзан цэвэрлэх байгууламж барьж ашиглалтанд оруулсан нөхцөлд цэвэр усны нөөц нэмэгдэж боломжтой болно.

Усан хангамжийн хувьд усанд агуулагдах төмрийн хэмжээг багасгасан тохиолдолд үйлдвэрлэлийн болон ундны усны нөөцтэй болно.

#### **1.2.4. Хот орчмын бүсийн нутаг дэвсгэр**

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум 3 хөдөөгийн, 3 хотын баг 10 мянган хүн амтай. Голчлон газар тариалан эрхэлж байна. Хотын ойр орчим, сумын нутаг дэвсгэр нь рашаан ховор бүсэд хамрагддаг.

Одоо байгаа оршуулгын газарт хамгаалалтын бүсийг тогтоож, ойролцоохи газрыг цэцэрлэгжүүлэх шаардлагатай. Цаашид газар нутгийн багтаамж багатайг бодолцож, төлөвлөлтийн хугацаанд чандарлах үйлдвэрийг цэцэрлэгт хүрээлэнгийн хамт байгуулан, чандрыг хадгалдаг байхаар шийдэх нь зүйтэй.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын ард иргэд, мал аж ахуй, газар тариалан эрхэлж, амьдардаг хэдий ч хот улсын чанартай авто замын тэнхлэг дагуу оршиж байгааг харгалзан Зам дагасан суурьшил нь аялал жуулчлалын салбарын хөгжлийг тэтгэх менежментийг ажлуудыг хийх шаардлагатай юм.

#### **Хог хаягдлын менежмент:**

Зуны улиралд нэг өрхөөс өдөрт гарах хог хаягдал дунджаар 1.22кг, өвлийн улиралд өдөрт үүсэх хог хаягдал дунджаар 2.5 кг байна. Хог хаягдлын цэгт хоногт

дунджаар 32 тн хог ирж байгаагаас өвлийн улиралд нийт хогны 50 хувь нь үнс байна. Мөн дахин боловсруулах боломжтой хог хаягдал нийт ирж байгаа хогны 19.07 орчим хувийг эзэлж байна. Үйлдвэрлэл үйлчилгээний болон ахуйн хог хаягдлыг ялгах, дахин боловсруулах бага оврын үйлдвэр байгуулах хэрэгтэй.

### **1.2.5. Үйлдвэржилтийн бүс газрын төлөвлөлт**

**Барилгын материалын үйлдвэр байгуулах төлөвлөлт:** Говьсүмбэр аймагт Монгол орны ямар ч төв, суурин газарт үндсэн түүхий эд дүүргэгч материал болох элс, хайрганы олдоц, илрэл элбэг байдагтай холбоотойгоор бетон зуурмаг, бетон, төмөрбетон эдлэлийн үйлдвэр байгуулах боломжтой. Мөн чулууг бутлан ангилж, дайрга бүхий дүүргэгч бэлтгэх боломж байгаагийн зэрэгцээ аймаг орон нутагт бетон зуурмаг, бетон эдлэлийн хэрэгцээ эн тэргүүнд шаардлагатай болдог. Иймд Говьсүмбэр аймагт бетон болон шавардлагын бетон эдлэлийн жижиг үйлдвэрийг эхний ээлжинд жилд 15.0-20.0 мянган м<sup>3</sup> бетон эдлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтайгаар байгуулах боломжтой. Үүнээс гадна барилгын ханын материалын үйлдвэр хөгжүүлэн үнсэн дүүргэгчтэй хөнгөн блок, ердийн болон өнгөлгөөний тоосго үйлдвэрлэхийн зэрэгцээ зам талбайн хавтан, хашлага зэрэг эдлэхүүнийг элс, цементэн хольц найрлагаар үйлдвэрлэх боломжтой ба төвийн бүс болон зүүн бүсийн эрэлт хэрэгцээ, зах зээлд тулгуурлах асуудал нь үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн сонгож хэрэгжүүлэх ажил юм.

Өнгөлгөөний тоосго үйлдвэрлэхэд шаардагдах сайн чанарын түүхий эдийн нөөцтэй Улааннуурын шаврын орд нилээд судлагдаж, нөөц нь тогтоогдсон бөгөөд Сэртэн сүүж, Хавирган-Улаан зэрэг шаврын илэрц бий. Үүнээс гадна Шивээ-Овоогийн хөрс хуулалтын шаврыг керамзитын түүхий эдээр ашиглах өргөн боломж байна. Мөн Дорноговь аймгаас төмөр замаар гөлтгөнө татаж, гөлтгөнөөр төрөл бүрийн дүүжин тааз, гадна дотно өнгөлгөө бүхий барилгын чимэглэлийн жижиг үйлдвэрүүдийг байгуулж болно.

Иймээс Говьсүмбэр аймагт барилгын материалын үйлдвэрлэлийн салбарыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлж, бетон, олон шавардлагын зуурмаг, төмөрбетон эдлэл, ердийн болон өнгөлгөөний тоосгоны үйлдвэрийг цогцолбороор байгуулахаар төмөр зам, авто зам болон бусад шаардлагатай дэд бүтэц хөгжсөн, байршил сайтай газар болох хуучин Орос цэргийн ангийн зэвсгийн агуулах буюу ангар болон төмөр замын хуучин даланг ашиглан байгуулахаар төлөвлөж байна. Энэхүү барилгын

материал үйлдвэрлэлийн цогцолборыг Сүмбэр сумын 4-р багийн нутагт 30 га талбайд байгуулж, 9 км урт төмөр зам тавьж ашиглахаар тусгалаа.

Барилгын материал үйлдвэрлэлийн цогцолборын төрөл, түүхий эдийн нөөц

№	Үйлдвэрлэлийн төрөл	Түүхий эдийн нөөц	Хэрэгжих хугацаа /он/
1	Бетон зуурмаг, бетон, төмөрбетон эдлэлийн үйлдвэр	Сэртэн сүүж, Хавирган-Улаан зэрэг шаврын илэрц	2020-2022
2	Чулууг бутлан ангилж, дайрга бүхий дүүргэгч бэлтгэх үйлдвэр	Хэрээгийн хонхор	2019-2022
3	Үнсэн дүүргэгчтэй хөнгөн блок, ердийн болон өнгөлгөөний тоосгоны үйлдвэр	Улааннуурын шаврын орд	2021-2022
4	Зам талбайн хавтан, хашлаганы үйлдвэр		2019-2021
5	Дүүжин тааз, гадна дотно өнгөлгөө бүхий барилгын чимэглэлийн үйлдвэр	Дорноговь аймгаас төмөр замаар гөлтгөнө татах	2020-2022
6	Керамзитын үйлдвэр	Шивээ-Овоогийн хөрс хуулалтын шавар	2019

#### 1.2.6. Амралт, рашаан сувилал, аялал жуулчлалын төлөвлөлт

Говьсүмбэр аймагт жинхэнэ хуурай хээрийн ландшафт зонхилохын зэрэгцээ өмнө талаас нь говь, цөлөрхөг хээр түрэн оршсон нутаг юм. Ургамал, амьтны төрөл зүйлээр баян биш боловч түүх дурсгалын зүйлээр баялаг нутаг. Энэхүү өвөрмөц үзэсгэлэнт байгалийг үзэж сонирхох хүсэлтэй гадаад дотоодын амрагч аялагч жуулчид цөөнгүй ирэх бөгөөд ялангуяа Дорноговь аймгийн Хамрын хийд зэрэг үзэсгэлэнт газруудыг зорин очих жуулчдын дайран өнгөрдөг гол газар гэж үзэж болно.

Чойрын богд уул, Сүмбэр уул, Сансар уул, Зараагийн өврийн хүн чулуу, Цоорхойн рашаан, Чойрын хийдийн туурь зэрэг байгалийн түүх, соёлын дурсгалт газруудтай. Эдгээрийг түшиглэсэн жуулчны бааз одоогоор байгуулагдаагүй ба тус аймагт одоохондоо аялал жуулчлал төдийлөн сайн хөгжиж чадаагүй байна.

Тус аймагт аялал жуулчлал хөгжүүлэхэд дараах бэрхшээлүүд бий:

- Аялал жуулчлалын боловсон хүчний чадавхи хангалтгүй
- Жуулчдад тухайн орон нутгийн талаар бүхий л бодитой мэдээлэл өгөх үүрэгтэй мэдээлэл сурталчилгааны төв байхгүй
- Орон нутгийн аялал жуулчлалын үйлчилгээ, тохь тух хангалтгүй
- Жуулчны улирлын үргэлжлэх хугацаа богино (3 сараас хэтрэхгүй)

Гэхдээ одоо байгаа нөөц боломжиндоо тулгуурлаад аялал жуулчлал хөгжүүлэх боломжууд бас байна.

### **1. Төрөлжсөн аялал жуулчлал хөгжүүлэх боломж**

Тус аймагт аялал жуулчлалын олон төрлийн үйл ажиллагаа хөгжүүлэх боломжтой.

**Фото сафари буюу байгалийн гэрэл зураг авах аялал:** Байгаль, түүхийн өвөрмөц сонин тогтоц, үзэсгэлэнт хослол, ховор амьтан, ургамал, хүн байгалийн зохицол фото зураг сонирхогчдын анхаарлыг зүй ёсоор татдаг.

**Нүүдэлч малчдын соёлтой танилцах аялал:** жилийн дөрвөн улиралд нүүдэллэн амьдардаг нүүдэлч малчдын ахуй, зан заншил

**Байгаль, түүх сонирхогчдын аялал:** заримдаг цөл, хуурай хээр, элс манхан бүхий онгон байгалийн гоо үзэсгэлэн бүрдсэн зэлүүд орчинд аялж аргаль, зэрэг зэрэг дэлхийд ховордсон ан амьтан, шувууд, сонин зүйлийн ургамал, шавьж харах боломжтой. Мөн тус аймагт элбэг тохиолдох шашин шүтлэгийн объектууд, хадны зураг, буган чулуу, хүрэл зэвсгийн үеийн булш, чулуун хөшөө мэтийн түүх археологийн дурсгалт зүйлсийг сонирхож болно.

**Ердийн хөсгийн аялал:** Морь, тэмээн аялал зохион байгуулах боломжтой. Гадаад дотоодын жуулчдын ихээхэн сонирхдог аялал жуулчлалын нэгэн төрөл бол ердийн хөсгийн аялал юм. Нэн ялангуяа онгон зэлүүд тээврийн хэрэгслээр хүрэх боломжгүй газруудаар аялахад чухал үүрэгтэй. Нөгөө талаар үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалтай танилцахад ихээхэн боломж олгодог, цаашилбал хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлдэггүй зэрэг давуу талтай.

**Явган аялал:** Тус аймгийн хотгор гүдгэрт гадаргын налуу 3<sup>о</sup>-аас ихгүй тэгш тал зонхилж байгаа нь явган аялал хөгжүүлэхэд тохиромжтой болохыг харуулж байна. Явган аялалын нөөц, хүндрэлийн хувьд жилийн дөрвөн улирлаар нилээд ялгаатай. Өвөл хаврын улирал нь ширүүн хахир болдог учраас явган аялал хөгжүүлэхэд тохиромж муутай. Зун намрын улиралд тохиромжтой. Ийм үеийн үргэлжлэх хугацаа тус аймагт 3 сар үргэлжлэнэ.

Говьсүмбэр аймагт аялал жуулчлалын менежментийг сайжруулах, ядуурлыг бууруулах чиглэлээр нутгийн иргэдийн ахуй амьдралыг дээшлүүлэх, орлогын шинэ эх үүсвэр бий болгох зорилгоор жижиг хамтлагууд байгуулж гар урлалын зүйл хийж жуулчдад худалдах, жуулчдыг байрлуулах гэр ажиллуулах, жуулчдад үйлчлэх зэрэг үйлчилгээ явуулах боломжтой. Аялал жуулчлалын бизнес нь тухайн орон нутагт



хөрөнгө оруулах, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, танин мэдэхүй, харилцааны соёлыг дээшлүүлэхэд эерэгээр нөлөөлөх боловч зарим сөрөг үр дагавар авчирдаг. Үүнд: жуулчдын хоноглож, отоглосон газруудад хог хаягдал бөөгнөрөх; жижиг гол, горхи, булаг шандын ус бохирдох; эмзэг тогтоцтой газрын хөрс, бэлчээр эвдэрч талхлагдах; агнуураас болж ховор ан амьтдын сүргийн бүтэц тоо толгой өөрчлөгдөх; түлшний хомсдол бий болох, орон нутагт морь унаа, тээврийн хөлсний үнэ ханш өсөх зэрэг сөрөг үзэгдлүүд байгаа бөгөөд тэдгээрээс хамгаалах бүрэн боломжтой.

## 2. Аялал жуулчлалын бүсүүд

Говьсүмбэр аймагт аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой газрууд, хотгор гүдгэр, үзэх зүйлс, хүрэх боломж зэргийг харгалзан аялал жуулчлалын бүсийг ялган тогтоов.


Хүснэгт 58. Аялал жуулчлалын бүсүүд

№	Аялал жуулчлалын бүсийн нэр	Бүсийн хэмжээ /га/
I	Хөшөөтийн хүн чулуу	220
II	Чингэлийн хадны хиргисүүр	175
III	Хүрий ногоон	193
IV	Чойрын богд	1257
V	Шивээгийн нуур	220

Энэ бүсэд байгаль, түүхийн дурсгалт газрууд ойрхон оршино.

**Үзэх гол зүйлийн товч тайлбар.** Байгаль түүхийн дурсгалт газруудыг үзэхийн зэрэгцээ Чойрын богд уул, байгалийн өвөрмөц тогтоц бүхий боржин хад үзэхийн зэрэгцээ аргаль хонь, цагаан зээр зэрэг ховор амьтан ажиглах боломжтой.

Сүмбэр сумын 4-р багийн нутагт Хүрийн ногоон гэдэг газарт эмчилгээний шавар бүхий жижиг хэмжээний нуур байдаг ба энэ газрыг түшиглүүлэн эмчилгээний шавран сувиллын газар нээх нь зүйтэй юм.



### 1.2.7. Говьсүмбэр аймгийн нутгийн “Брэнд” бүтээгдэхүүн

Брэнд гэдэг нь хэрэглэгчийн ой тойнд үлдэх онцгой нэгэн санаа эсвэл зарчмыг хэлдэг. Брэнд үйлдвэрлэгчийн хувьд бүтээгдэхүүнийг таних, өрсөлдөгчдөөс нь ялгах нэр, лого, загвар, ямар нэгэн шинж чанар эсвэл эдгээрийн нийлбэр цогц юм. Хэрэглэгчийн хувьд өрсөлдөгч бүтээгдэхүүнээс тодорхой онцлог шинжээр ялгаран хэрэглэгчийн сэтгэлд хоногшиж чадсан бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг илэрхийлдэг.

Одоо байгаа брэндийн нэрийг ашиглан зах зээлд шинэ бүтээгдэхүүн гаргах боломжтой. Говьсүмбэр аймгийн брэнд бүтээгдэхүүн бол:

1. Сүмбэр үүлдрийн хонь
2. Шивээ-Овоогийн нүүрс юм. Энэхүү хоёр брэнд бүтээгдэхүүнийг ашиглан бэлэг дурсгалын зүйл бүтээж зах зээлд нэвтрүүлснээр брэнд мөнхөрөх болно.

Говьсүмбэр аймаг нь байгаль-түүх-дурсгал, ан амьтны өлгий нутаг бөгөөд ирээдүйд аялал жуулчлал өргөжин хөгжих хандлагатай байна. Иймээс гадаад, дотоодын аялагч, жуулчид болон ажил хэргийн зочдод зориулан нутгийн брэнд бүтээгдэхүүнийг сурталчилсан бэлэг дурсгалын зүйлс бүтээж борлуулах нь өрхийн үйлдвэрлэлийг дэмжсэн үйл ажиллагаа болох ба орон нутгийн төсөвт бага боловч хувь нэмэр оруулах нь тодорхой юм.

#### Сүмбэр үүлдрийн хонины арьсыг ашиглан бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх санаа:



**Шивээ-Овоогийн нүүрсийг ашиглан бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх санаа:**



**Брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нөөц, байршил**

Д/д	Брэнд бүтээгдэхүүний нэр	Бүтээгдэхүүний нийт нөөц	2016 онд бэлтгэсэн нөөц	Нөөцийн газарзүйн байршил
1	Сүмбэр үүлдрийн хонины арьс болон ноосон бэлэг дурсгал бүтээгдэхүүн	1595 толгой хонь	316 ширхэг арьс бэлтгэсэн	Сүмбэр сумын 6 дугаар баг
2	Шивээ-Овоогийн нүүрсэн бэлэг дурсгалын бүтээгдэхүүн	2708.7 сая тн нүүрс	45.1 тэр бум төгрөгийн нүүрс үйлдвэрлэсэн	Шивээговь сумын Шивээ-Овоогийн нүүрсний уурхай

**Зөвлөмж**

Тус аймагт барилгын үйлдвэрлэл явуулах, Говьсүмбэр, Дундговь аймгийн нутгийг дамжих орших Хараатын ураны хүдрийг ашиглах, олборлох, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн нүүрс химийн үйлдвэр байгуулж керолин, кокс, шингэн болон бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортлох бололцоотой юм.

Нефть хангамжийн хувьд Өмнөговь, Дундговь, Сүхбаатар, Хэнтий аймгуудыг шатахуунаар хангахад хүрэлцэхүйц шатах, тослох, материал агуулах тээвэрлэх боломжтой. Өвс тэжээл хадгалах өндөр хүчин чадал багтаамж бүхий улсын нөөцийн газар ажиллаж говийн аймгуудыг өвс тэжээлээр хангаж ирсэн.

### 6.3. ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

#### 6.3.1. Авто замын газрын төлөвлөлт

##### 6.3.1.1. Олон улсын чанартай авто замын төлөвлөлт:

2004 онд Засгийн газар хоорондын гэрээгээр Монгол улс Азийн авто замын сүлжээнд холбогдохоор тогтож 2013 оноос олон улсын азийн авто замын сүлжээ АНЗ- /Замын-Үүд-Сайншанд-Чойр-Налайх-Улаанбаатар-Дархан-Сүхбаатар-Алтанбулаг/ чиглэлийн зам барих ажлыг эхлүүлсэн билээ.

"Чингис Лэнд Девелопмент Групп – Шинэ Хөгжлийн Зам" ХХК Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 99, 399 дүгээр тогтоолын дагуу Эдийн Засгийн Хөгжлийн Яамтай "Алтанбулаг–Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны авто зам" төслийг хэрэгжүүлэх Концессын гэрээг 2014 оны 3 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан. Энэхүү мега төслийг Монгол Улсад анх удаа концессийн Барих-Ашиглах-Шилжүүлэх нөхцлөөр гэрээ байгуулсан байна.

Хурдны авто зам нь Монгол Улсын зургаан аймгийн 24 сум, Нийслэлийн 2 дүүргийн нутгийг дайран өнгөрөх бөгөөд нийтдээ 990 орчим км үргэлжлэх томоохон бүтээн байгуулалт болох юм.

Хурдны замын трассыг тогтоож трассын дагуу Алтанбулаг-УБ-Мааньт чиглэлийн 450 км газарт геотехникийн /геодези, инженер-геологи, гидрометеорологи/ суурь судалгаа, Алтанбулаг-Маньт чиглэлийн 450 км хэсгийн зам барилгын ажлын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг дуусгах, Мааньт–Замын-Үүд чиглэлийн 550 км хэсгийн геотехникийн суурь судалгааны ажлыг тус тус гүйцэтгэсэн байна.

##### Хүснэгт 59. Олон улсын АНЗ чиглэлийн авто замын төлөвлөлт

Хурдны замын нэр	Замын чиглэл	Нийт урт /км/	Говьсүмбэр аймаг дах замын чиглэл	Урт /км/	Хамгаалалтын зурвас /га/
АНЗ	Алтанбулаг-Сүхбаатар-Дархан-Улаанбаатар-Налайх-Чойр-Сайншанд-Замын-Үүд	1041	Налайх-Чойр-Сайншанд	73	1457

Олон улсын авто зам баригдсанаар орон нутгийн хөгжилд дараах нөлөөг үзүүлэх болно. Үүнд:

- Олон улсын авто зам дагуух орон нутагт худалдаа бизнесийн болон орлого нэмэгдүүлэх бусад үйл ажиллагааг өргөжүүлэх боломж бүрдэж зах зээлийн

боломж нэмэгдэнэ. Орон нутагт зорчих боломж дээшилж тээврийн зардал буурснаар хүнсний бараа орж ирэх урсгал нэмэгдэж хэрэглээний барааны үнэ буурна.

- Зам барих явцад бий болох ажлын байруудад орон нутгийн иргэдийг өргөнөөр хамруулж тэдний орлогыг нэмэгдүүлэхэд анхаарна. Зам барилгын ажлын явцад мэргэжилтэй болон мэргэжилгүй Монгол ажилчдыг авч ажиллуулах бөгөөд ажлын дадлага туршлага зэмшүүлэх сургалтуудыг зохион байгуулах юм. Зам ашиглалтанд орсны дараа түүгээр зорчигсдод үйлчлэх, замыг дагаж орж ирэх худалдаа, үйлдвэрлэлийн боломжийг ашиглах нөхцөл бүрдэнэ. Зам дагуух үйлчилгээний төвлөрсөн цэгүүд, ШТС, зочид буудал, ресторан, засварын цех, гар урлал болон бусад бүтээгдэхүүн худалдах дэлгүүр байгуулах замаар орлогоо нэмэгдүүлэх боломжтой.

- Говьсүмбэр аймаг нь хагас хуурай уур амьсгалтай, сийрэг ургамлын бүрхэвчтэй хээр тал юм. Замыг элс, цасны нүүдлээс хамгаалах үүднээс замын трассын 15%-д шинээр мод тарина. Энэ нь цөлжилтийг бууруулахад зохих нөлөө үзүүлнэ. Төслийн зам баригдсанаар олон салаа зам гаргаж, хөрсийг эвдэх явдал зогсоно.

#### 6.3.1.2. Улсын чанартай авто замын төлөвлөлт:

Монгол Улсын нийгэм-эдийн засгийн хөгжлийг түргэтгэх чухал хөшүүргийн нэг нь авто замын сүлжээг өргөтгөх асуудал бөгөөд аймгийн төвүүдийг хатуу хучилттай замаар холбож, аймаг орон нутаг хоорондын нийгэм, эдийн засгийн харилцааны таатай орчинг бүрдүүлэхээр Чойр-Мандалговийн чиглэлд шинээр баригдах улсын чанартай нийт 184 км авто замын Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэр дээгүүр дайран гарах 31 км замын чиглэлийг, Чойр-Өндөрхаан чиглэлд шинээр баригдах нийт 225 км авто замын 38 км замын чиглэлийг тус тус төлөвлөгөөнд тусгав.

#### *Хүснэгт 60. Шинээр баригдах улсын чанартай авто замын төлөвлөлт*

Авто замын чиглэл	Авто замын чиглэл. /холбогдох хот, суурин, ордууд, хатуу хучилттай замын нэр/	Замын ангилал, зориулалт	Хэрэгжих хугацаа	Замын урт /км/		Замын хамгаалалтын зурвасын хэмжээ /м/
				Нийт	Говьсүмбэр аймаг дахь замын урт	
Сүмбэр/Чойр/-Мандалговь	Сүмбэр/Чойр/-Шивээ-Овоо-Говь-Угтаал-Их газрын чулуу жуулчны бааз-Мандалговь	Аймаг хоорондын улсын чанартай зам	2020-2024	184	31	100
Сүмбэр/Чойр/-Өндөрхаан	Бор-Өндөр-Дархан-Баянмөнх-Өндөрхаан	Аймаг хоорондын улсын	2020-2024	225	54.7	100

		чанартай зам				
--	--	-----------------	--	--	--	--

\*Эх сурвалж. Авто зам тээврийн салбар 2018-2020 онд: Зам тээврийн хөгжлийн яам/

Хүснэгт 61. Төлөвлөсөн авто замын маршрутыг тохиромжтой байдлын үнэлгээтэй давхацуулан үнэлсэн байдал, авто замын зурвас газрын хэмжээ

Д/д	Аймгуудын нэр	Эхлэх- төгсөх /км/	Тохиромжтой байдлын үнэлгээ					
			Замын доорхи газар /га/			Зурвас газар /га/		
			Нэн хүнд - рэлтэй	Хүнд- рэлтэй	Хэвийн	Нэн хүнд- рэлтэй	Хүнд- рэлтэй	Хэвийн
1	Трассын нийт 338км-с 28км буюу 8.3% нь нэн хүндрэлтэй, 45км буюу 13.3% нь хүндрэлтэй, 265км буюу 78.4% нь хэвийн нөхцөлтэй							
32	Говьсүмбэр.Сүмбэр/Чойр/- Хэнтий.Өндөрхаан 2020- 2024	225			269.3		2245.1	
	Трассын нийт 225км зам нь 100% нь хэвийн нөхцөлтэй							
33	Говьсүмбэр.Сүмбэр/Чойр/- Дундговь.Мандалговь 2020-2024	0-82			98.8		824.1	
		82-92	11.5			96.1		
		92-135			51.8		432.3	
		135-165		35.4			295.4	
		165-184			22.4		187.5	


#### 6.3.1.3. Орон нутгийн чанартай авто замын төлөвлөлт:

Улсын чанартай А01 чиглэлийн авто замтай Баянтал сумын төвийг 2 км урт замаар, Шивээ-говь сумын төвийг 8 км урт замаар холбохоор төлөвлөлөө. Хүснэгт 71.

№	Сумын нэр	Замын урт /км/	Төсөв зардал	Хэрэгжүүлэх хугацаа
1	Баянтал	2		2019-2020
2	Шивээ-Говь	8		2018-2019
	Бүгд	10		

#### 6.3.1.4. Засварлах зам, гүүрийн төлөвлөлт:

Говьсүмбэр аймгийн төв нь Хэрлэн голоос 90 км зайд оршдог бөгөөд аймгийн хойд хилээр урсах Хэрлэн голын Хөмүүлтийн гүүр нь Сүмбэр сумын Малах багийн нутагт хамаардаг. Энэ нуур нь Хэнтий аймгийн Аварга тосонгийн сувиллын газарт хүрэх гол гарц болдог ба цаг хүндэрсэн үед өөр аймаг, сумын нутагт отор нүүдэл хийх, мах бэлтгэлийн малыг туухад энэ гүүрийг ашиглана гэж үзвэл гүүрийг сэргээн засварлах нь тус аймгийн ард иргэд, малчдад ихээхэн тустай зүйл болох нь дамжиггүй юм. Хөмүүлтийн гүүрийг сэргээн засварлахад нийт 10 сая төгрөгийн санхүүжилт шаардагдана.






**6.3.2. Аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдах авто замын төлөвлөлт:**

Аймгийн нутаг дэвсгэр дэхь байгаль, түүх дурсгал бүхий газрыг түшиглэн томоохон амралт сувилал, аялал жуулчны бааз байгуулж болохуйц байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай нь холбогдох байгууллагаар тогтоогдсон зам харилцаа, гэрэл цахилгаан, ундны усны эх үүсвэртэй хямд өртгөөр холбогдох боломжтой газрыг хамруулан аялал жуулчлалыг хөгжүүлэх бүс газрыг дараах 4 байршилд тогтоосон байна. Үүнд: **Хөшөөтийн хүн чулуу-Чингэлийн хадны хиргисүүр-Хүрий ногоон-Чойрын богд-Шивээгийн нуур**

Эдгээр аялал жуулчлалын бүсэд хүрэх маршрутыг аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/334 тоот захирамжаар тогтоожээ.

Бид энэ ажлынхаа хүрээнд аялал жуулчлалын маршрутыг газар зүйн мэдээллийн системийн Arc Gis програм ашиглан орон нутгийн зам дагуу зураглаж, уртын хэмжээг тооцоолж үзэхэд ойрын зайн маршрут 91 км, дундын зайн маршрут 144 км, холын зайн маршрут 180 км байна.




**6.3.3. Мал тууврын замын төлөвлөлт:** Говьсүмбэр аймгийн болон хил залгаа орших Дорноговь аймгийн мах бэлтгэлийн болон цаг хүндэрсэн үед бэлчээр ашиглах отор нүүдэл хийх мал тууврын замын зурвасыг тусгаж орууллаа. Нийт 207 км урттай мал тууврын зам Сүмбэр, Баянтал сумдын нутаг дэвсгэрээр дайран өнгөрч байна.

Хүснэгт 62. Мал тууврын замын чиглэл

№	Замын чиглэл	Урт /км /	Дайран өнгөрөх газрын нэр	Замын чиглэлд хамрагдаж байгаа объект			
				Худаг		Өвөлжөө, хаваржаа	
				ойр	хол	ойр	хол
1	Сүмбэр 4-р баг-Дундговь аймаг Баянжаргалан сум	63	4-р багийн Духан толгойн зүүн талаар зүүн хойшоо Холбоо нуурын зүүн талаар Хүрэн дух овооны баруун талаар хойшоо Хүрийн зооны баруун талаар хойшоо Төмөр замынхаа талаар Нүдэнгийн Бор гүвээ хүртэл	10		4	
2	Дорноговь Даланжаргалан сум-Шивээ-говь сум-Сүмбэр сум-Баянтал сум-Дундговь Баянжаргалан	67	Шивээ-говь сумын төмөр замын 22-зөрлөгийн баруун талаар баруун хойшоо Шивээгийн булагийн хажуугаар чигээрээ төмөр замын гарам-аар зүүн тийш гарна. Сүмбэр сумын зүүн талаар хойшоо Лүн уулын зүүн талаар Баянтал сумын хойд талаар 18-р зөрлөг хүртэл		8		10
3	Дорноговь Даланжаргалан сум-Сүмбэр сум-Баянтал сум-Төв Баян сум	77	Цайдам нуурын хойд талаас баруун тийшээ Сүүл өндөр уулын урд талаар баруун тийшээ Улаан эрэг толгой дайрч баруун хойшоо Тэрэгтийн хонхор, Цахиурын ухаа дайрч Шилийн ухаа зүүн талаар Мөгийн толгод хүртэл		5	4	20

Мал тууврын замын зурвас нь янз бүрийн шалтгаанаас өөрчлөгдөж байх нь зайлшгүй юм. Цаашид тууврын замыг аль болох богино байх, тууврын зам дагуух бэлчээр нь өвс ургамлаар сайн, худаг усаар хангалттай байх, өвөлжөө, хаваржааны орчмын бэлчээр нутгаас хол байх, хадлангийн талбайг дайрахгүй байх зарчмыг баримтлан тогтоож байх нь зүйтэй.



**6.3.4. Эрчим хүчний шугам, сүлжээний төлөвлөлт:**

Тус аймаг нь төвийн эрчим хүчний системд холбогдсон, аймгийн төвдөө Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан дамжуулах станц байрлаж үйл ажиллагаа явуулдаг бөгөөд цахилгаан хангамж сайтай аймаг юм.

Цаашид уг дамжуулах станцаас Багануур-Чойр, Чойр-Сайншанд, Чойр-Цагаансуварга, Чойр-Цайдамын чиглэл тус бүрт 220 квт-ын 2 хэлхээ нийт 167 км урт эрчим хүчний шугам тавихаар төлөвлөлөө.

Хүснэгт 63. Цахилгаан дамжуулах шугам, сүлжээний төлөвлөлт

№	Чиглэл	Хүчин чадал	Урт /км/	Хэрэгжих хугацаа
1	Чойр-Багануур	220квт	59	2018-2020
2	Чойр-Сайншанд	220квт	33	2019-2022
3	Чойр-Цагаансуварга	220квт	43	2019-2024
4	Чойр-Цайдам	220квт	48	2018-2021

Мөн цаашид дотоодын буюу иргэн, аж ахуй нэгж хоорондын шугам сүлжээний төлөвлөлт хийгдэнэ. Энэхүү төлөвлөлт нь хотын ерөнхий хөгжил, чигийг харсан байх ба болж өгвөл өндөр хүчин чадалтай шугамыг газар доогуур аюул осол багатайгаар байршуулахаар хот байгуулалтын хэсэгчилсэн төлөвлөгөөнд тусгах хэрэгтэй.

**6.3.5. Төмөр замын төлөвлөлт:**

Говьсүмбэр аймагт бетон, олон шавардлагын зуурмаг, төмөрбетон эдлэл, ердийн болон өнгөлгөөний тоосго, дүүжин тааз, гадна дотно өнгөлгөө бүхий барилгын чимэглэл зэрэг барилгын материал үйлдвэрлэлийн цогцолборыг Сүмбэр сумын 4-р багийн нутагт хуучин Орос цэргийн ангийн зэвсгийн агуулах буюу ангарыг ашиглан байгуулж, төмөр замын хуучин даланг ашиглан 9 км урт төмөр зам тавьж Улаанбаатар-Замын Үүд чиглэлийн төмөр замтай холбохоор тусгасан болно.

**Зөвлөмж**

Суурьшлын бүсэд дэвсгэр зураг, ерөнхий төлөвлөгөө хийлгэх, улаан шугам тавих, инженерийн болон нийгмийн дэд бүтэц бий болгох хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж, улсын төвлөрсөн төсөв, орон нутгийн төсөвт бие даасан байдлаар тусгуулах ажлыг зохион байгуулан хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

#### 6.4. УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

Говьсүмбэр аймаг нь усан хангамжын хувьд хангалттай биш ба аймгийн хэмжээнд цөөн тооны булаг, шанд, гол горхи нь ундрага багатай.

Ус зүйн сүлжээний хувьд аймгийн нутаг дэвсгэрийн багахан хэсэг нь (нутгийн зүүн хойно Хэрлэн голын сав) номхон далайн ай савд үлдсэн хэсэг нь төв азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг.

##### 6.5.1. Гадаргын усны хамгаалалт, ашиглалтын төлөвлөлт

###### Гол, горхи:

Аймгийн хэмжээнд тал хээрийн бүсэд хамаарагдах ба жилийн турш байнга устай байдаг тоотой хэдэн нуураас өөр гадаргын усны сүлжээ байхгүй юм. Хаврын шар ус, зуны борооны үеэр түр зуурын урсгал ус үүсч улмаар ширгэж алга болдог байна. Иймд аймгийн ихэнх нутгийн хэмжээнд түр зуурын урсгал усны гольдролууд ялгагдана. Байнгын урсгалтай гол горхи, нуур талбайн болон орчны хэмжээнд гадаргуугийн усан сүлжээгүй, зөвхөн ухаа гүвээт талын хонхор, хотгоруудад ширгэдэг. Жижиг нуур, тогтоол ус /тойром/ тохиолддог. Иймээс Сүмбэр сумын 5-р багийн нутаг дах Уулзварын гол, Хүхээгийн гол, Хулгарын гол, Өгөөмөрийн гол, 4-р багийн нутаг дах Гашууны голуудаас тус бүр хоёр тийш онцгой хамгаалалтын бүсийг 50 метрт татаж, уг зурвас дотор аливаа ашиглалтыг хязгаарлаж, өвөлжөө бууц барихгүй байх зэрэг арга хэмжээ авах хэрэгтэй. Мөн Уулзварын голын эх авдаг Асгана булгийн ундаргыг малын хөлд дарагдахаас урьдчилан сэргийлж хашаа, хайс барьж хамгаалах арга хэмжээ авах нь зүйтэй байна.

##### Хүснэгт 64. Голын хамгаалалт, ашиглалтын төлөвлөлт


№	Голын нэр	Төлөвлөсөн арга хэмжээ	Зурвас газрын хэмжээ	Нийт эзлэх талбай	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Зарцуулах хөрөнгийн хэмжээ /сая төг/
<b>Сүмбэр сум</b>							
1	Уулзварын гол	Голын хамгаалалтын зурвас татах	50		Хамгаалалтын зурвас дотор өвөлжөө, бууц олгохгүй байх,	2018-2022	-
2	Хүхээгийн гол	Голын хамгаалалтын зурвас татах	50		Хамгаалалтын зурвас дотор өвөлжөө, бууц олгохгүй байх,	2018-2022	-
3	Хулгарын гол	Голын хамгаалалтын зурвас татах,	50		Хамгаалалтын зурвас дотор өвөлжөө, бууц	2018-2022	-

		ус тогтоох тавцан барих			олгохгүй байх	2019-2020	2.0
4	Гашууны гол	Голын хамгаалалтын зурвас татах,	50		Хамгаалалтын зурвас дотор өвөлжөө, бууц олгохгүй байх	2018-2022	-
		ус тогтоох тавцан барих				2021-2022	2.0
5	Өгөөмөрийн гол	Голын хамгаалалтын зурвас татах,	50		Хамгаалалтын зурвас дотор өвөлжөө, бууц олгохгүй байх	2018-2022	-
		ус тогтоох тавцан барих				2020-2022	2.0

Хулгарын гол, Гашууны гол, Өгөөмөрийн голууд хэдийгээр ширгэсэн боловч хур тунадасны усаар тэжээгдэж сэргэдэг байна. Голын хуурай сайраар ус богино хугацаанд урсан өнгөрөх, доош шингэж алга болох, уурших зэргээс урьдчилан сэргийлж аль болох удаан хугацаагаар усаа барих зорилгоор ус тогтоох тавцанг голын хуурай сайр дотор гаргаж бага боловч ус тогтоовол мал усалгаанд ихээхэн ач тустай арга хэмжээ болох юм.

Доорх бүдүүвч зурагт хаврын шар ус, хур тунадасны усаар тэжээгддэг голын дэргэд ус тогтоох тавцан буюу даланг барьж бэлчээрийг усжуулахаар тусгасан байна. Харин энэ аргыг ашиглаад голын хуурай сайр дотор ус тогтоох тавцан барьж болох юм. Учир нь Говьсүмбэр аймаг нь хуурайшилт ихтэй, хур тунадасны хэмжээ харьцангуй бага тул тэрхүү байгалийн үзэгдлийг үр дүнтэй ашиглах үүднээс энэхүү арга тохиромжтой гэж үзлээ. Уг тавцангийн суурийг усыг доош нэвчүүлдэггүй материалаар хийх нь зүйтэй.

Ус тогтоох тавцангийн бүдүүвч



**6.5.2. Булаг, шанд:**

Сүмбэр сумын 5-р багийн Асгана булаг, Шивээговь сумын 2-р багийн Бэхтийн булаг, Нэртийн булгийн эхийг хамгаалсан хашааг засварлахад нийт 1.5 орчим сая төгрөг, Сүмбэр сумын 5-р багийн Ар хажуу булаг, Тагт булаг, 4-р багийн Ар хөндлөнгийн булаг, Шивээговь сумын 2-р багийн Тогоогийн булаг, Мөнхтийн булаг, Хөтөлийн булгийн эхийг хашиж хамгаалахад нийт 10 сая орчим төгрөг шаардагдана.

**Хүснэгт 65. Булаг, шандын хамгаалалт, ашиглалтын төлөвлөлт**

№	Булаг, шандын нэр	Төлөвлөсөн арга хэмжээ	Зурвас газрын хэмжээ	Нийт эзлэх талбай	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Зарцуулах хөрөнгийн хэмжээ /сая төг/
<b>Сүмбэр сум</b>							
1	Асгана булаг	Хашааг засварлах	50		Булгын эх орчмыг малын хөлөөс хамгаалах	2019	0,5
		хамгаалалтын зурвас татах				2018-2030	-
2	Ар хажуугийн булаг	Хашиж хамгаалах	50		Булгын эх орчмыг малын хөлөөс хамгаалах	2019	1,5
		Хамгаалалтын зурвас татах				2018-2030	-
3	Тагтын булаг	Хашиж хамгаалах			Булгын эх орчмыг малын хөлөөс хамгаалах	2020	1,5
		Хамгаалалтын зурвас татах				2018-2030	
4	Ар хөндлөнгийн булаг	Хашиж хамгаалах			Булгын эх орчмыг малын хөлөөс хамгаалах	2020	1,5
		Хамгаалалтын зурвас татах				2018-2030	
	<b>БҮГД</b>						<b>5,0</b>

Гол, булаг, шандын хамгаалалт, ашиглалтын төлөвлөгөөг боловсруулахдаа Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулдаг Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны усны тооллого, бүртгэл судалгааг үндэслэн эх сурвалж болгон ашиглалаа.

**6.5.3. Нуур:**

Шивээ-Овоогийн уурхайн шүүрүүлгийн уснаас бий болсон Шивээгийн булгийн нуур нь хүний гараар бүтсэн үзэсгэлэнт газрын нэг болж аймгийн төдийгүй гадаад, дотоодын жуулчдын амарч зугаалах аятай нөхцөлийг бүрдүүлсэн газар болжээ. Мөн нуураас суваг шуудуу татаж усалгаатай газар тариалан эрхэлж, төмс, хүсний ногоо



тарьж ургуулж байна. Шивээгийн булгийн нууранд бух, сугас загас үржиж байгаа бөгөөд спорт загас агнуурыг хөгжүүлэх боломжтой юм.

Уурхай жилд 4 сая шоо метр усыг газрын гүнээс татаж төмөр хоолойгоор нууранд цутгаж байна. Газрын гадарга усны элэгдэлд нилээд их орж, ганга жалга үүссэн байдалтай байна. Нуурыг зорин ирж буй амрагч, аялагчдын аюулгүй байдал болон газрын гадаргын элэгдлийг тэлэхгүй байх үүднээс жалгаар ус урсах ёроол хэсгийг бетоноор доторлож, цаашид усанд идэгдэж гүнзгийрэхээс хамгаалах, жалгын эргийн нуралтаас урьдчилэн сэргийлэх арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.



Цаашид нүүрсний 1, 2-р давхаргын шургах чигт усжилт нэмэгдэх гидрологийн нөхцөлтэй. Иймээс нуурын орчимд ёроолын болон эрэг хавийн шингэлт, ууршлын ажиглалтыг зохих журмын дагуу хийх нь шүүрлийн бүсэд хиймэл нуур тогтмол тэжээлтэй хил үүсгэдэг эсэхийг үнэлэх боломжтой болно. Нуурын эзлэх талбай нэмэгдэж ойр орчмын тариалангийн талбайд хүрэх магадлалтай байна. Иймээс нуурын усны горимыг тохируулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгтэй.

## 6.5. УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

### 6.5.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөгөө

Улс орны хөгжлийг даган газарт ирэх ачаалал байнга нэмэгдэж байдаг бөгөөд хотжилт үйлдвэржилт эрчимтэй хөгжсөн сүүлийн 80 гаруй жилийн хугацаанд нутаг дэвсгэрийн нилээд хэсэг нь унаган төрхөө алдаж, зарим хэсэг нь ашиглалтаас хасагдаж байгаа сөрөг үзэгдэл ажиглагдах боллоо.

Газар нутгийг тусгай хамгаалалтад авахдаа тухайн газар нутгийн экологийн онцлог, өвөрмөц тогтоц үзэсгэлэнт байдал, унаган төрхөө хадгалсан байдал, биологийн төрөл зүйлийг хамгаалах шаардлага, түүх соёл шинжлэх ухааны ач холбогдол зэргийг нь харгалзан үзэх зарчмыг баримталдаг.

Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг 2016 оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн .... хувьд хүргэсэн бол, 2030 он гэхэд ..... хувьд хүргэх зорилттой байна.

#### 6.6.1.1. Улсын тусгай хамгаалалтад авах газар нутгийн хэтийн төлөв:

Одоо манай улсад нийтдээ 30 нөөц газар байгаа нь нийт тусгай хамгаалалттай газар нутгийн 10,8 хувийг эзэлж байна. Эдгээрийн 1 нь Говьсүмбэр аймагт байна.


Тал хээрийн бүсэд ховорхон тохиох, хоорондоо нам хөтлөөр холбогдсон 2 салангид уулсаас бүрдэх өвөрмөц тогтоц бүхий Чойрын Богд хэмээх энэ ууланд манай орны түүх, соёлын ихээхэн дурсгал хадгалагдаж байдгийн зэрэгцээ 1990 оноос 120 аргаль угалз нутагшсан билээ. Чойрын Богд ууланд Монголын шашны том төв байсан зүүн Чойрын хийдийн туурь, суварга, хадан дээр сийлэгдсэн Цагаан дарь эх, Дагвасүндэл бурхадууд, мөргөл хад, Цагаан суваргын туурь, Чандмань илдийн зурагт хаднууд зэрэг түүх, соёлын үнэт дурсгалууд их бий.

Цаашид Говьсүмбэр аймгийн улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх зорилгоор тусгай хамгаалалттай газар нутгийн экологийн бүс нутгийн үнэлгээг үндэслэн дараах газруудыг нэмж хамгаалалтад авах шаардлагатай.

#### Хүснэгт 67. Тусгай хамгаалалтад авах шаардлагатай газрын төлөвлөлт

№	Талбайн нэр	Аймаг	Сум	Талбайн хэмжээ (км <sup>2</sup> )	Периметр (км)	Үе шат
1	Дуулга уул	Хэнтий, Дорноговь, Говьсүмбэр	Дархан, Даланжаргалан, Иххэт, Айраг, Сүмбэр	3115.5	372.1	III үе шат 2026-2030
2	Ов Товын	Хэнтий,	Дархан, Сүмбэр	1120.7	187.8	III үе

	тал	Говьсүмбэр				шат 2026- 2030
3	Улигтийн ухаа	Дундговь, Говьсүмбэр	Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Шивээговь, Сүмбэр	2425	218.9	III үе шат 2026- 2030



**6.6.1.2. Орон нутгийн тусгай хамгаалалтад авах газрын хэтийн төлөв:**

Говьсүмбэр аймгийн хувьд тусгай хамгаалалттай газар нутаг цөөнтэй, орон нутаг хэд хэдэн газрыг хамгаалалтад аваад байгаа юм. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэх, Тусгай хамгаалалттай газар нутгийг сонгох шалгуурыг үндэслэн зохистой сүлжээ бүрдүүлэхийн тулд хамгаалалттай хийгээд хамгаалах газруудыг зохих системд оруулан дүн шинжилгээ хийх ажлууд хийгдсээр байна. Үүний дотор төрөл зүйлийн хувьд өргөтгөх, зарим нэг ач холбогдол бүхий орон нутгийн хамгаалалттай газрын ангиллыг дээшлүүлэх үүднээс Говьсүмбэр аймгаас байгаль түүхийн дурсгал бүхий одоо орон нутгийн хамгаалалтад байгаа Хөшөөтийн хүн чулуу, Чингэлийн хадны хиргисүүр, Хүрийн ногоон зэрэг газруудыг өргөтгөх, нэгтгэн Байгалийн дурсгалт газрын ангилалд оруулах боломжтой.

Хүснэгт 68. Шинээр авах газрын төлөвлөлт

Орон нутгийн хамгаалалтад авах газрууд	Хамгаалах зүйл	Байрлал	Талбайн хэмжээ /га/	Хэрэгжүүлэх хугацаа
Агаарын хүчний дайчдын оршуулгын газар	Түүхийн дурсгал	Аймгийн хойд хэсэгт		2018-2019
Цоорхойн рашаан	Эмчилгээ сувилгааны шавар	Сүмбэр сумын 5-р баг	354	2020-2022

Хүснэгт 69. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын ангилал шилжүүлэх төлөвлөлт


Газрын нэр	Өргөтгөх талбайн хэмжээ /га/	Хамрагдах ангилал	Хэрэгжүүлэх хугацаа
Хөшөөтийн хүн чулуу	399.69	Байгалийн дурсгалт газар	2019-2021
Чингэлийн хадны хиргисүүр	5107.02		2019-2021
Хүрийн ногоон	123.9		2019-2021

**6.5.2. Аймаг дундын отрын нөөц нутгийн хэтийн төлөв:**

Малах талын бэлчээрийг Засгийн газрын 2007 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 187 тоот тогтоолоор аймаг дундын отрын нөөц нутгийн зориулалтаар тусгай хэрэгцээнд авсан байна. Уг отрын нөөц нутаг нь Сүмбэр сумын 6-р багт харьяалагдах бөгөөд 73100 га талбайтай. Одоогийн байдлаар нутгийн малчдаас гадна хил залгаа аймаг, сумдын малчид отор нүүдэл хийн нутагладаг ба зохион байгуулалттайгаар албан ёсоор отор нүүдэл хийгдээгүй байна. Малчид хаяа багтахаараа бууж, хамар

багтахаараа иднэ гэдгээр даацыг хэтрүүлж, бэлчээр сулаас хүчтэй талхагдалд орсон байна.


### Хүснэгт 70. Отрын нөөц нутгийн бэлчээрийн даац



Отрын нөөц нутаг	Талбайн хэмжээ	1 га ургацын хэмжээ цн/га	Бэлчээрийн нөөц цн/га	1 хонины жилд идэх өвсний хэмжээ /цн	Бэлчээрийн даац хонин тол	Бэлчээрт байгаа малын тоо	Бэлчээрийн даац хэтэрсэн эсэх
Засгийн газрын тогтоолын талбай	73100	4.46	326026.0	5.6	58219	23448	+34771
Arc gis програмаар бодуулсан талбай	64636.0	1.4	90490.4	5.6	16159	23448	1.5
Говьсүмбэр аймаг дах отрын бүс нутгийн талбай	45038	1.4	63053,2	5.6	11260	23448	2.1
Өвөл-хаврын бэлчээр	26810.0	0.8	21448.0	5.6	3830	23448	6.1
Зун-намрын бэлчээр	18228	1.2	21873.6	5.6	3906	23448	6.0


Малах отрын нөөц нутгийг тусгай хэрэгцээнд авсан Засгийн газрын тогтоолд талбайн хэмжээг 73100 га гэж байгаа боловч тогтоолын хавсралтад дурьдсан хилийн заагийн солбицолыг газарзүйн мэдээллийн системийн ARC GIS програмд оруулж талбайн хэмжээг бодуулахад нийт 64636 га талбайтай гэж гарч байна. Үүнээс Говьсүмбэр аймагт 45038 га нь хамаарагддаг бөгөөд бэлчээрийн даац 2.1 хувиар хэтэрсэн байна. Отрын нөөц нутгийн улирлын даацыг тооцоолж үзэхэд өвөл-хаврын бэлчээр 26810 га ба даац 6.1 дахин, зун-намрын бэлчээр 18228 га ба даац 6 дахин хэтэрсэн байна.

Малах отрын бүс нутгийн Говьсүмбэр аймаг дах талбайгаас нийт 22592 га нь хүчтэй талхагдсан, 5173 га нь сул талхагдалд орсон байна. Иймээс сул талхагдсан бэлчээрийг улирал, сараар сэлгэн ашиглах, түүнчлэн хүчтэй талхагдсан бэлчээрийг ашиглалтаас хэсэг хугацааны турш бүрэн чөлөөлөх шаардлагатай байна. Дараах хүснэгтэд отрын бэлчээрийг хамгаалах төлөвлөгөөг харуулав.



Хүснэгт 71. Отрын нөөц нутгийн бэлчээрийг хамгаалах, ашиглах төлөвлөгөө

Талхагдлын зэрэглэл	Талбайн хэмжээ /га/	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа /он/
Дунд	5174	Жилээр сэлгэх	2018-2025
Хүчтэй	22500	Өнжөөх, чөлөөлөх	2018-2028



Отрын бүс нутгийн 5174 га жилээр сэлгэх бэлчээрт энгийн хуваарьтай ашиглалтыг нэвтрүүлж, бэлчээрээ 5-7 хэсэгт хувааж шон, чулуун овоо босгох, байгалийн таних тэмдгийг ашиглан ээлжлэн ашиглах, байнгын хариулгаар малаа бэлчээрлүүлэх. Бутлалтын болон үр боловсрох бэлчээрийг аль болох чөлөөлөх зорилгоор 2 талбайт сэлгээг нэвтрүүлэх шаардлагатай. Бэлчээр хүрэлцээтэй нөхцөлд 1 зуны турш ашиглалтаас чөлөөлөх нь үр дүнтэй

Мөн 22500 га өнжөөж амрах бэлчээрт 3 жил дараалан ургалтын хугацаанд ашиглалтаас чөлөөлөх. Ачааллыг боломжит даацаас 15 хувиар багаар тооцон 2 жил дараалан ургамал ургалтын хугацаанд ашиглах. Ахин 3 жилээр ургалтын хугацаанд ашиглалтаас чөлөөлөх. Малын тоог боломжит даацаас 15 хувиар багаар тооцон ахин 2 жил дараалан ургамал ургалтын хугацаанд ашиглах. Дэрсний хөгширсөн том бутыг шатааж нялхруулах бөгөөд энэ тохиолдолд зуны турш ашиглалтаас бүрэн чөлөөлөх. 1 га-д 60-аас илүү байхаар тооцож бууцаар бордоно.

Тус отрын бэлчээрт эртнээс нутаглаж ирсэн уугуул малчид өвөлжөө, бууц эзэмшиж чадахгүй хэл үг, маргаан хийдэг ба отрын нөөц нутгаас гаргах саналыг байнга гаргадаг байна.



Отрын бэлчээрийн даац 2-6 дахин хэтэрсэн, нийт талбайн 50 хувь нь хүчтэй талхагдалд орсон, нутгийн уугуул малчдын тусгай хэрэгцээнээс гаргах хүсэлт зэрэг шалтгааны улмаас Малах отрын нөөц нутгийг улсын тусгай хэрэгцээний газраас гаргах саналыг дэмжиж төлөвлөгөөнд тусгалаа.

Отрын нөөц нутгаас гаргахын тулд малчид өөр хоорондоо нэгдэн саналаа Багийн иргэдийн нийтийн хуралд гаргаж хэлэлцүүлэх хэрэгтэй. Тусгай хэрэгцээнээс отрын нөөц нутгийг гаргах саналд уг газрыг тусгай хэрэгцээнд авсан зориулалт болон улсын тусгай хэрэгцээнээс гаргах болсон зайлшгүй шаардлагыг тодорхойлсон танилцуулга, хил зааг, талбайн хэмжээ, бусад мэдээллийг тусгасан зохих масштабын газрын зургийг хавсаргана.

Багийн иргэдийн нийтийн хурлаас гарсан шийдвэрийг сумын ИТХ-аар хэлэлцэн шийдвэрлэж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлээд эцсийн шийдвэрийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

### **Зөвлөмж, дүгнэлт**

Биологийн төрөл зүйлийг байгалийн нөхцөлд хэвийн өсөж үржих нөхцлийг бүрдүүлэх

Түүх соёлын дурсгалт газруудын хамгаалалтыг сайжруулах

Оролцоог хангасан удирдлага, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох

Санхүүгийн тогтвортой эх үүсвэрийг бий болгох

Нутгийн иргэдэд түшиглэсэн, байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт, хамгаалалттай холбоотой санал, санаачлагыг дэмжих

БНГ-ын үнэлэмжийг дээшлүүлэх, төрөлжсөн аялал жуулчлалыг хөгжүүлэх

Олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх

Говьсүмбэр аймгийн нутагт МЭӨ XIII зууны үеийн булш, хэргэсүүр зэрэг түүх, археологийн олдворууд элбэг. Цаашид судлах шаардлагатай олон дурсгалт газрууд байна.

Монголд ирж буй гадаадын жуулчдын дийлэнх нь манай орны үзэсгэлэнт байгальтай ТХГН-уудаар аялдаг бөгөөд Чойрын Богдын БНГ-т ирдэг жуулчдын тоог гаргасан судалгаа өнөө хир байхгүй байна.

Цоорхойн рашаан нь ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд орсон тул тусгай зөвшөөрлийн талбайгаас гаргах ажлыг зохион байгуулсаны дараа орон нутгийн тусгай хамгаалалтад авах нь зүйтэй.

#### **Долдугаар бүлэг. БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР**

Мал аж ахуйн нөлөөлөл: Хуурайшилтын улмаас нуур, булаг шандын нугархаг бэлчээрт мал сүргийн нягтшил ихсэж ус намгархаг орчинг ихээр доройтуулдаг. Ялангуяа хуурай жил мал нуурын зэгсрүү орж бэлчих, нуурын эргээр өдрийн халууныг өнгөрөөх тул ус намгийн шувууд хэвийн үржих, үүрлэх нөхцөлийг бууруулдаг. Түүнчлэн бэлчээр муутай гантай зуны дараа Чойрын Богд уулруу малчид орж өвөлждөг нь туруутан амьтдын бэлчээрт сөрөг нөлөө үзүүлдэг байна.

Хот, суурин, уул уурхайн нөлөөлөл: Говьсүмбэр аймаг нь Монгол улсын бусад аймгуудтай харьцуулахад газар нутаг бага хүн амын суурьшилт нягтшил ихтэй. Хүн амын суурьшилтаас гадна ачаа тээврийн гол зам дагуу оршдог, уул уурхайн үйлдвэрлэлтэй тул хүний үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл ихтэй. Тухайлбал Чойрын Богд уулын улсын ТХГН-ийн зэрлэг ан амьтад нь Чойр хотоос шулуунаар 25 км, Шивээ Овоо сумаас 17 км, Даланжаргалан сумын нүүрсний уурхайгаас 16 км зайд оршиж байгаа тул хулгайн агнуурт өртөх аюул их байна. Хулгайгаар тарвага буудах, зээр мотоцикл, машинаар бахардуулж хөөх, хавх тавих зэрэг хулгайн агнуур нилээдгүй гардаг байна.

Байгаль хамгаалах, байгальдаа ойр байх, байгалийн танин мэдэхүй нь бидний хувьд чухал ач холбогдолтой. Гэвч зэрлэг ан амьтад, шувуудын байршилт, хэвийн амьдралыг алдагдуулахгүйгээр байгаль дахь арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

Авто болон төмөр замын нөлөөлөл: Зэрлэг туруутан амьтдын популяцид сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйл бол УБ-Замын үүд чиглэлийн төмөр зам, шинээр ашиглалтанд орсон хатуу хучилттай автозам юм. Цагаан зээр нь улирлын нүүдэлтэй амьтан юм. Улаанбаатар Бээжингийн чиглэлийн галт тэрэгний замын давхар хашлага нь Монгол орны зүүн хэсгийн цагаан зээрийн популяцийг 2 хуваасан гэж судлаачид дүгнэдэг. Учир нь энэхүү төмөр зам дагуу зэрлэг туруутан нэвтрэх том хэмжээний нүхэн гарц байхгүй. Мал сүрэг, томоохон туруутан амьтад төмөр зам гарах үед тээвэрлэлтийн аюулгүй байдалд хүндрэл учирдаг. Иймээс аюулгүй байдлыг хангах үүднээс төмөр замын дагуу 2 талаар нь торон хаалт, хашлага хийдэг бөгөөд энэ нь орчны бүсийн зэрлэг туурайтан, туруутан амьтдын шилжилт хөдөлгөөнд саад болох

сөрөг үр дагавартай. Нөгөө талаар энэхүү хашлага нь мал амьтан галт тэргэнд дайруулхаас сэргийлдэг. Улаанбаатар, Замын үүдийн чиглэлийн төмөр зам өргөстэй тороор хийгдсэн хашлага хаалттай бөгөөд цагаан зээр зэрэг нүүдлийн туруутан хашаан доторх өвсийг идэх гэж ороод торонд орооцолдож үхдэг байна.

Төмөр замын нүхэн гарц нь жижиг хэмжээтэй, нам, үзэгдэх орчин бага тул туруутан амьтад нь төмөр замыг хөндлөн гарч чаддаггүй байна. Хатуу хучилттай авто зам нь амьтад тодорхой хэмжээгээр сөгөг нөлөө үзүүлдэг. Орон нутаг хоорондох хатуу хучилттай автозам дээр авто машинууд 100км/цаг дээш хурдтай давхих болсоноор зээрийн сүрэг зам хөндлөн гарахад аюултай болж дайрагдах, эсвэл машины чөлөө хүлээн зам дагуу зогсож байдаг.

Говьсүмбэр аймгийн нутагт судалгаа хийсэн хугацаанд автозам дээр шилийн сар, дагуур зараа, шивэр алагдаага, хярс, цагаан зээр, олон тооны бор шувууд машинд дайрагдаж үхсэн байгааг баримтжуулсан.

#### Бэлчээрийн зөв менежментийг хэрэгжүүлэх замаар биологийн төрөл зүйлийг хамгаалах

Иймд бэлчээрийн менежментийг сайжруулах нь байгаль орчин, зэрлэг амьтдыг хамгаалах чухал арга хэмжээ юм. Уур амьсгалын өөрчлөлтийг бэлчээр ашиглалтын менежментэд зайлшгүй тусгах шаардлагатай.

Аймгийн нутаг дэвсгэр дэхь зэрлэг амьтдын ундаалах боломжтой бүх уст цэгүүдэд малчид нутаглаж, мал сүрэг зэрлэг туруутан амьтдын бэлчээр ус давхцсан байна. Иймд нөхцөлд зэрлэг ан амьтдын популяцийг хамгаалах, өсгөж үржүүлэх боломж хязгаарлагдах юм. Зэрлэг ан амьтдыг хамгаалахын тулд аймгийн бэлчээр ашиглалтын менежментэд дараах арга хэмжээг тусгах хэрэгтэй гэж үзэв. Эдгээр нь:

1. Чойрын Богд уулын ТХГН-ийн хилийн бүс дотор мал сүрэг өвөлжиж байгааг зогсоох, энэхүү ТХГН-ийн хамгаалалтыг аймгуудын байгаль орчны газрууд хамтын гэрээгээр зохицуулах
2. Худаг усан хангамжийн ашиглалтыг сайжруулах замаар Чойрын Богд уулын орчны бүсийн булаг шандыг зэрлэг амьтад чөлөөлж өгөх
3. Өвлийн бэлчээрийг хашиж хамгаалах, малчдын хадлан тэжээлийн ургамал тарих санаачлагыг дэмжих замаар байгалийн бэлчээрийг хамгаалах

#### Мэрэгч амьтадтай тэмцэх, нутагшуулах ажлыг зохион байгуулах

Бэлчээр малын хөлөөр талхагдаж, ургамалжилтын бүрхэц багассанаар хөрсний температур нэмэгдэж мэрэгчид үржихэд таатай болохоос гадна тачир сийрэг ургамалтай газар тэдгээрийг сахиж агнадаг махчин амьтдыг хялбархан илрүүлж чаддаг учир биеэ сайн хамгаалж улмаар үржиж олширдог.

Бидний судалгааны хугацаанд үлийн цагаан оготно тархсан газруудад шилийн сар олуулаа байршиж байна. Иймд бэлчээр дэхь мэрэгч амьтдын тоо толгойг зохицуулах арга хэмжээг бэлчээрийн сайжруулах ажилтай уялдуулах, мэрэгчдийг зохицуулагч биологийн хүчин зүйлсийг дэмжих хэрэгтэй. Өөрөөр хэлбэл шилийн сар, идлэг шонхор, начин шонхор, талын сар, тарважи бүргэд, хярс үнэг зэрэг махчин амьтдын популяцийг дэмжих, эдгээр амьтдыг зүй бусаар хороох үйлдлийг таслан зогсоох нь зүйтэй.

Чойрын Богд болон Чингэлийн уулсад тарвага, янгир зэрэг амьтдыг нутагшуулах боломж харагдаж байна. Гэхдээ эдгээр амьтдыг нутагшуулахын өмнө тухайн газарт бэлчээр ашиглалтыг сайжруулах, байгаль хамгаалах нөхөрлөлүүдийг чадавхжуулах шаардлагатай.

#### Шувууд цахилгаан шугам мөргөх эрсдэлийг бууруулах

Цахилгааны шугамтай холбоотой шувуудын эрсдэлийг бууруулахын тулд аймгийн хэмжээнд одоо байгаа болон цаашид байгуулагдах цахилгаан дамжуулах шугам дээр шувуу хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг шаардах хэрэгтэй юм.

Шувуу утас мөргөхөөс сэргийлэх хялбар арга болох сэрэмжлүүлэгч тэмдэгийг зүүх билээ. Шон хооронд татсан утсанд нисэж байгаа шувуудад харагдахуйц сэрэмжлүүлэгч зүүлт хэрэглэх нь эрсдэлийг бууруулна. Зураг дээрх сэрэмжлүүлэгчийг шон хооронд 1-ийг байрлуулахад болно. Зарим сэрэмжлүүлэгч зүүлт шөнө гэрэлтдэг материалаар хийгдсэн байх тул шөнө нисэж байгаа шувуудад ач холбогдолтой.

Цахилгаан дамжуулах шугамын шонгийн хийц загварыг зөв сонгох нь шувуу үхүүлэх эрсдлээс сэргийлэх үндсэн зам юм. Монгол улсын аймаг сумдын хэмжээнд тавигдсан 15 кв цахилгаан дамжуулах шугамын хийц шувуудад аюултай болох нь батлагдсан тул энэ төрлийн хийцээс аль болох зайлсхийх ёстой.

Махчин шувууд шон дээр сууж амрах, шон дээрээс ангуучлах, хэрээ шонхор, сар, элээ зэрэг шувууд шон дээр үүр засах зэргээр цахилгаанд цохиулах эрсдэлүүд нэмэгддэг. Шувуу цахилгаанд цохиулах эрсдэлээс сэргийлэхийн тулд:

4. Шувуу үүрлэхээс сэргийлэх ажлыг шувууны үржлийн үе буюу IV-VI саруудад зохион байгуулах

5. Дэд станц, трансформаторуудыг том шувуу орохоос сэргийлж тороор хамгаалах

Хууль бус агнууртай тэмцэх, нөхөрлөлийг бэхжүүлэх

Зэрлэг амьтдыг хамгаалах хүний нөөц болон санхүүгийн чадавх сул байдлаас шалтгаалан хулгайн агнуурыг таслан зогсоож чаддаггүй. Хулгайн агнуурыг таслан зогсоох төрийн байгууллагын ачааллыг бууруулах арга зам бол агнуурын бүс нутгийг эзэн хариуцагчтай болгох арга хэмжээ юм.

Говьсүмбэр аймагт агнуурын бүс нутаг болон байгаль хамгаалах нөхөрлөлүүд байгуулагдсан нь зэрлэг амьтдын тархац нутаг эзэн хариуцагчтай болохын эхлэл болжээ.

Хулгайн агнууртай тэмцэх зардлыг бууруулахын тулд орон нутгийн байгаль хамгаалах нөхөрлөлүүдийг дэмжих, тэдний үйл ажиллагааг бэхжүүлэх хэрэгтэй. Үүний тулд:

- Бэлчээр ашиглалтын сайн менежментийг нөхөрлөлүүдэд нэвтрүүлэх, улмаар бэлчээр ашиглалтын давуу эрхийг тэдэнд олгох
- Хулгайн агнуурыг илрүүлсний урамшууллыг зохих хувийг нөхөрлөлийн гишүүдэд олгох
- Зэрлэг амьтдыг нутагшуулах, үржүүлэх ажлыг нөхөрлөлүүдэд түшиглэн зохион байгуулах
- Нөхөрлөлийн гишүүдийг байгаль, зэрлэг амьтан хамгаалах сургалтад хамруулах зэрэг ажлуудыг зохион байгуулж болохоор байна.

Зэрлэг амьтдыг авто тээврийн хөдөлгөөнөөс хамгаалах

Автомашин хөдөлгөөнтэй холбоотой зэрлэг амьтдын эрсдлийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Үүнд:

- Чойр хот-Шивээ Овоо хүртэлх төв зам дагуу хурд сааруулах анхааруулах самбар байрлуулах
- Төмөр замын хашаан доторх өвсийг хадах, шатаах замаар зээрийн сүрэг төмөр замруу орох шалтгааныг арилгах
- Машинд дайруулсан сэг зэмийг замаас холдуулах
- Зэрлэг амьтдын осол эндэгдлийг бүртгэх, улмаар хамгийн их осол эндэгдэл гардаг цэгүүдийг тодорхойлж зам дээр хурд сааруулагч тавих арга хэмжээ үр дүнтэй байх болно.

## Хүснэгт 72. Сүмбэр сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгах арга хэмжээний саналын товчоо

№	Иргэдээс гарсан саналууд	Саналын тоо	БИНХ-ын санал
1.	Худаг усыг нэмэх, шинээр гаргах /хөдөөд/	15	54
2.	Байгалийн дурсгалт газруудыг хамгаалах, тохижуулах, эзэнжүүлэх	61	
3	Үлийн цагаан оготоно устгах	72	54
4	Гэр хорооллыг орон сууцжуулах	9	0
5	Аялал жуулчлалын бааз байгуулах	9	0
6	Дугуйн зам хийх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замтай болох	25	43
7	Малын түүхий эд боловсруулах үйлдвэр барих	45	
8	Гар худаг сэргээн засварлах	69	27
9	Хадлангийн нөөц газар бий болгох хашиж хамгаалах	12	42
10	Жижиг дунд үйлдвэр байгуулах	11	0
11	Тавилгын үйлдвэр барих	2	0
12	Байгаль орчны нөхөн сэргээх	50	219
13	Ногоон байгууламж байгуулах, мод, бут,сөөг тарих, хамгаалах	60	219
14	Гэр хороололд шинээр тоглоомын талбай байгуулах, хуучин тоглоомыг засварлах	178	14
15	Байгаль орчны боловсрол олгох	47	219
16	Усан сан цөөрөм байгуулах	60	
17	Тэрэгтийн төв усан сангийн хүчин чадлыг нэмэх	55	
18	5 га газар малын тэжээл тарих /эрдэнэшиш, овьёос/	45	

## Наймдугаар бүлэг. ГАЗАР, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ЗҮЙ ЁСНЫ ЭРХ, ТҮҮНИЙГ БҮРТГЭН БАТАЛГААЖУУЛАХ

Газрын асуудал хөгжил дэвшилд голлох үүрэгтэй гэдэг үүднээс газар, байгалийн нөөцийн зүй ёсны эрх нь нөөцийг эзэмших, тэгш эрхтэйгээр ашиглах, хүртэх явдлыг хөхүүлэн дэмжих замаар ядуурлыг бууруулах дэлхийн нийтийн болон үндэсний хэмжээний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Газар, байгалийн нөөцийг хүмүүс, нутгийн иргэд болон бусад хэрэглэгчдэд хүртээмжтэй болгох асуудлыг байгалийн нөөцийн эдэлбэрийн системүүдээр дамжуулан тодорхойлж зохицуулдаг. Эдгээр эдэлбэрийн системийн дагуу хэн ямар нөөцийг, хэдий хугацаагаар, ямар нөхцөлтэйгээр ашиглаж болохыг тодорхойлдог. Эдэлбэрийн системүүд нь батлагдсан бодлого, хуулиуд болон бичигдээгүй хууль, тухайлбал ёс заншил, бодит амьдрал дээр үндэслэсэн байж болно. Эдэлбэрийн эрх хангалтгүй, баталгаагүй байгаа нь эмзэг байдал, өлсгөлөн, ядуурлыг нэмэгдүүлж, байгалийн нөөцийн эзэмшлийн төлөөх өрсөлдөөнийг зөрчилдөөн болгон хувиргаж, байгаль орчны доройтолд хүргэх нөхцлийг бүрдүүлж байна.

Газар, байгалийн нөөцийн зүй ёсны эрхийн үндсэн зарчим

1. Зүй ёсны эрх эзэмшигчид, тэдний эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэнэ. Албан ёсны бүртгэлтэй эсэхээс үл хамааран зүй ёсны эрх эзэмшигчид болон тэдний эрхийг тодорхойлж, бүртгэн, хүндэтгэх талаар болон бусдын эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх хэрэгтэй.
2. Зүй ёсны эрхийг элдэв аюул занал, зөрчлөөс хамгаална.
3. Зүй ёсны эрхээ эдлэх явдлыг дэмжиж боломжоор хангана.
4. Зүй ёсны эрхийн зөрчлийг шүүхээр шийдвэрлүүлэх боломжоор хангана.
5. Эрхийн маргаан, хүч хэрэглэсэн мөргөлдөөн, авилгаас урьдчилан сэргийлнэ.

Сүмбэр сумын хувьд газар, байгалийн нөөцийн зүй ёсны эрхийн дараах төрлүүд байна. Үүнд:

- Бэлчээр ашиглах /уламжлалт эрх/
- Эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх
- Хадлан бэлтгэх
- Сүмбэр үүлдрийн каракуль хонь үржүүлэх

- Худаг эзэмших
- Хөв цөөрөм ашиглах гэх мэт төрлүүд байна гэж судалгааны явцад тодорхойллоо.

## Хүснэгт 73. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах зүй ёсны эрх

№	Бэлчээр ашиглалтын хэсгийн нэр	Нийт талбайн хэмжээ /га/	Өрхийн тоо	Малын тоо	Зүй ёсны эрхийн төрөл	
<b>Төвш баг</b>						
1	1-р хэсэг	8631	6 өрх	2576	Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах	
2	2-р хэсэг	11331	8 өрх	2921		
3	3-р хэсэг	12652	7 өрх	6461		
4	4-р хэсэг	13693	8 өрх	3510		
5	5-р хэсэг	16839	13 өрх	8562		
6	7-р хэсэг	15269	10 өрх	7521		
7	6-р хэсэг	16004	13 өрх	8207		
<b>Уулзвар баг</b>						
8	1-р хэсэг	11171	10 өрх	7092		
9	2-р хэсэг	13578	8 өрх	13129		
10	3-р бүлэг	13129	11 өрх	4220		
11	4-р бүлэг	13921	9 өрх	6912		
12	5-р бүлэг	9656	7 өрх	1787		
13	6-р бүлэг	10308	10 өрх	10837		
14	7-р хэсэг	12868	13 өрх	8519		
15	8-р хэсэг	8174	8 өрх	4157		
16	9-р хэсэг	14611	9 өрх	10273		
<b>Малах баг</b>						
17	1-р хэсэг	10317	7 өрх	5292		
18	2-р хэсэг	9582	5 өрх	4924		
19	3-р хэсэг	12688	8 өрх	4297		
20	4-р хэсэг	17731	12 өрх	6610		
21	5-р хэсэг	11157	9 өрх	4033		
22	6-р хэсэг	15260	8 өрх	5191		
23	7-р хэсэг	10896	7 өрх	4405		



### ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

- Говьсүмбэр аймаг нь говийн тариалангийн бүсэд хамаардаг бөгөөд байгаль цаг уурын онцлог нөхцлөөс шалтгаалж усалгаатай газар тариаланг хөгжүүлэхэд илүүтэй анхаарвал зохино.
- Говьсүмбэр аймгийн хүн амын өсөлт, хүнсний хэрэгцээнээс дүгнэлт хийхэд хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, боловсруулах, ханган нийлүүлэх үйл ажиллагааг уялдуулан эрчимтэй хөгжүүлэх асуудлыг дэвшүүлж байна. Иймээс агропаркийн цогцолборыг зохистой байгуулахын тулд бодлогоор дэмжин иргэд, аж ахуйн нэгж, байгууллага болон гадаад, дотоодын төсөл арга хэмжээ, зээл тусламжтайгаар зохион байгуулах нь зүйтэй.
- Усалгаатай газар тариалан эрхлэлтийг дэмжиж усалгааны худгийн цахилгааны зардлыг хөнгөлөх, чөлөөлөх, бүтээгдэхүүн борлуулсан зардлаас төлүүлэх /дараа төлбөрт ашиглалт/ гэх зэрэг урамшууллыг бодлогоор дэмжих нь зүйтэй байна.
- Малчид өвөлжөө, хаваржааныхаа ойр орчимд таримал хадлан бий болгож гаднаас үнээр худалдаж авалгүй өөрсдийн хэрэгцээгээ хангах боломжтой.
- Сүмбэр сумын бэлчээрийн даац дунджаар 7.6 дахин хэтэрсэн ба үүнээс 4-р баг 6 дахин, 5-р баг 7.2 дахин, 6-р баг 9.3 дахин даацыг хэтрүүлэн ашиглаж байна. Үүнээс харахад цаашид Сүмбэр суман дахь аймаг дундын отрын бэлчээрт мал оторлуулах, өөр аймаг сумын мал оруулах боломжгүй болсон байна.
- Дунд зэргийн талхагдалд орсон бэлчээрийн газрыг 3 жил дараалан ургамлан нөмрөг сэргэтэл ургалтын хугацаанд ашиглалтаас чөлөөлөх.
- Хүчтэй талхагдалд орсон бэлчээрийн идэмж сайтай үндсэн зүйл ургамлууд бараг устаж үгүй болсон тул эргэн сэргэхдээ удаан 10-аад жил шаардагдана. 3 жил дараалан ургалтын хугацаанд ашиглалтаас чөлөөлөх. Ачааллыг боломжит даацаас 15 хувиар багаар тооцон 2 жил дараалан ургамал ургалтын хугацаанд ашиглах. Ахин 3 жилээр ургалтын хугацаанд ашиглалтаас чөлөөлөх. Малын тоог боломжит даацаас 15 хувиар багаар тооцон ахин 2 жил дараалан ургамлан нөмрөг сэргэтэл ургамал ургалтын хугацаанд ашиглах нь зүйтэй.
- Бэлчээрийг зөв зохион байгуулалттай, дэс дараатай ашиглуулахын тулд бэлчээр ашиглах улирлыг 4 биш, 6-аар тогтоох нь чухал юм.
- Малчид, орон нутгийн удирдлагууд цөлжихөөс урьдчилан сэргийлж дэрстэй бэлчээрийг сэлгэж ашиглах, хашиж хамгаалах арга хэмжээ авах нь нэн чухал.
- Говьсүмбэр аймаг нь тал хээрийн бүсэд багтах бөгөөд өвөлжөө, хаваржааны доорх газрыг 0.1-0.4 га-аар эзэмшүүлэх нь тохиромжтой хэмжээ юм.
- Бэлчээр зохион байгуулалтыг малын төрөл, тоо толгой, бэлчээрийн онцлог байдал, даац ашиглалт, ургамлын сэргэн ургах чадвар зэргийг харгалзан малчидтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр хийх,

- Бэлчээрийн газрыг улирлаар, сар өдрөөр хэзээ хаана, ямар төрлийн малыг, хэр хугацаатай бэлчээрлүүлэх хуваарь гаргах, эхний удаа ашигласан бэлчээрийг 25-30 хоногийн дараа хэнз ногоо идүүлж байхаар тохируулж бэлчээрийн эргэлтийг тогтоох,
- Өвөл, хаврын бэлчээрийг эртнээс нөөцөлж түүнийг холын болон ойрын бэлчээр гэсэн 2 хэсэгт хуваан ашиглах.
- Холын бэлчээр нь өвөлжөө, хаваржааны эзэмшил бэлчээрт хамгийн алсын бэлчээр бөгөөд мал тарган, хээл нь хүндрээгүй үед буюу өдрийн урт, цаг агаар дулаан үед гаднаас нь дотогшлуулах замаар ашиглахад тохиромжтой.
- Ойрын бэлчээр нь өвөлжөө, хаваржааны дэргэд хамгийн ойр нөөцөлсөн бэлчээр байх учраас цагийн хүнд нөхцөлд мал тарга хүчээ алдаж сульдаж турж эцсэн юмуу хээл нь томорч хүндэрсэн мал төллөж байгаа үед л ашиглах нь зүйтэй.
- Зун, намрын улиралд отрыг алс хол соргог сэрмүүн бэлчээрт хийх нь бэлчээр ашиглалтыг сайжруулан өвөл, хаврын бэлчээрээ хамгаалах ач холбогдолтой байдгийг анхаарах.
- Бэлчээр усжуулалтыг сайжруулах, эвдэрсэн худаг усыг засч сэлбэх, эзэмшилтэй болгох.
- Нэгэнт талхлагдсан бэлчээрийг наад зах нь 2-3 жил ашиглахгүйгээр өнжөөх, тусгайлан хамгаалж хүний үйл ажиллагаагаар болон байгалийн аясаар нөхөн сэргээх, мөн бэлчээрийг услах, бордох, хөрсийг хагалалгүйгээр сэндийлэх, дов сондуулыг хэрчих, тэгшлэх, олон наст ургамлын үр нэмэрлэн тарих зэргээр сайжруулах, таримал бэлчээр, хадлан бий болгох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх.
- Малыг нэг дор хэт олноор бөөгнөрүүлэхгүй байх, бэлчээрийн даацыг тохируулах.
- Бэлчээрийн газрыг мал бүхий иргэдэд гэрээгээр ашиглуулан бэлчээр ашиглалтанд байнгын хяналт тавьж ажиллах.
- Байгалийн болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах
- Сумын төвийн ойр орчинд говийн нөхцөлд элсэрхэг хөрсөнд ургах боломжтой хайлаас, улиас болон бусад мод сөөг, өвслөг ургамлыг тарьж, ногоон бүс байгуулахад сумын иргэд, хүүхэд залуучуудыг идэвхитэй оролцуулах, элсний нүүлтгээс хамгаалах.
- Мал маллагааны уламжлалаа сэргээж, бэлчээрийг сэлгэн ашиглах, нүүдлийн давтамжийг нэмэгдүүлэх, уст цэгийг шинээр буй болгох, эвдэрсэн худгийг засварлан ашиглах зэрэг арга хэмжээг авч бэлчээр талхлахаас сэргийлэх нь зүйтэй.
- Чойр хот нь 4 аймгийн 10 гаруй сумдтай хиллэдэг. Говь хээрийн бүс оршдог, газар тариалан, төмс, хүнсний ногоо тариалах, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх хөрс ургамлын таатай орчинтой.

- Чойр хот ирээдүйд томоохон хот суурин болон хөгжиж хотжилт эрчимтэй өсөх бүрэн боломжтой тул эрчимжсэн болон хагас эрчимжсэн фермерийн аж ахуй хөгжүүлэх хэрэгтэй.
- Цаашид нутгийн малын чанарыг сайжруулах, Сүмбэр үүлдрийн каракул хонины удмын санг хамгаалан тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор зохих арга хэмжээ авах, бодлогоор дэмжих үйл ажиллагааг нэн даруй хийх нь зүйтэй байна.
- Үйлдвэрлэл үйлчилгээний болон ахуйн хог хаягдлыг ялгах, дахин боловсруулах бага оврын үйлдвэр байгуулах хэрэгтэй.
- Барилгын материал үйлдвэрлэлийн цогцолборыг Сүмбэр сумын 4-р багийн нутагт 30 га талбайд байгуулж, 9 км урт төмөр зам тавьж ашиглахаар тусгалаа.
- Сүмбэр сумын 4-р багийн нутагт Хүрий ногоон гэдэг газарт эмчилгээний шавар бүхий жижиг хэмжээний нуур байдаг ба энэ газрыг түшиглүүлэн эмчилгээний шавран сувиллын газар нээх нь зүйтэй юм.
- Тус аймагт барилгын үйлдвэрлэл явуулах, Говьсүмбэр, Дундговь аймгийн нутгийг дамжих орших Хараатын ураны хүдрийг ашиглах, олборлох, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн нүүрс химийн үйлдвэр байгуулж керолин, кокс, шингэн болон бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортлох бололцоотой юм.
- Нефть хангамжийн хувьд Өмнөговь, Дундговь, Сүхбаатар, Хэнтий аймгуудыг шатахуунаар хангахад хүрэлцэхүйц шатах, тослох, материал агуулах тээвэрлэх боломжтой.
- Өндөр хүчин чадалтай шугамыг газар доогуур аюул осол багатайгаар байршуулахаар хот байгуулалтын хэсэгчилсэн төлөвлөгөөнд тусгах хэрэгтэй.
- Суурьшлын бүсэд дэвсгэр зураг, ерөнхий төлөвлөгөө хийлгэх, улаан шугам тавих, инженерийн болон нийгмийн дэд бүтэц бий болгох хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж, улсын төвлөрсөн төсөв, орон нутгийн төсөвт бие даасан байдлаар тусгуулах ажлыг зохион байгуулан хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.
- Сүмбэр сумын 5-р багийн нутаг дах Уулзварын гол, Хүхээгийн гол, Хулгарын гол, Өгөөмөрийн гол, 4-р багийн нутаг дах Гашууны голуудаас тус бүр хоёр тийш онцгой хамгаалалтын бүсийг 50 метрт татаж, уг зурвас дотор аливаа ашиглалтыг хязгаарлаж, өвөлжөө бууц барихгүй байх зэрэг арга хэмжээ авах хэрэгтэй. Мөн Уулзварын голын эх авдаг Асгана булгийн ундаргыг малын хөлд дарагдахаас урьдчилан сэргийлж хашаа, хайс барьж хамгаалах арга хэмжээ авах нь зүйтэй байна.
- Нуурыг зорин ирж буй амрагч, аялагчдын аюулгүй байдал болон газрын гадаргын элэгдлийг тэлэхгүй байх үүднээс жалгаар ус урсах ёроол хэсгийг бетоноор доторлож, цаашид усанд идэгдэж гүнзгийрэхээс хамгаалах, жалгын эргийн нуралтаас урьдчилэн сэргийлэх арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Малах отрын бүс нутгийн Говьсүмбэр аймаг дах талбайгаас нийт 22592 га нь хүчтэй талхагдсан, 5173 га нь сул талхагдалд орсон байна. Иймээс сул талхагдсан бэлчээрийг улирал, сараар сэлгэн ашиглах, түүнчлэн хүчтэй талхагдсан бэлчээрийг ашиглалтаас хэсэг хугацааны турш бүрэн чөлөөлөх шаардлагатай байна.
- Отрын бэлчээрийн даац 2-6 дахин хэтэрсэн, нийт талбайн 50 хувь нь хүчтэй талхагдалд орсон, нутгийн уугуул малчдын тусгай хэрэгцээнээс гаргах хүсэлт зэрэг шалтгааны улмаас Малах отрын нөөц нутгийг улсын тусгай хэрэгцээний газраас гаргах саналыг дэмжиж төлөвлөгөөнд тусгалаа.
- Цоорхойн рашаан нь ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд орсон тул тусгай зөвшөөрлийн талбайгаас гаргах ажлыг зохион байгуулсаны дараа орон нутгийн тусгай хамгаалалтад авах нь зүйтэй.

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

- “Газар тариалангийн цогцолбор аж ахуй байгуулах төсөл” УБ, 2016 он
- “Говьсүмбэр аймгийн Байгаль орчины төлөв байдлын тайлан 2014-2015он” 2017 он
- “Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын иргэдийн оролцоотой газар ашиглалтын судалгаа, төлөвлөлт” 2005он
- Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт барих “АЙДИНЕР ГЛОБАЛ” ХХК-ны 50.0 мвт-ын САЛХИН ПАРК” төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотголын тайлан
- Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Баянбулагийн хөв ажлын гүйцэтгэлийн тайлан” УБ, 2010он
- Говьсүмбэр аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тайлан, 2005 он
- “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” УБ, 2011 он
- Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм
- Монгол улсын стандарт MNS 4652-28
- Монгол улсын стандарт MNS 4628-98 “Шатахуун түгээх станц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага” УБ, 1998 он
- “Харилцаа холбооны тухай хууль”, Засгийн газрын 2001 оны 263 дугаар тогтоол
- "Авто замын тухай хууль"-ийн 12.2 зүйл
- “Ойн тухай хууль” 2012 оны 5-р сарын 17
- “Аялал жуулчлалын тухай хууль” 2000 оны 5-р сарын 5
- “Иргэдийн оролцоотой газар ашиглалтын төлөвлөлт” УБ, 2006 он
- “Бэлчээр хадлангийн газрыг сайжруулах арга, тэжээлийн таримлын төрөл, сортууд” УБ, 2012он
- “Монгол малын зарим өвчин, сэргийлэх арга зам” УБ, 2017он
- “Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй” УБ, 2005он